

ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ

АГРОЭКОЛОГИЙН СУРГУУЛЬ

**ИХ ГАЗРЫН ЧУЛУУНЫ БАЙГАЛИЙН
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
НӨӨЦ, ДААЦЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Захиалагч байгууллага: Их Газрын Чулууны Байгалийн Цогцолборт
Газрын Хамгаалалтын Захиргаа

Гүйцэтгэгч: Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Агроэкологийн Сургууль

Улаанбаатар хот

2021 он

Захиалгат ажлын нэр: Их Газрын Чулууны Байгалийн Цогцолборт Газрын аялал жуулчлалын нөөц, даацын судалгаа

Хугацаа: 2021 он

Захиалагч байгууллага: Их Газрын Чулууны Байгалийн Цогцолборт Газрын Хамгаалалтын Захиргаа

Гүйцэтгэгч байгууллага: Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Агроэкологийн Сургууль

Удирдагч: М.Уянга (ХААИС-ийн АЭС-ийн Экологийн тэнхимийн аялал жуулчлалын багш, докторант)

Гүйцэтгэгчид: Б.Баасаннамжий (ХААИС-ийн АЭС-ийн Экологийн тэнхимийн аялал жуулчлалын багш, докторант)

Н.Сарангарав (ХААИС-ийн АЭС-ийн Экологийн тэнхимийн аялал жуулчлалын багш, докторант)

Б.Сэр-Од (ХААИС-ийн АЭС-ийн Газрын менежментийн тэнхимийн багш, докторант)

У.Уранцэцэг (ХААИС-ийн АЭС-ийн байгалийн аялал жуулчлалын 4-р курсийн оюутан)

АГУУЛГА

ОРШИЛ.....	v
ХҮСНЭГТ.....	vi
ЗУРАГ	viii
ТОВЧИЛСОН ҮГ.....	ix
НӨГДҮГЭЭР БҮЛЭГ.....	1
ИХ ГАЗРЫН ЧУЛУУНЫ БЦГ-ЫН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	1
1.1. Байгаль, газар зүйн нөхцөл	1
1.1.1. Газар зүйн байрлал.....	1
1.1.2. Хотгор гүдгэрийн онцлог	1
1.1.3. Ландшафтын хэв шинж	1
1.1.4. Геологийн тогтоц	2
1.1.5. Уур амьсгал	2
1.1.6. Гадаргын ус	2
1.1.7. Хөрсөн бүрхэвч	3
1.1.8. Амьтны аймаг	3
1.1.9. Ургамлын аймаг	4
1.2. Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал	5
1.2.1. Хүн ам	5
1.2.2. Мал аж ахуй.....	6
1.2.3. Харилцаа холбоо, дэд бүтэц.....	6
1.3. Их Газрын Чулууны БЦГ-ын дотоод бүсчлэл.....	7
1.4. Аялал жуулчлалын өнөөгийн байдал.....	9
ХОЁРДУГААР БҮЛЭГ.....	15
ИХ ГАЗРЫН ЧУЛУУНЫ БЦГ-ЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨӨЦ, ДААЦЫН СУДАЛГАА	15
2.1. Их Газрын Чулууны БЦГ-ын аялал жуулчлалын суурь нөөцүүдийн судалгаа.....	15
2.1.1. Амралт сувилал, аялал жуулчлалын газар зүйн мужлал.....	15
2.1.2. Аялал жуулчлалын байгалийн нөөц.....	15
2.1.3. Аялал жуулчлалын түүх, соёлын нөөц	18
2.1.4. Үйл явдал, эвент.....	20
2.2. Аялал жуулчлалын даацыг тогтоох арга зүй.....	20
2.2.1. Ландшафт, газрын бүрхэвчийн ангилал, түүний өөрчлөлтийн үнэлгээ хийсэн арга зүй.....	20
2.2.2. Хүний үйл ажиллагааны нөлөөллийн үнэлгээ хийсэн арга зүй.....	21
2.2.3. Байгалийн ландшафтын эрсдэлийн үнэлгээ хийсэн арга зүй	22
2.2.4. Аялал жуулчлалын даацыг хүрээлэн буй орчин, нийгэм-хүн ам зүйн, улс төр- эдийн засгийн үзүүлэлтээр үнэлсэн үнэлгээ хийсэн арга зүй.....	25
2.2.5. Аялал жуулчлалын даац тогтоосон арга зүй	26

2.2.6.	Рекреацийн нөхцөлийн тааламжийн үнэлгээ хийсэн арга зүй.....	27
2.2.7.	Аялал-рекреацийн чадавхын нэгдсэн үнэлгээ хийсэн арга зүй.....	28
2.3.	Их Газрын Чулууны БЦГ-ын аялал жуулчлалын нөөц, даацын үнэлгээ.....	31
2.3.1.	Ландшафт, газрын бүрхэвчийн ангилал, түүний өөрчлөлтийн үнэлгээ	31
2.3.2.	Хүний үйл ажиллагааны нөлөөллийн үнэлгээ	33
2.3.3.	Байгалийн ландшафтын иж бүрдлийн эрсдэлийн үнэлгээ.....	37
2.3.4.	Аялал жуулчлалын даацыг хүрээлэн буй орчин, нийгэм-хүн ам зүйн, улс төр- эдийн засгийн үзүүлэлтээр үнэлсэн үнэлгээ	41
2.3.5.	Аялал жуулчлалын даац тогтоох	42
2.3.6.	Рекреацийн нөхцөлийн тааламжийн үнэлгээ	44
2.3.7.	Аялал-рекреацийн чадавхын нэгдсэн үнэлгээ.....	45
	ГУРАВДУГААР БҮЛЭГ.....	55
	ИХ ГАЗРЫН ЧУЛУУНЫ БЦГ-Т АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА, БАРИМТЛАХ БОДЛОГО, ЗӨВЛӨМЖ.....	55
3.1.	Их Газрын Чулууны БЦГ-т аялах аялагчдын хэв шинж, хэтийн төлөв.....	55
3.1.1.	Аялагч, жуулчдын зах зээлийн хэв шинж, эрэлт хэрэгцээ.....	55
3.1.2.	Их Газрын Чулууны БЦГ-т аялах аялагч, жуулчдын хэтийн төлөв.....	60
3.2.	Их Газрын Чулууны БЦГ-ын аялал жуулчлалыг хөгжүүлэх чадавх.....	62
3.2.1.	Аялагчдыг тогтвортой нэвтрүүлэх Хамгаалалтын Захиргааны хүний нөөцийн чадавх.....	62
3.2.2.	Хамгаалалтын захиргааны менежментийн чадавх.....	63
3.2.3.	Аялагч, жуулчдыг хүлээн авах байршуулах хэрэгслийн чадавх, зөвшөөрөгдөх дээд хэмжээ.....	65
3.3.	Их Газрын Чулууны БЦГ-ын аялал жуулчлалын нөөц, даацад үндэслэн аялал жуулчлал хөгжүүлэх боломж, зөвлөмж.....	67
3.3.1.	SWOT-АНР шинжилгээ.....	67
3.3.2.	Өрсөлдөгчийн шинжилгээ.....	70
3.3.3.	ТХГН-т нэвтрэх гадаад, дотоод жуулчдын тоо, орлого, зарлагыг тооцох аргачлал.....	71
3.3.4.	ТХГН-ийн нөөц, даацын онцлогийг харгалзан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний норм стандартыг тогтоох.....	75
3.3.5.	Цаашид хэрэгжүүлэх боломжтой, санал болгож буй аяллын хөтөлбөр, маршрут.....	78
3.3.6.	Их Газрын Чулууны БЦГ-т аялал жуулчлалыг түүний нөөц, даацад тохируулан хөгжүүлэхэд анхаарах зүйлс	93
3.3.7.	Рекреацийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах талаар өгөх зөвлөмж	94
	ДҮГНЭЛТ.....	96
	АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	98
	Хавсралт 1. Орон нутгийн иргэдээс авсан судалгааны үр дүн.....	99
	Хавсралт 2. Байгаль хамгаалагчдаас авсан санал асуулгын дүн.....	102
	Хавсралт 3. Дотоодын аялагч, жуулчдаас авсан судалгааны үр дүн	106

ОРШИЛ

Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт зүйлс болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсаж өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалах зорилгоор тодорхой нутаг дэвсгэрийг улсаас тусгай хамгаалалтад авдаг. 2020 оны байдлаар улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нийт хэмжээ 120 байршилд 32.8 сая га-д хүрч, Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 21 хувийг эзлэх болжээ. Үүнээс байгалийн цогцолборт газрын ангиллаар тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ улсын нийт нутаг дэвсгэрийн 8.6% буюу 13,496,402 га-г эзэлж байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт зохион байгуулагдах аялал жуулчлалын үйл ажиллагаа нь тухайн хамгаалалттай нутаг дэвсгэр болон орон нутаг, түүний оршин суугчдад эдийн засгийн үр өгөөж өгч, байгаль хамгаалах ажилд ихээхэн дэмжлэг болох боломжтой. Гэвч аялал жуулчлалын бүхий л төрлүүд байгаль орчинд ямар нэг нөлөөлөл үзүүлдэг тул аливаа уг хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалыг хэр хэмжээнд дэмжих болон хязгаарлах, түүний байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөс хэрхэн урьдчилан сэргийлэх, мөн нөлөөллийг бууруулах зэрэг асуудлыг тухайн нутаг дэвсгэрийн нөөц, даацад тулгуурлан тогтоох нь байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрийг хангахад чухал ач холбогдолтой.

Их Газрын Чулууны Байгалийн Цогцолборт Газрыг 2003 оны 06 сарын 19-ний УИХ-ын тогтоолоор байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авч, 2012 оны 05 сарын 23-ны өдрийн УИХ-ын 57 дугаар тогтоолоор байгалийн цогцолборт газар болгон ангиллыг өөрчилж, хилийн заагийг нь өргөжүүлсэн юм.

Тус цогцолборт газрын Хамгаалалтын захиргааг 2013 оны 11 дүгээр сард байгуулсан бөгөөд өнөөгийн байдлаар 13 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Их газрын чулуу уул нь Дундговь аймгийн 9 гайхамшгийн нэг ба сүүлийн жилүүдэд тус цогцолборт газрыг зорин ирэх гадаад, дотоодын жуулчдын тоо жил ирэх бүр нэмэгдсээр байна. 2019 оны байдлаар Их газрын чулууны байгалийн цогцолборт газар нь гадаадын 327, дотоодын 489 жуулчин хүлээн авсан бол 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор гадаадын жуулчид хүлээн аваагүй боловч дотоодын 1170 жуулчин хүлээн авсан байна. Энэ нь тус газрыг зорин очих дотоодын жуулчдын тоо өмнөх жилтэй харьцуулахад 2.3 дахин өссөнийг харуулж байна. Тиймээс тус хамгаалалттай нутаг дэвсгэрийн хамгаалалтад авсан үндсэн зорилгыг нь алдагдуулалгүйгээр тухайн газар нутгийн аялал жуулчлалын нөөц, байгаль орчны даацад тохируулан аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудал нь зайлшгүй судалж тогтоох ёстой чухал асуудлын нэг юм. Энэхүү судалгааны зорилго нь Их Газрын Чулууны байгалийн цогцолборт газарт аялал жуулчлалаас байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, байгалийн өөрөө нөхөн сэргэх чадвараас хүний нөлөөлөл давахгүй байх экологийн даацын дээд хязгаарыг тогтооход оршино.

Тус судалгаа нь Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын нөөц, даацыг үнэлж, аялал жуулчлалыг тогтвортойгоор хөгжүүлэх боломжийг бүрдүүлж байгаагаараа ач холбогдолтой.

Тайлан нь 3 бүлэг, 10 дэд бүлэг, 37 зураг, үүнээс хээрийн судалгааны үеэр авсан 9 фото зураг, тус судалгааны ажлын хүрээнд хийгдсэн 21 газрын зураг, 56 хүснэгт, 13 графикийг багтаасан нийт 105 хуудас бүхий судалгааны ажлын үр дүн юм.

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Их Газрын Чулууны БЦГ-ын захын цэгүүд.....	1
Хүснэгт 2. Зурвас замналын судалгаа.....	3
Хүснэгт 3. Их Газрын Чулууны БЦГ-т ургадаг зарим ховор ургамлууд.....	4
Хүснэгт 4. Их Газрын Чулууны БЦГ-ын орчны бүсийн өрх, хүн амын тоо	5
Хүснэгт 5. Малын тоо, толгой (2017-2020 он)	6
Хүснэгт 6. Их Газрын Чулууны БЦГ-ын дотоод бүсчлэлийн талбайн хэмжээ (га талбай)	7
Хүснэгт 7. Их Газрын Чулууны БЦГ-ын амьтан, ургамлын төрөл	16
Хүснэгт 8. Их Газрын Чулууны БЦГ-ын түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд, тэдгээрийн ангилал, байршил.....	18
Хүснэгт 9. Ландшафтын эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт.....	22
Хүснэгт 10. Аялал жуулчлалд гадаргын налууг харгалзах үзүүлэлтүүд.....	23
Хүснэгт 11. Хөрсний чанарын үнэлгээ	24
Хүснэгт 12. ТХГН-ийн нийгэм, эдийн засагт аялал жуулчлалын үзүүлэх нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүдийг үнэлэх аргачлал	26
Хүснэгт 13. Рекреацийн үйл ажиллагааг улирлын ялгаагаар үнэлэх үзүүлэлтүүд.....	27
Хүснэгт 14. Газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээний шатлал	29
Хүснэгт 15. Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын уур амьсгалын рекреацийн үнэлгээний шатлал.....	30
Хүснэгт 16. Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын ургамлын рекреацийн нөөцийн үнэлгээний шалгуур, шатлал	30
Хүснэгт 17. Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын амьтны рекреацийн нөөцийн үнэлгээний шалгуур, шатлал	31
Хүснэгт 18. Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын ландшафт-газрын бүрхэвчид гарсан өөрчлөлт.....	31
Хүснэгт 19. Их Газрын Чулуу БЦГ-ын газар ашиглалтын байдал.....	33
Хүснэгт 20. Их Газрын Чулууны БЦГ-ын хүний үйл ажиллагааны нөлөөлөл	33
Хүснэгт 21. Байгаль орчинд аялал жуулчлалаас үзүүлж буй сөрөг нөлөөлөл.....	37
Хүснэгт 22. Их Газрын Чулууны БЦГ-ын хөрсний чанарын үнэлгээ.....	37
Хүснэгт 23. Их Газрын Чулуу БЦГ-ын хөрсний механик бүрэлдэхүүний эрсдэлийн үнэлгээ ...	38
Хүснэгт 24. Их Газрын Чулууны БЦГ-ын ландшафтын эрсдэлийн газрын гадаргын налуугийн үнэлгээ.....	40
Хүснэгт 25. Хүрээлэн буй орчин, нийгэм-хүн ам зүйн, улс төр-эдийн засгийн үзүүлэлтээр сонгож авсан газруудын даацын үнэлгээ.....	41
Хүснэгт 26. Их Газрын Чулууны БЦГ-ын рекреацийн тааламжийн үнэлгээ	45
Хүснэгт 27. Их Газрын Чулууны БЦГ-ын хотгор, гүдгэрийн аялал, рекреацийн үнэлгээ.....	46
Хүснэгт 28. Их газрын чулууны БЦГ-ын уур амьсгалын аялал, рекреацийн үнэлгээ.....	48
Хүснэгт 29. Их Газрын Чулуу БЦГ-ын ургамалжлын рекреацийн үнэлгээ	48
Хүснэгт 30. Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын амьтны рекреацийн үнэлгээ.....	51
Хүснэгт 31. Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын ландшафтын рекреацийн чадавхын нэгдсэн үнэлгээ	53
Хүснэгт 32. Монголд ирсэн гадаадын жуулчдын сонирхдог зүйлс	61
Хүснэгт 33. Нийт жуулчдын тоог тэгшитгэлийн Х утгад шилжүүлсэн байдал.....	61
Хүснэгт 34. Маркетингийн чадавх	63
Хүснэгт 35. Үйлдвэрлэл, үйлчилгээний чадавх	63
Хүснэгт 36. Бүтээгдэхүүний чадавх	63
Хүснэгт 37. Менежментийн чадавх.....	64

Хүснэгт 38. Хүний нөөцийн чадавх	64
Хүснэгт 39. Санхүүгийн чадавх.....	64
Хүснэгт 40. Их Газрын Чулууны БЦГ-т байгуулах боломжтой жуулчны баазын хүчин чадал (жилээр)	65
Хүснэгт 41. ИГЧБЦГ-ын SWOT шинжилгээ.....	67
Хүснэгт 42. SWOT-АНР шинжилгээний үр дүн	68
Хүснэгт 43. СРМ матриц.....	70
Хүснэгт 44. Их Газрын Чулууны БЦГ-ын үйлчилгээ авсан нийт жуулчдын тоо (2021 оны 3-р улирал)	72
Хүснэгт 45. Их Газрын Чулууны БЦГ-ын аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа явуулсан нийт өдрийн тоо (2021 оны 3-р улирал).....	72
Хүснэгт 46. Их Газрын Чулууны БЦГ-ын дотоодын нэг жуулчинд ногдох аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын дундаж орлого (2021 оны 3-р улирал).....	74
Хүснэгт 47. Их Газрын Чулууны БЦГ-ын аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын ТХГН-д аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардал (2021 оны 3-р улирал)	74
Хүснэгт 48. Хүснэгт. Их Газрын Чулууны БЦГ-ын бүсүүдэд хөгжүүлэх үйл ажиллагааны чиглэл.....	75
Хүснэгт 49. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний стандарт, норм.....	76
Хүснэгт 50. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний эко стандартууд.....	77
Хүснэгт 51. Төлөвлөж буй маршрут 1	79
Хүснэгт 52. Төлөвлөж буй маршрут 2	79
Хүснэгт 53. Төлөвлөж буй маршрут 3	79
Хүснэгт 54. Төлөвлөж буй маршрут 4	80
Хүснэгт 55. Төлөвлөж буй маршрут 5	80
Хүснэгт 56. Төлөвлөж буй маршрут 6	80
Хүснэгт 57. Аяллын газрын зурагт тусгагдсан үзмэрийн тэмдэглээ, солбицол	87

ЗУРАГ

Зураг 1. Их Газрын Чулууны БЦГ дахь худгийн байршил	3
Зураг 2. Их Газрын Чулууны БЦГ-ын дотоод бүсчлэл.....	8
Зураг 3. Их Газрын Чулууны БЦГ дахь ердийн хөсөг болон авто машинтай аяллын батлагдсан маршрут 1	11
Зураг 4. Их Газрын Чулууны БЦГ дахь явган аяллын батлагдсан маршрут 2	12
Зураг 5. Амрах, отоглох цэг	13
Зураг 6. Ариун цэврийн байгууламж	13
Зураг 7. Түүх, соёлын дурсгалт зүйлсийн тэмдэглэгээ	13
Зураг 8. Явах чиглэл заасан тэмдэглэгээ	13
Зураг 9. Байгалийн өвөрмөц тогтоцын тэмдэглэгээ	14
Зураг 10. Их газрын чулуу уул руу орох, гарах хаалга	14
Зураг 11. 2018 оны агуйн судалгаагаар бүртгэгдсэн агуйн байршил.....	17
Зураг 12. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тархалтын зураг.....	19
Зураг 13. Их Газрын Чулууны БЦГ дахь Задгай театр	20
Зураг 14. Их Газрын Чулууны БЦГ-ын газрын бүрхэвч	32
Зураг 15. Их Газрын Чулууны БЦГ-ын бэлчээр ашиглалтын нөлөөлөл.....	34
Зураг 16. Их Газрын Чулууны БЦГ-ын авто замын нөлөөллийн зураг	35
Зураг 17. Их Газрын Чулууны БЦГ-ын хүний үйл ажиллагааны нэгдсэн нөлөөлөл.....	36
Зураг 18. Их Газрын Чулууны БЦГ-ын хөрсний механик бүрэлдэхүүний үнэлгээ.....	39
Зураг 19. Их Газрын Чулууны БЦГ-ын газрын гадаргын налуугийн үнэлгээ.....	40
Зураг 20. Их Газрын Чулууны БЦГ-ын хотгор, гүдгэрийн аялал рекреацийн үнэлгээ	47
Зураг 21. Их Газрын Чулууны БЦГ-ын уур амьсгалын аялал, рекреацийн чадавхын үнэлгээ ...	49
Зураг 22. Их Газрын Чулууны БЦГ-ын ургамалжилтын аялал рекреацийн чадавхын үнэлгээ ..	50
Зураг 23. Их Газрын Чулууны БЦГ-ын ан амьтдын аялал рекреацийн чадавхын үнэлгээ	52
Зураг 24. Их Газрын Чулууны БЦГ-ын ландшафт-рекреацийн нэгдсэн үнэлгээ.....	54
Зураг 25. Олон улсын аялал жуулчлалын 1950-2030 онд хүрэх төлөв байдал	60
Зураг 26. Stata программын тооцоолол.....	62
Зураг 27. Их Газрын Чулууны БЦГ дахь жуулчны баазын төлөвлөлт.....	66
Зураг 28. Төлөвлөж буй явган аяллын маршрутын зураг	81
Зураг 29. Төлөвлөж буй авто машинтай аяллын маршрут -1	82
Зураг 30. Төлөвлөж буй авто машинтай аяллын маршрут -2	83
Зураг 31. Төлөвлөж буй авто машинтай аяллын маршрут -3	84
Зураг 32. Төлөвлөж буй морин ба дугуйн аяллын маршрут	85
Зураг 33. Төлөвлөж буй морин аяллын маршрут.....	86
Зураг 34. Их Газрын Чулууны БЦГ-ын аялал жуулчлалын үзмэрүүд	89
Зураг 35. Их Газрын Чулууны БЦГ-ын “Аялал жуулчлалын I бүс”-д орших аялал жуулчлалын үзмэрүүд.....	90
Зураг 36. Их Газрын Чулууны БЦГ-ын “Аялал жуулчлалын II бүс”-д орших аялал жуулчлалын үзмэрүүд.....	91
Зураг 37. Их Газрын Чулууны БЦГ-ын “Аялал жуулчлалын III бүс”-д орших аялал жуулчлалын үзмэрүүд.....	92

ТОВЧИЛСОН ҮГ

ААНБ	аж ахуйн нэгж байгууллага
АЖ	аялал жуулчлал
АНУ	Америкийн нэгдсэн улс
АСАЖ	Амралт сувилал, аялал жуулчлал
БОАЖЯ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
БОНХАЖ	Байгаль Орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын Яам
БЦГ	Байгалийн Цогцолборт Газар
ГМС	газар зүйн мэдээллийн систем
ГХГЗЗГ	газрын харилцаа, геодез зураг зүйн газар
ДНХ	Дезоксирибо нуклейн хүчил
ЛХШ	Ландшафтын хэв шинж
НҮБХХ	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ТХГН	тусгай хамгаалалттай газар нутаг
УИХ	Улсын их хурал

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

ИХ ГАЗРЫН ЧУЛУУНЫ БЦГ-ЫН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

1.1.Байгаль, газар зүйн нөхцөл

1.1.1. Газар зүйн байрлал

Их газрын чулууны БЦГ нь Дундговь аймгийн төвөөс зүүн урагш 80 орчим км-т буюу хойд өргөргийн 45.76726 зүүн уртрагийн 107.24748-т байрладаг. Их газрын чулуу уул нь Говь-Угтаал, Гурвансайхан, Өлзийт сумдын нутгийн уулзварт уртаараа 30 орчим км, өргөөшөө 15 км сунаж тогтсон бол цогцолборт газрын хилийн урт нийтдээ 221 км, хойноосоо урагш 104.3 км, баруунаас зүүн тийш хамгийн өргөн хэсэгтээ 50.8 км үргэлжилнэ.

Хүснэгт 1. Их Газрын Чулууны БЦГ-ын захын цэгүүд

№	Захын цэгүүд	Өргөрөг	Уртраг
1	Урд захын цэг	45° 10' 53,599" N	107° 33' 46,960" E
2	Зүүн захын цэг	45° 48' 17,424" N	107° 24' 1,825" E
3	Баруун захын цэг	45° 33' 48,274" N	106° 56' 17,425" E
4	Хойд захын цэг	45° 56' 23,027" N	107° 10' 52,445" E

Байгалийн бүс бүслүүрийн хувьд хээрийн бүсийн урд хэсгээр хуурай хээрийн зурвас бүсэд оршдог. Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ нь 175.906 га.

1.1.2. Хотгор гүдгэрийн онцлог

Цогцолборт газрын гадаргад жигд ухаа гүвээт тал, нам уул, цав толгод зонхилох бөгөөд үнэмлэхүй өндөр нь 1150-1700 метрт хэлбэлзэнэ. Хамгийн өндөр цэг нь БЦГ-ын хойд хэсэгт орших Ерлөг уул (1706 м) бол хамгийн нам цэг нь цогцолборт газрын урд хэсэгт орших Хайрхан уул (1566 м) юм. Их газрын чулуу уул орчмын газрын гадарга нь уулс хоорондын цөлөрхөг хотгорт орших пермийн галавын настай цайвардуу ягаан өнгийн дунд ба жижиг ширхэгт боржин чулуунаас тогтсон нүцгэн цулдам хад чулуурхаг бөгөөд эргэн тойронд заримдаг цөлийн хөндий хоолой хүрээлдэг.

1.1.3. Ландшафтын хэв шинж

Их Газрын Чулууны БЦГ нь цөлөрхөг хээрийн бүсэд оршдог. Цогцолборт газрын нутаг дэвсгэрт жинхэнэ хуурай хээрийн ландшафт зонхилохын зэрэгцээ говь цөлийн нөлөөгөөр ургамлын бүрхэвчийн үндсэн бүрэлдэхүүнд цөлөрхөг хээрийн ургамал, элементүүд нэвтэрч ургамлын бүрхэц сийрэг болсон байна. Агь-үетэн-харганат хээр голлох суурийг эзэлдэг. Энд голдуу говийн ба сайрын хялгана, нангиад хазааргана, хуурайсаг сөөг, сөөгөнцрүүд зонхилж агь, ямаан ба шүлхий шарилж, цагаан ба бор шаваг, боролзой, таана, хөмүүл, буурал янгиц, бор эдгэнэ, өргөст ортууз, дэлхээ тогторгоно, орог тэсэг, ахар навчит баглуур, бунгийн ба улаан харгана, цулбуур өвс, хойрго хотор зэрэг говийн ургамал ургана. Нам хотос бүхий марз хужиртай газраар улаан, бор, шар бударгана, хармаг, таар, хуурайсаг сөөг сөөгөнцрүүд, жижиг үетэн зонхилон тархана.

1.1.4. Геологийн тогтоц


Геологийн тогтцын хувьд “Монголын их батолитын” зүүн сэжүүр буюу каледон, герциний болон Номхон далайн уул тогтох хөдөлгөөний үеийн боржин чулуу голлохын зэрэгцээ эрт төрмөлийн эриний девон, чулуун нүүрс, пермийн галавт үүссэн хувирмал занар, элсэн чулуу, мөлгөр хөрзөн, алевролит зэрэг тунамал чулуулаг, мөн боржин, гранодиорит зэрэг боржингийн төрлийн магмын чулуулаг түгээмэл тархсанаас гадна дөрөвдөгчийн хурдас багагүй бий. Мөн Их газрын чулуу нь усан болор, утаат болор, хаш, мана, хайлуур жонш, гиваан, төмөр, зэс, билүү, занар, шороон будаг гэх мэт эрдэс баялагтай.

1.1.5. Уур амьсгал

Эрс тэс, гандуу хуурай уур амьсгалтай. Уур амьсгалын гол үзүүлэлтийн нэг болох дулаан хангамжийн хувьд жилийн дундаж агаарын температур $+0.3 - +7.7^{\circ}\text{C}$ хэлбэлздэг бөгөөд цаашид 2030-аад оны үед $+1.6^{\circ}\text{C}$ -аар нэмэгдэх хандлагатай гэж судлаачид үзэж байна. Агаарын температур бүх нутгаар нэмэгдэж байгаа нь бүс нутгийн байгаль экологид сөргөөр нөлөөлж байна. Жилд дунджаар 130.1-193.8 мм хур тунадас унадаг. Жилд орж буй хур тунадасны 80 хувь нь дулааны улиралд унадаг.

1.1.6. Гадаргын ус

Жилд орох хур тунадасны хэмжээ бага, газрын доорх усны нөөц хязгаарлагдмал, байгалийн тэнцвэр харьцангуй багатай, усны хатуулаг, эрдэсжилт өндөртэй. Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргаатай хамтран 2018 оны 06 дүгээр сарын 20-аас 06-р сарын 22-ны өдрийн хооронд газрын гадаргын ус, уст цэгийн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулсан. Судалгаагаар нийт 115 худаг бүртгэгдсэнээс өрөмдмөл худаг-23, энгийн худаг-92, булаг шанд-7 байна. Усны эрдэсжилт нь шохойн чулуу, мергеля, доломит, гипс, чулуун давсны эрдсийн нөлөөнд хамаарагдаж байна (Зураг 1).



Зураг 1. Их Газрын Чулууны БЦГ дахь худгийн байршил

Гадаргын усны хувьд 6 булаг, 1 рашаан байдаг боловч эдгээр нь хур борооны усаар тэжээгддэг.

1.1.7. Хөрсөн бүрхэвч

Хөрсөн бүрхэвчийн хувьд цайвар хүрэн хөрс дагнан тархах бөгөөд өндөрлөг уулс, толгодтой хэсгээр хүрэн хөрс мэр сэр тааралдана. Механик бүрэлдэхүүнээр сайр чулуурхаг, хөнгөн шавранцар, элсэнцэр хөрс голлох бөгөөд ухаа гүвээний хоорондох хужир тойром бүхий хонхор, хотгор газраар хужир мараа, хужирлаг ба мараалаг цайвар хүрэн хөрс тогтворжсон байна. Тус нутагт тархсан хөрсний чадавх муу ба хөрсний чанарын суурь үнэлгээний дундаж балл Гурвансайхан сумын нутаг 16.0, Говь-Угтаал сумын нутагт 17.3 балл байна.

1.1.8. Амьтны аймаг

Амьтны аймгийн хувьд хойд говийн тойрогт хамаарч тухайн бүс нутагт тархсан хөхтөн амьтад амьдардаг. Цогцолборт газрын хамран орших Гурвансайхан, Говь-Угтаал, Өлзийт сумдын нутаг нь хөхтөн амьтны зүйлийн бүрэлдэхүүнээр баялаг ч энэ бүс нутагт хөхтөн амьтны тусгайлсан судалгаа бага хийгдсэн байдаг.

2014 онд Их Газрын Чулууны БЦГ-ын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн, байгаль хамгаалагчид цогцолборт газрын нутагт тархсан олон улсын улаан номд орсон аргаль хонь, янгир ямаа зэрэг амьтдын тархац нутагт ажиглалт судалгаа хийсний үр дүнд дээрх амьтдын гол тархац нутаг нь Их газрын чулуу уул, Ерлөг уул, Гурвансайхан уул, Үүдийн хяр, Тэвшийн хяр зэрэг газрууд болохыг тогтоожээ. Тус цогцолбор газарт 2009-2010 оны зуднаар аргаль, янгир цөөрч, бараг үгүй болсон байсан бол 2015-2018 оны хооронд хийсэн зурвас замналын судалгаагаар 728 бодгаль аргаль хонь, 318 бодгаль янгир ямаа бүртгэгдсэн байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Зурвас замналын судалгаа

№	Зүйлийн нэр	2015. 9 сар	2016 он	2017 он	2018 он	2020 он
1	Аргаль хонь	77 бодгаль	215 бодгаль	210 бодгаль	226 бодгаль	240 бодгаль
2	Янгир ямаа	36 бодгаль	46 бодгаль	107 бодгаль	129 бодгаль	130 бодгаль

Эх үүсвэр: Их Газрын Чулууны БЦГ-ын уулын туруутан амьтдын тооллого судалгаа 2020, замналын судалгаа 2015-2018

Түүнчлэн тус цогцолборт газар нь хуурай хээр, цөлжүү хээрийн бүсэд өргөн тархацтай бусад олон төрөл зүйлийн амьтдаар баян. Тухайлбал, алаг даага, хадны борогчин, монгол чичүүл, үхэр огдой зэрэг мэрэгчид, зараа, хонин гүрвэл, монгол гүрвэл, могой, хэвлээр явагчид, сахалт багваахай, жижиг соотон багваахай зэрэг гар далавчтан, тас, бүргэд, харцага, шонхор, занхгар занглай, ногтруу, эрээн хавирга, хээрийн тагтаа, ухаа дунхай, болжмор, хондон ангир, ооч ёл зэрэг жигүүртэн, аргаль, янгир, хар сүүлт, цагаан зээр, мануул мий, дорго, үнэг, хярс, тарвага, туулай, чоно зэрэг амьтад амьдардаг.

2000 оны дунд үе хүртэл энэ нутагт тарвага элбэгтэй байсан ба иргэдийн буруутай үйл ажиллагаанаас болж 2010 оноос хойш тус газарт тарвага үзэгдэх нь багасаж, ер нь бараг устаад байжээ. 2017 оноос хойш тус нутагт тарвага ганц нэг үзэгдэх болж, 2018 оноос Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас тарвага нутагшуулах төслийг хэрэгжүүлж байна.

1.1.9. Ургамлын аймаг

Их газрын чулууны БЦГ-т 34 овог, 97 төрөл, 156 зүйл ургамал ургадаг бөгөөд мөн Монгол орны улаан номд орсон цөлийн аргамжинцэцэг, ноосон шилбэт баглуур гэсэн 2 зүйл нэн ховор ургамал, пржевальскийн зээргэнэ, анхил сонгино, ацан ажигана, өргөст ортууз, дагуур хүж өвс, сибирь ерөндгөнө, шаргал шарилж гэсэн 7 зүйл ховор ургамал ургадаг. Ховор, ховордсон болон эмийн онцлог ургамлын гол тархац нутаг нь Их газрын чулууны уул, Ерлөг уул, Гурвансайхан уул, Үүдийн хяр, Тэвшийн хяр юм. Хазаар өвс, хялгана, таана, хүмүүл, бударгана зэрэг говь хээрийн бэлчээрийн ургамал зонхилж ургахаас гадна Ганга, Алтан гагнуур, гичгэнэ, хунчир, далайн түрүү зэрэг гучаад нэрийн эмийн ургамал ургадаг.

2018 онд тус цогцолборт газрын захиргаанаас “Ховор ургамлын тархалтын судалгаа”-г хийж шинэсэрхүү бударгана, анхил сонгино, дагуур хүж өвс гэсэн 3 төрлийн ховор ургамлын тархац байршлыг судлан тогтоосон байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Их Газрын Чулууны БЦГ-т ургадаг зарим ховор ургамлууд

№	Ургамлын нэр	Англи / Монгол нэршил			Аж ахуйн бүлэг	Идэмж, тэжээлийн ач холбогдол
		Овог	Төрөл	Зүйл		
1.	Шинэсэрхүү бударгана	Chenopodiaceae / Луультан	Salsola / Бударгана	Salsola laricifolia / шинэсэрхүү бударгана	Заримдаг сөөг	Эмийн үнэт ургамал
2.	Анхил сонгино	Alliaceae / Сонгинотон	Allium / Сонгино	Allium odorum / Анхил сонгино	Олон наст өвслөг ургамал	Малын тэжээл, хүнс, эмийн чухал түүхий эд
3.	Дагуур хүж өвс	Grossulariaceae / Тошлойтон	Haplophyllum / Хүж өвс	Haplophyllum dahuricum / Дагуур хүж өвс	Олон наст хагас сөөгөнцөр	Малын тэжээлийн ургамал

Эх үүсвэр: Их Газрын Чулууны БЦГ-ын Ховор ургамлын тархцын судалгаа, 2018

Шинэсэрхүү бударгана нь цогцолборт газрын Баруун Сайхан уул, Цахир Дэл, Майхан, Ширүүн хөтөл, Хороот цагаан, Шар хад, Дунд сайхан уул, Зүүн сайхан уул, Нарийн уулын хойд араар буюу бутрамтгай чулуурхаг, хайргархаг хажуу сайрын ирмэгээр тархсан байна. Мөн Баруун сайхан уулаас Ширүүн хөтөл хүртэл 12.22 км урт үргэлжилсэн бөгөөд хамгийн өргөн хэсэг нь Хороот цагаанаас Нарийн уул хүртэл 3.48 км өргөнтэй нийт 1856.81 га талбайг хамран ургаж байна. Цогцолборт газрын бүсээр авч үзвэл Онцгой “Б” бүсэд 1811.04 га, Аялал жуулчлалын “Г” бүсэд 45.77 га талбайд ургаж байна.

Анхил сонгино нь Их Газрын Чулууны БЦГ-ын Ерлөг Хайрханы хойд ар, Их газрын уул болон Агуйтын энгэр, “Уяхан замбуу тивийн наран” хөшөөний баруун урд, Задгай театрын зүүн талд нийт 685.94 га талбайд тархан ургаж байна. Цогцолборт газрын бүсээр авч үзвэл Онцгой “А” бүсэд 4.71 га, Аялал жуулчлалын “Г” бүсэд 542.12 га, Хязгаарлалтын бүсэд 139.11 га-г хамран ургаж байна.

Дагуур хүж өвс нь Их Газрын Чулууны БЦГ-ын Чулуун хороот, Баян уул, Ерлөг хайрханд их хэмжээгээр, Их газрын чулууны ууланд алаг цоог, хээрийн чулуурхаг хажуу, хайргархаг хажуу, бэл, асга, нурангид нийт 327.77 га талбайд тархан ургадаг. Цогцолборт газрын бүсээр авч үзвэл Онцгой “А” бүсэд 2.21 га, Аялал жуулчлалын “Г” бүсэд 325.56 га-г хамран ургаж байна.

Тус БЦГ нь бутлаг үетэнт хуурай хээрийн монгол хэв шинжийн чулуусаг алаг өвс-ботуульт бүлгэмдэлтэй хосолсон чулуусаг алаг өвс-хялганат (*Stipa krylovii*, *Arenaria capillaris*, *Arctogeron gramineum*, оржинтой газраар *Artemisia rullifolia*, *Caryopteris mongolica*), Бутлаг үетэнт ба заримдаг сөөгөнцөр-бутлаг үетэнт цөлжүү хээрийн хаяа уулс, тал уулс, тал газар, цав толгод, хотгорын говийн умард-монгол хэв шинжтэй хазаар өвс-хялганат, хялганат (*Stipa klemenzi*, *S.gopica*, *Cleistogenes squarrosa*, *Artemisia frigida*), заримдаг сөөгөнцөр-бутлаг үетэнт ба таанат цөлийн говийн умард хэв шинжтэй баглуур-хялганат, баглуур-таана-хялганат (*Stipa gopica*, *S.glareosa*, *Anabasis brevifolia*, *Allium polyrhizum*), чулуусаг алаг өвс-боролзой-хялганат (*Stipa gobica*, *S.glareosa*, *Anabasis brevifolia*, *Ajania fruticulosa*, *Zypoghyllum pterocarpum*), Дорноговийн хэв шинжтэй бор бударгана-хялганат (*Stipa glareosa*, *S gobica*, *Salsola passerina*), заримдаг сөөгөнцөрт ба сөөгт цөлийн говийн хэв шинжтэй өндөр загт (*Haloxylon ammodendron*) бүлгэмдэлтэй.

1.2. Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал

1.2.1. Хүн ам

Их Газрын Чулууны БЦГ нь засаг захиргааны хувьд Гурвансайхан сумын Элгэн, Гурвансайхан, Чулуут баг, Говь-Угтаал сумын Ажирхай баг, Өлзийт сумын Буян багийн нутаг дэвсгэрт харьяалагддаг. Тус гурван сумдад нийт 1952 өрхөд 6102 (2020 оны байдлаар, www.1212.mn) хүн ам оршин суудаг бөгөөд энэ нь Дундговь аймгийн нийт өрхийн 13.5%, хүн амын 12.9%-ийг эзэлж байна.

2018 оны байдлаар Их Газрын Чулууны БЦГ-ын нутаг дэвсгэр дээр тус сумдын 99 өрх оршин суудаг ба тэдгээрээс БЦГ-ын “Онцгой А бүс”-д оршин суугч байхгүй, “Онцгой Б бүс”-д 1 өрх, “Аялал жуулчлалын I дүгээр бүс”-д 20 өрх, “Аялал жуулчлалын II дугаар бүс”-д 7 өрх, “Аялал жуулчлалын III дугаар бүс”-д 12 өрх, “Хязгаарлалтын бүс”-д 59 өрх жилийн 4 улиралд нүүдэллэн амьдардаг байжээ (2018, Их Газрын Чулууны БЦГ-т нутагладаг өрх, малын тоо, байршлын судалгаа). Харин 2021 оны 9 сарын байдлаар цогцолборт газрын орчны бүсэд 21 өрх, хязгаарлалтын бүсэд 26 өрх, аялал жуулчлалын бүсэд 14 өрх нийт 61 өрхийн 205 иргэн оршин сууж байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Их Газрын Чулууны БЦГ-ын орчны бүсийн өрх, хүн амын тоо

№	СУМДЫН НЭР	Оршин сууж буй өрхийн тоо			Оршин сууж буй хүн амын тоо		
		Орчны бүс	Хязгаарлалтын бүс	Аялал жуулчлалын бүс	Орчны бүс	Хязгаарлалтын бүс	Аялал жуулчлалын бүс
1	Гурвансайхан	21	14	12	58	62	51
2	Говь-Угтаал	-	12	2	-	27	7
3	Өлзийт	-	-	-	-	-	-
	Нийт	21	26	14	58	89	58

Эх үүсвэр: Их Газрын Чулууны БЦГ-ын мэдээ

Тус цогцолборт газарт оршин суух хүн амын 83.4% нь Гурвансайхан сум, 16.6% нь Говь-Угтаал сумын иргэд байгаа бөгөөд Өлзийт сумын иргэд амьдардаггүй байна. Энэ нь цогцолборт газрын өмнөд багахан хэсэг Өлзийт суманд харьяалагддаг болон тэр хэсэгт зуншлага тааруу байдагтай холбоотой юм.

Ерөнхийдөө Их Газрын Чулууны БЦГ болон түүний орчны бүсэд оршин суудаг өрх, хүн амын тоог 2018 онтой харьцуулахад буурсан байгаа нь 2021 оны хавар болсон байгалийн гамшигт үзэгдэл болон зуншлага тааруу байсантай холбоотой хэмээн дүгнэж болох юм.

1.2.2. Мал аж ахуй

Гурвансайхан, Говь-Угтаал, Өлзийт сумд нь нийт 1629 малтай өрхтэй бөгөөд тэдний 61 өрх буюу 3.74% нь Их Газрын Чулууны БЦГ-т амьдардаг байна.

Их Газрын Чулууны БЦГ-ын Хамгаалалтын Захиргаанаас гаргаж өгсөн тайлан мэдээнээс харахад 2018 онд тус нутаг дэвсгэрт амьдардаг малтай өрхүүд нь нийт 47921 толгой малтай, үүнээс 402 нь тэмээ, 1667 нь адуу, 579 нь үхэр, 26236 нь хонь, 19037 нь ямаа байжээ (Их Газрын Чулууны БЦГ-ын тоон мэдээ, 2021).

Харин 2020 оны байдлаар нийт 51377 толгой мал тоологдсоноос харахад малын тоо толгой өмнөх онтой харьцуулахад 7%-иар өссөн байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Малын тоо, толгой (2017-2020 он)

Сумдын нэр	Малын төрөл	Малын тоо толгой											
		2017			2018			2019			2020		
		Орчны бүс	Хязгаарлалтын бүс	Аялал жуулчлалын бүс	Орчны бүс	Хязгаарлалтын бүс	Аялал жуулчлалын бүс	Орчны бүс	Хязгаарлалтын бүс	Аялал жуулчлалын бүс	Орчны бүс	Хязгаарлалтын бүс	Аялал жуулчлалын бүс
Гурван сайхан	Хонь	9347	6152	3378	12098	4091	3216	10342	6765	3189	10200	9073	4621
	Ямаа	4351	5055	2422	3961	6050	3618	4708	6217	3497	4605	7621	3470
	Үхэр	267	159	76	172	146	89	168	152	76	191	249	148
	Адуу	1638	313	46	699	413	50	542	434	69	480	504	87
	Тэмээ	269	19	31	295	33	34	242	38	57	238	40	72
Говь-Угтаал	Хонь	-	4637	835	-	5887	944	-	6683	1080	-	3465	904
	Ямаа	-	4424	666	-	4599	809	-	4972	819	-	3991	770
	Үхэр	-	100	87	-	94	78	-	110	67	-	92	34
	Адуу	-	432	109	-	396	109	-	411	112	-	406	79
	Тэмээ	-	32	3	-	35	5	-	45	3	-	35	2
Өлзийт	Хонь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Ямаа	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Үхэр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Адуу	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Тэмээ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт		15872	21323	7653	17225	21744	8952	16002	25827	8969	15714	25476	10187
ИГЧБЦГ-ын хэмжээнд		44848			47921			50798			51377		

Эх үүсвэр: Их Газрын Чулууны БЦГ-ын тоон мэдээ

1.2.3. Харилцаа холбоо, дэд бүтэц

Их Газрын Чулууны БЦГ-ын нутаг дэвсгэрээр Өмнөговь-Таван толгой чиглэлийн төв зам, Их газрын чулууны уул, Элгэн баг, Чойрын чиглэлийн төв замууд дайран өнгөрдөг бөгөөд Юнител, Мобикомын үүрэн утасны сүлжээтэй, Ж-мобайл, Скайтел компанийн суурин утасны сүлжээтэй.

1.3. Их Газрын Чулууны БЦГ-ын дотоод бүсчлэл

Дархан цаазат газар, Байгалийн цогцолборт газрууд нь харьцангуй том хэмжээний нутгийг хамардаг тул аж ахуйн ашиглалтын үйл ажиллагаатай зөрчилдөх явдал зайлшгүй гарах бөгөөд үүнийг зохицуулах арга зам нь хамгаалалтын бүсүүдийг оновчтой тогтоох явдал байдаг. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд Дархан Цаазат Газар болон Байгалийн Цогцолборт Газруудад хамгаалалтын 3 бүстэй байхаар заасан бөгөөд эдгээр бүсийг ялган тогтоох нь онол практикийн чухал ач холбогдолтой билээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд Байгалийн Цогцолборт Газар нь онцгой, аялал жуулчлалын, хязгаарлалтын гэсэн 3 бүстэй байхаар заасан бөгөөд онцгой бүс нь агуулгаараа дархан газрын онцгой бүс ба хамгаалалтын бүсийг хамтад нь төлөөлж байгаа юм. Өөрөөр хэлбэл Байгалийн Цогцолборт Газарт онцгой бүс нэртэй бичил дархан газар байна гэсэн үг юм. Иймд Байгалийн Цогцолборт Газрын тухайд хамгаалалтын бүсүүдийг ялган тогтооход дан ганц аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах талаас хандвал өрөөсгөл болох талтай. Учир нь улсын тусгай хамгаалалттай газрын дотор дархан газрын дэд сүлжээг бүрдүүлэхэд байгалийн муж, дэд мужийг төлөөлөх зарим нутгийг Байгалийн Цогцолборт Газрын онцгой бүсээр төлөөлүүлэн үзэж болно. Иймд энэ байдлыг давхар харгалзан үзэж хамгаалалтын бүсийг тогтоох нь зүйтэй юм. Байгалийн цогцолбор газар дахь рекреацийн үйл ажиллагааг байгаль хамгаалах, нөхөн сэргээх, сургах, сурталчлах үйл ажиллагаатай зөв хослуулж зохион байгуулахын тулд хамгаалалтын бүсүүдийг ялган тогтоох шаардлагатай байдаг.

Энэхүү үндэслэлээр Их газрын чулууны БЦГ-ын дотоод бүсчлэлийг БОНХАЖ-ын Сайдын 2015 оны А/90 дүгээр тушаалаар баталсан байна. Тус газрын онцгой бүс нь А, Б гэсэн 2 хэсэг талбайд байх бөгөөд аялал жуулчлалын бүс нь I, II, III гэсэн орон зайд тархдаг. Үүний гадуур хамгаалалтын бүс оршино (Хүснэгт 6, График 1).

Хүснэгт 6. Их Газрын Чулууны БЦГ-ын дотоод бүсчлэлийн талбайн хэмжээ (га талбай)

№	ДОТООД БҮС	ХАМААРАХ СУМД			НИЙТ ТАЛБАЙ
		Говь-Угтаал	Гурвансайхан	Өлзийт	
1	Онцгой бүс А	615.3	185.1	-	800.4
	Онцгой бүс Б	-	7976.2	-	7976.2
2	Аялал жуулчлалын бүс I	5213.7	8669.6	-	13883.3
	Аялал жуулчлалын бүс II	-	32158.3	79.5	32237.9
	Аялал жуулчлалын бүс III	-	11151.8		11151.8
3	Хязгаарлалтын бүс	10355.8	92799.6	6701.6	109857
4	Нийт талбай				175906.1
5	Орчны бүс	15908.14	128630.9	29460.6	174000

Эх сурвалж: Их Газрын Чулууны БЦГ-ын танилцуулга. Хуудас 4





График 1. Их Газрын Чулууны БЦГ-ын бүсүүдийн эзлэх хувь

ТХГН-ийн орчны бүсийн тухай хуулийн 3 дугаар зүйлд "Дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, тухайн газар нутгийг хамгаалахад иргэдийн оролцоог өргөжүүлэх, тэдний ахуй амьдралаа баталгаажуулах, байгалийн баялгийг зохистой ашиглах шаардлагыг харгалзан тогтоосон газар нутгийг орчны бүс гэнэ" хэмээн тодорхойлсон байна (ТХГН-ийн орчны бүсийн тухай хууль, 1997).



Зураг 2. Их Газрын Чулууны БЦГ-ын дотоод бүсчлэл

Эх үүсвэр: Их Газрын Чулууны БЦГ-ын менежментийн төлөвлөгөө 2019-2022

ТХГН-ийн менежментийн орчны бүс гэдэг нь тусгай хамгаалалттай газрын хилийн гадуур байгуулагдсан бүс бөгөөд нэмэлт давхарга бий болгохын тулд газар ашиглалтыг тодорхой хэмжээнд хязгаарлаж, нутгийн иргэд байгалийн баялгийг

хяналттайгаар ашиглаж болох газар юм. Орчны бүсийн хөгжлийн гол зорилго нь ТХГН-ийн хамгаалалтад хувь нэмрээ оруулах явдал бөгөөд энэ нь байгалийн нөөц ашиглах дарамтыг багасгах замаар хамгаалагдсан нутгийн тогтвортой хамгаалалтаа дэмжинэ гэсэн үг юм.


Их Газрын Чулууны БЦГ-ын орчны бүсийг 2016 онд нийт 174000 га талбайгаар тогтоосон байна (Зураг 2).

1.4. Аялал жуулчлалын өнөөгийн байдал

Их Газрын Чулууны БЦГ нь түүний өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хадгалах, хамгаалах, хувьсаж өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх, унаган төрхийг нь хадгалах, хамгаалах, хүн амын амралт, аялал жуулчлалыг зөв зохион байгуулах үүднээс байгуулагдсан, экологи, түүх, газар зүйн хувьд онцгой ач холбогдолтой, Дундговь аймгийн 9 гайхамшгийн нэг болсон үзэсгэлэнт газар юм.

2012 онд байгалийн цогцолборт газар болж өргөжсөнөөс хойш амрагч, жуулчдын тоо жил ирэх бүр тасралтгүй өссөөр байна (График 2). Үүнээс харахад Их Газрын Чулууны БЦГ нь сүүлийн жилүүдэд аялал жуулчлал эрчимтэй хөгжих хандлагатай газруудын тоонд зүй ёсоор орно.

График 2. Их Газрын Чулууны БЦГ-т аялсан жуулчдын тоо (2014-2020 он)



Эх сурвалж: Их Газрын Чулууны БЦГ-ын Хамгаалалтын захиргаа (Жуулчдын тоог ТХГН-ийн хураамж болох нэг удаагийн тасалбараар тооцсон)

Графикаас харвал цогцолборт газраар аялж буй гадаадын жуулчдын тоо жил бүр нэмэгдэж байгаа бөгөөд 2019 онд өмнөх жилийнхээс 49%-иар өссөн үзүүлэлттэй байна. Гэвч 2020 онд дэлхийг хамарсан Ковид-19 цар тахлаас шалтгаалж дэлхийн аялал жуулчлалын салбар 0 зогсолт хийсэнтэй холбоотой нэг ч гадаадын жуулчид ирээгүй боловч дотоодын жуулчдын тоо дангаараа өмнөх жилийнхээс 58%-иар өссөн байна. Дээрх тоо баримт нь Их Газрын Чулууны БЦГ-т аялахаар зөвхөн тасалбар авсан буюу ТХГН-ийн хураамж төлсөн аялагч, жуулчдын тоо юм.

Гэвч энэхүү судалгааг бодит тоо гэж үзэхэд хангалтгүй байна. 2021 оны 7-р сард хээрийн судалгааны үеэр авсан асуулгын дүнгээс харахад хураамж төлөхгүйгээр зорчих

аялагчдын тоо дээрх тооноос даруй 60 хувиар илүү байж болохыг тогтоосон. Аялагчид нь тухайн бүсэд отоглож буудаллахгүйгээр үзмэрийг үзэж сонирхоод дайран өнгөрөх төлөвтэй байгаа нь судалгааны үр дүнгээс ажиглагдав. Иймээс тасалбар авсан аялагчдын тоон дээр түүний 60%-тай тэнцэх хэмжээний тоон утгыг нэмснээр бодит аялагчдын тоо гарах магадлалтай. Жишээ нь 2020 онд зорчсон дотоодын аялагчдын тоо $1170 * 60\% = 702$ аялагчаар нэмэгдэхэд $1170 + 702 = 1872$ болсон тооцоолол байна.

Өнөөгийн байдлаар 2018 онд БОАЖ-ын сайдын А/116 дугаар тоот тушаалаар батлагдсан аяллын үндсэн 2 маршрутаар жуулчид аялдаг.

Аяллын маршрут-1 (Зураг 3)

Аяллын замын чиглэл: *Задгай театр – Гэрэлт хөшөө – Тоонотын агуй – Хур харцагын таг – Эхийн умай агуй – Өвгөн хад – Уст хад – Толгой – Ихрийн агуй – Бурхантын агуй – Лянх хад*

Тээврийн хэрэгсэл

Авто болон ердийн хөсөг

Нийт замын урт

14 км

Амрах цэг -1

Хур харцагын таг

Аргаль, янгир харах боломжтой

Амрах цэг -2

Уст хад

Түүнчлэн орчин цагт байгаль орчноо хамгаалж эрүүл, аюулгүй байдлаар аялах хандлага дэлхий дахинд нэмэгдэж байгаатай уялдуулан богино зайд явганаар аялах боломжийг бүрдүүлж аяллын дараах замналыг гаргаж баталсан байна.

Аяллын маршрут-2 (Зураг 4)

Аяллын замын чиглэл: *Тоонотын агуй – Хур харцагын таг – Эхийн умай агуй – Өвгөн хад – Уст хад – Өнөр баян хайрхан*

Тээврийн хэрэгсэл

Явган аялал

Нийт замын урт

5 км

Амрах цэг -1

Хур харцагын таг

Аргаль, янгир харах боломжтой

Амрах цэг -2


Уст хад

Өнөр баян хайрхан

Орчныг өндрөөс харах боломжтой байршил

Эдгээр маршрутын дагуу амрагч, жуулчдын ая тухтай байдлыг хангах зорилгоор мэдээллийн самбар, амрах, отоглох цэг болон эко ариун цэврийн байгууламжийг барьж байгуулсан байна (Зураг 5-9).

Судалгааны үр дүнгээс харахад жуулчид Их Газрын Чулууны БЦГ-аар өөрийн аяллын маршрутын дагуу дайран өнгөрөх, эсвэл тус газрыг зорин ирж амрах зэрэг аль ч тохиолдолд ерөнхийдөө 1-2 хоногийг энэхүү цогцолборт газарт өнгөрүүлдэг. Өнөөгийн байдлаар жуулчны бааз байхгүй тул хоноглохоор ирсэн ихэнх аялагчид отоглох цэг дээр майханд хоноглож байна. Мөн аялагч, жуулчид ойр хавьд тохь тухтай хоноглох бааз байгаа талаар судалгааны багийнхнаас цөөнгүй асууж сураглаж байсан юм. Отоглох цэг дээр хоноглосон аялагч, жуулчид ариун цэврийн байгууламж, тохижилт зэрэгт сэтгэл хангалуун байгаагаа бидэнд илэрхийлж байв.



Зураг 4. Их Газрын Чулууны БЦГ дахь явган аяллын батлагдсан маршрут 2



Зураг 5. Амрах, отоглох цэг



Зураг 6. Ариун цэврийн байгууламж



Зураг 7. Түүх, соёлын дурсгалт зүйлсийн тэмдэглэгээ



Зураг 7. Явах чиглэл заасан тэмдэглэгээ



Зураг 8. Байгалийн өвөрмөц тогтоцын тэмдэглэгээ

Тус цогцолборт газарт нийт 1 отоглох цэг, 3 ариун цэврийн байгууламж, 18 мэдээлэл, үзвэрийн самбар байршуулсан бөгөөд байгаль хамгаалагчийн байранд аяллын маршрут болон үзмэрийн дэлгэрэнгүй мэдээллийг түгээсэн самбартай ба замналын дагуу чиглэл заасан тэмдэглэгээ байрлуулсан байдаг.

Их газрын чулууны уулын тойрогт орох, гарах 3 хаалгыг Өлзийт, Говь-Угтаал, Гурвансайхан сумдын чиглэлд байрлуулсан байх бөгөөд хаалганы хажууд мөн мэдээллийн самбартай (Зураг 10).

2021 оны байдлаар амралт, жуулчны бааз үйл ажиллагаа явуулаагүй байна. Уг нь хоёр ч амралт, жуулчны бааз байсан байна. 1990-ээд оноос өмнө Өвгөн хадны хойд талд хүүхдийн зуслан байсан ба хожим нь амралтын газар болсон боловч үйл ажиллагаагаа зогсоожээ.



Зураг 9. Их газрын чулуу уул руу орох, гарах хаалга

Мөн Байгаль хамгаалагчийн байрны зүүн урд талд жуулчны бааз ажиллаж байсан боловч газар ашиглах хүсэлтээ сунгуулаагүй гэсэн шалтгааны улмаас үйл ажиллагааг нь зогсоосон байна. Тиймээс судалгаа, шинжилгээний үндсэн дээр, тодорхой байршлуудад цөөн тооны амралтын газар, жуулчны бааз байгуулах шаардлагатай юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

ИХ ГАЗРЫН ЧУЛУУНЫ БЦГ-ЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨӨЦ, ДААЦЫН СУДАЛГАА

2.1. Их Газрын Чулууны БЦГ-ын аялал жуулчлалын суурь нөөцүүдийн судалгаа

2.1.1. Амралт сувилал, аялал жуулчлалын газар зүйн мужлал

Монгол орны амралт сувилал, аялал жуулчлалын үндсэн нөөцүүд болон бусад холбогдох хүчин зүйлс /био уур амьсгал, уулын ба талын ландшафт, амралт, загас агнуурт тохиромжтой гол, мөрөн, нуурын байдал, байршил, рашаан ус, эмчилгээний шавар гэх мэт/-ийн зохицолдлогоо нь олон янзын шинж төрхийг агуулдаг бөгөөд амралт, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тохиромжтой байдлаараа харилцан адилгүй нөхцөлтэй байдаг.

Монгол орны нутаг дэвсгэрийг амралт сувилал, аялал жуулчлал (АСАЖ)-ын үйл ажиллагааг төрөлжүүлэх боломж, ландшафтын шинж төрх, уур амьсгалын тааламжит нөхцөл зэргийг гол үндэс болгон АСАЖ-ыг хөгжүүлэх 5 их мужид хуваан авч үздэг (Барилга, Хот Байгуулалтын Яамны Зураг Төсөл Судалгааны Үндэсний Төв, Монгол улсад амралт сувилал аялал жуулчлалыг хөгжүүлэх ерөнхий төсөл, 1991 он). Үүнд:

- АСАЖ-ыг бүх төрлөөр хөгжүүлэх их муж
- АСАЖ-ыг хязгаарлагдмал хөгжүүлэх их муж
- Уулын спорт аяллын их муж
- Орон нутгийн амралт, аялал жуулчлалын их муж
- Амралт сувилал хөгжүүлэхэд тохиромжгүй их муж

Эдгээр их мужуудыг дотор нь АСАЖ-ыг хөгжүүлэх нөөц, байгаль газарзүйн онцлогоор нь ангилж 19 дэд мужид хуваан үздэг байна.

Энэхүү АСАЖ-ын газар зүйн мужлалаар авч үзвэл Их Газрын Чулууны БЦГ нь “АСАЖ-ыг хязгаарлагдмал хөгжүүлэх их муж”-ийн Мандалговийн буюу өмнөд Хэнтийн дэд мужид хамаарна. Энэхүү мужлалд уг дэд мужийг тодорхойлохдоо “Хангайн нурууны зүүн салбар уулсаас Хэрлэн голын эх хүртэлх нутаг хамардаг бөгөөд ойн ландшафт байхгүй, цав толгодлог жинхэнэ хуурай хээр, тал зонхилно. Энэ дэд муж хужирлаг хөндий ихтэй, хотгоруудаар нь жижиг нууруудтай, эдгээр нуурууд нь голдуу эмчилгээний шавар агуулсан байдаг ч сайтар судлагдаж амжаагүй. Мужийн зүүн ба баруун хойд хэсэгт рашаан усууд байдаг ба Их, Бага газрын чулуу, Хайрхан уул зэрэг байгалийн зарим өвөрмөц тогтоц, хотгор гүдгэрийн зохилдлого, түүний дотроос геоморфологийн тогтцууд нь аялал, жуулчлалын хувьд сонирхол татахуйц байдаг. Томоохон гол мөрөн, нуур байхгүй, ландшафтын нэг хэвийн байдлаас нь шалтгаалж энэ дэд муж АСАЖ-ын ач холбогдлоороо доогуур үнэлгээтэй юм. Энд орон нутгийн хүн амын хэрэгцээг хангах зорилгоор түр хугацааны амралт, хэсэгчилсэн байдлаар аялал жуулчлал, эмчилгээ сувилгаа, ан агнуурыг хөгжүүлэх бололцоотой” гэсэн байна. Үүнээс үзвэл Их Газрын Чулууны БЦГ нь “өвөрмөц тогтоц, хотгор гүдгэрийн зохилдлого, түүний дотроос геоморфологийн тогтоц нь аялал, жуулчлалын хувьд сонирхол татахуйц” бөгөөд “түр хугацааны амралт, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тохиромжтой” нутаг дэвсгэр юм.

2.1.2. Аялал жуулчлалын байгалийн нөөц

Амрагч, аялагчдын сонирхлыг татах нэг гол зүйл нь тухайн нутаг орны байгалийн тогтоц, үзэсгэлэнт газрууд байдаг. 2018 оны Монгол банкны судалгаагаар Монголд ирж

байгаа жуулчдын 17,82% нь зэрлэг, унаган байгалийг үзэхийг хүсэж буйгаа илэрхийлсэн нь тус асуулгын хамгийн өндөр үзүүлэлт байсан юм. Их Газрын Чулууны БЦГ-ын хувьд түүний үзэсгэлэнтэй, өвөрмөц тогтоц бүхий газрууд нь жуулчдын сэтгэлийг татах бусдаас ялгарах өвөрмөц онцлогийг илэрхийлдэг.

Их Газрын Чулууны БЦГ-ын аялал жуулчлалын голлох байгалийн нөөц нь:

1. Ховор, ховордсон ургамал, амьтан
2. Өвөрмөц тогтоц бүхий үзэсгэлэнтэй сүрлэг боржин чулуун хадан цохио, болон бусад агуй, хавцал юм.

Ховор, ховордсон ургамал, амьтан

Их Газрын Чулууны БЦГ-ийн амьтан, ургамлын нөөц, түүн дотроо нэн ховор, ховор ургамал, амьтан нь цэцэг ажиглах, амьтан ажиглах аялал зэрэг тусгай сонирхлын аялал жуулчлалын чухал нөөц юм (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Их Газрын Чулууны БЦГ-ын амьтан, ургамлын төрөл

Нөөц	Төрөл	Нэрс
Амьтны аймаг	Мэрэгчид	Алаг даага, хадны борогчин, монгол чичүүл, үхэр огдой
	Хэвлээр явагчид	Зараа, хонин гүрвэл, могой
	Гар далавчтан	Сахалт багваахай, жижиг соотон багваахай
	Жигүүртэн	Тас, бүргэд, харцага, шонхор, занхгар занглай, ногтруу, эрэн хавирга, хээрийн тагтаа, ухаа дунхай, болжмор, хондон ангир, ооч ёл
	Хөхтөн	Аргаль, янгир, хар сүүлт, цагаан зээр, мануул мий, дорго, үнэг, хярс, тарвага, туулай, чоно
	Ховор	Аргаль, янгир, хар сүүлт, цагаан зээр
Ургамлын аймаг	34 овог 97 төрөл	152 зүйл ургамалтай
	Нэн ховор	Цөлийн аргамжин цэцэг, ноосон шилбэт баглуур
	Ховор	Пржевальскийн зээргэнэ, анхил сонгино, ацан ажгана, өргөст ортууз, дагуур хүж өвс, сибирь ерөндгөнө, шаргал шарилж

Өвөрмөц тогтоц бүхий үзэсгэлэнт сүрлэг боржин чулуун хадан цохио болон бусад агуй, хавцал


“Их газрын чулуу” уул нь далайн түвшнээс дээш 1565-1709 метр өндөрт өргөгдсөн боржин, асмалжин, толбожин гэх мэтийн гүний чулуулаг, пермь, цэрд, гурав дахь галавын элсэн чулуу, нүүрслэг занар, алаг мөлгөр хөрзөн, шохойн чулуунаас тогтсон 450 км кв нутгийг эзлэн оршдог өвөрмөц тогтоцтой, үзэсгэлэнтэй сайхан уул юм. Их газрын чулуу нь хойноос урагшаа чиглэлтэйгээр 20 орчим км үргэлжилсэн 2 хэсгээс тогтох бөгөөд Монголын их боржин чулуулгийн бүсийн хамгийн том хэмжээтэй нь юм. Эндэхийн боржин цохио нь ухаа ягаан өнгөтэй, том ширхэгтэй талстуудаас бүрдэх ба тууш, босоо, хөндлөн янз бүрийн хагарлуудтай. Эдгээр хагарлын заагт өгөршлийн үр дүнд үүссэн агуйнууд байх ба тэдгээр нь Их газрын чулууны зүүн хэсэгт нэлээд өндөрт нь тооцогдох Өлзийт, Сүмбэр уулын урд хэсэгт тусгаар орших боржин цохионд байрладаг.

Өлзий, Сүмбэр, Баян уул, Хайрхан зэрэг ноёлог өндөрлөгүүдтэй, Өвгөн, Сэнжит, Хатан хаан, Хайлсман, Тувин, Гуа өлгий, Монгол, Баян уул, Ёрвон, Уст хад гэх мэт өвөрмөц хэлбэр тогтоц бүхий хад байц олонтой. Мөн Өлгий, Бурхант, Шинэ ус, Тоонот, Эхийн умай, Агуйт, Рашаант, Ихрийн агуй, Торой бандийн агуй зэрэг их бага нийлсэн 40 гаруй агуйтай.

Их Газрын Чулууны БЦГ-ын Хамгаалалтын Захиргаанаас 2018 онд агуйн судалгаа хийж дээрх агуйнуудаас 13 агуй, 2 хавцлыг бүртгэж, хэмжилт, эргэлтийн цэгийг координатжуулах, зурагжуулах ажлыг зохион байгуулсан байна (Зураг 11). Тэдгээрээс:

- Хамгийн урт агуй –Тоонотын агуй /33.10 м/,
- Хамгийн өргөн агуй - Өлгийн агуй /5.60 м/,
- Хамгийн өндөр агуй- Эхийн умай /3.57 м/

- Хамгийн том амсартай агуй- Тоонотын агуй /амсарны өндөр-1.41, өргөн-3.46-тай/
- Далайн түвшнээс хамгийн өндөр агуй- Алагийн агуй /1488 м/
- Далайн түвшнээс хамгийн нам агуй - Хяналтын агуй /1395 м/-т оршиж байгааг судалж тогтоожээ.



Зураг 10. 2018 оны агуйн судалгаагаар бүртгэгдсэн агуйн байршил

Эх үүсвэр: ИГЧБЦГ-ын агуйн тооллого, судалгаа, 2018

Сонирхол татахуйц, нууцлаг агуйнууд, өвөрмөц сүрлэг хадан цохио, хавцал нь аялал жуулчлалын байгалийн үнэт нөөц болдог бөгөөд Их Газрын Чулуу БЦГ-т орших агуйнуудад тулгуурлан агуйн аялал жуулчлалыг дагнасан хэлбэрээр болон бусад аяллын төрлүүдтэй хавсарсан байдлаар зохион явуулах боломжтой.

Агуйт хэмээх газар нь боржин цохионы баруун урд байрладаг бөгөөд энэ агуй руу 2 метр өргөн, 5 метр өндөр зууван амаар орж 11 метр яваад мухарт нь тулна. Тоонотын агуй нь Агуйтын хадны ар бэлд оршино. Нийт урт нь 27 метр бөгөөд агуйн төгсгөл хэсэгт орой нь цоорхой тул Тоонот гэж нэрлэжээ. Өлгий агуй нь Тоонотын агуйгаас зүүн тийш 1.4 километрт байрлах бөгөөд эрт үед энэ агуйд ном судар их байдаг байсан гэлцдэг. Унаа хад, Боов хад, Лусын эзэн, Хаан хатан хоёр загасны ам зэрэг олон сонин тогтоц бүхий хад чулуутай. Агуй байрлаж буй хадан цохионууд нь харгана, шаваг, буйлс зэрэг сөөг ургамал оролцсон хялгана-агьт ургамалтай. Эдгээр агуйнууд нь үзэж сонирхоход газрын бартаа багатай, хоорондоо ойрхон орших тул явган аялал хийхэд тохиромжтой юм.

Их газрын чулуунд ирсэн хүн бүр “Эхийн умай”-гаар орж, бие, болоод сэтгэлээ ариусгасны дараа “Уст хад”-нд очиж рашаан хүртэн ариусаж, “Өлгий” хаданд очиж өлгийдүүлэн “хүн болох” зан үйлийг гүйцэтгэх ёстой гэдэг. Нутгийн ард түмэн “Уст хад”-ыг дөрвөн алд уурга оруулахад ёроолд нь хүрдэггүй гүнзгий гэж ярьдаг, нүдний мах ургах, улайх зэрэгт энэ рашаанаар нүдээ угаадаг байна.

Баганатын, Гимбэлийн, Жирэгийн зэрэг хэд хэдэн тагтай бөгөөд тэдгээрийн нэг нь хэдэн азарга адуу багтаах зайтай, алдарт бөх “Хур харцага”-ын амьдарч байсан гэх домогт гардаг “Хур харцагын таг” юм. Мөн энэ нутагт байдаг байгалийн өвөрмөц тогтоц бүхий “Ембүү” хад, “Лянх буюу үр гуйх” хад зэргийг монголчууд зорин ирж, хүслээ шивнээд явдаг байна.

2.1.3. Аялал жуулчлалын түүх, соёлын нөөц

Түүх, соёлын дурсгалууд нь хүн төрөлхтний түүх, нийгмийн хөгжлийн үе шатуудыг илтгэгч үнэт гэрч болдог төдийгүй тухайн газар нутагт жуулчдыг татах, аялал жуулчлалыг хөгжүүлэх чухал нөөц болдог.

Монгол улс 1990 онд Дэлхийн соёлын Өвийн Конвенцод, 1991 онд Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенцод нэгдэн орсноор тэдгээрийн үзэл санаа, үндсэн зарчмууд, шаардлагуудыг соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжуудад тусган хэрэгжүүлдэг.

Их газрын чулууны БЦГ-ын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын үнэт нөөц-үзмэр болох боломжтой олон тооны түүх, соёлын дурсгал хадгалагдахын зэрэгцээ уламжлалт өв соёлын бүтээлүүд байдаг байна. 2018 онд Их Газрын Чулууны БЦГ-ын хамгаалалтын бүсэд тус цогцолборт газрын Хамгаалалтын Захиргааны мэргэжилтэн, байгаль хамгаалагч нар Соёлын Өвийн Үндэсний Төвийн судлаачидтай хамтран түүх соёлын үл хөдлөх дурсгал болон соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын бүртгэл судалгааг хийж, судалгаагаар цуглуулсан мэдээллийг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан болон аймаг, сумын бүртгэл мэдээллийн сан, хамгаалалтын захиргааны бүртгэл мэдээллийн сангуудад цэгцлэн хадгалж, Соёлын өвийг хамгаалах хуулийн хэрэгжилтийг хангасан байна.

Тус судалгаагаар Их Газрын Чулууны БЦГ-д байрлах 49 газарт нийт 216 түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд байгааг тогтоож, тэдгээр үл хөдлөх түүх, соёлын дурсгалын тархалтын зургийг гаргасан байна (Хүснэгт 8, зураг 12).


Хүснэгт 8. Их Газрын Чулууны БЦГ-ын түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд, тэдгээрийн ангилал, байршил

№	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын төрөл	Байрлах газрын тоо	Тоо ширхэг
1.	Хиргисүүр	8	11
2.	Дөрвөлжин булш	6	18
3.	Шоргоолжин булш	1	1
4.	Хүрлийн үеийн жижиг дугуй булш	3	15
5.	Чулуун байгууламж	3	3
6.	Зэл чулуу	4	4
7.	Хадны зураг	2	2
8.	Түвд маань үсэг	3	4
9.	Хөшөө чулуу	2	4
10.	Барилгын туурь	1	1
11.	Түрэгийн тахилын онгон	1	1
12.	Хүннү булш	5	80
13.	Монгол булш	3	72
			216

Эх сурвалж: Хамгаалалтын захиргааны судалгааны тайлан, 2018

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг төрлөөр нь авч үзвэл 37.3% нь хүннү булш, 33.3% нь Монгол булш, 8.3% нь дөрвөлжин булш, 6.9% нь хүрлийн үеийн жижиг дугуй

булш, 5% нь хиргисүүр, үлдсэн хувь нь зэл чулуу, хөшөө чулуу, барилгын туурь, тахилын онгон болон бусад дурсгал байна. Эндээс үзэхэд Их Газрын Чулуу БЦГ-ын нутаг дэвсгэрт түүх соёлын дурсгал болох эртний булш, хиргисүүр их байдаг тул түүх, соёл, судалгаа шинжилгээний аялал зохион байгуулахаас гадна бусад төрлийн аяллын хөтөлбөрт ч тусгах боломжтой.



Зураг 11. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тархалтын зураг

(Эх сурвалж: Их Газрын Чулууны БЦГ-ын хамгаалалтын бүсэд хийсэн соёлын өвийн бүртгэл судалгааны тайлан, 2018)

2.1.4. Үйл явдал, эвент

Энэхүү цогцолборт газарт гадаад, дотоодын жуулчид олноороо ирдэг бөгөөд Дундговь аймаг энэ нутгийг аялал жуулчлалын бүс болгох чиглэлээр ихээхэн анхаарч, хэд хэдэн томоохон үйл ажиллагааг зохион байгуулсан.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойгоор 2006 онд Их газрын чулууны уулнаа байгалийн Задгай театр байгуулсан нь Монголдоо анхдагч болсон юм. Театрын тайзны диаметр нь 18 метр буюу радиус 9 метр бөгөөд 1 метр 40 сантиметрийн өндөртэй (Зураг 13).



Зураг 12. Их Газрын Чулууны БЦГ дахь Задгай театр

Задгай театрын тайзнаа 2006, 2013 онд хоёр удаа Олон улсын урлагийн наадам, 2019 онд “Уяхан замбуу тивийн наран” урлагийн их наадмыг тус тус зохион байгуулсан юм. Мөн 2006 онд тус театрын дэргэд Зууны манлай уртын дуучин Ж.Дорждагва, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт ардын жүжигчин, Зууны манлай уртын дууч Н.Норовбанзад нарын нэр алдрыг мөнхжүүлсэн гэрэлт хөшөөг босгож “Уяхан замбуу тивийн наран” дууны үгийг сийлэн мөнхөлсөн нь жуулчдын очих дуртай газрын нэг болжээ.

Түүнчлэн энэ ууланд тус нутгийн өвөрмөц тогтцыг нь ашиглан “Талын цуурай”, “Ичээнд нь”, “Бушхүүгийн үлгэр”, “Загийн алим”, “Тууврын замд” зэрэг ард түмний зүрх сэтгэлд хоногшсон олон сайхан киноны зураг авалтыг хийж байжээ. Энэ нь кино аялал (film tourism)-ыг зохион байгуулж, дотоодын жуулчдад санал болгох боломжтойг харуулж байна. Film tourism буюу кино аялал гэдэг нь хүмүүс өөрсдийн дуртай, алдартай киноны зураг авалт хийгдсэн газар нутагтай өөрийн биеэр танилцах, түүнийг судлах аялал бөгөөд энэ нь соёлын аялал жуулчлалын нэг төрөл юм.

2.2. Аялал жуулчлалын даацыг тогтоох арга зүй

2.2.1. Ландшафт, газрын бүрхэвчийн ангилал, түүний өөрчлөлтийн үнэлгээ хийсэн арга зүй

Байгаль дэлхий дээр явагдаж байгаа өөрчлөлтүүд, тэдгээрийн орон зай, цаг хугацааны хамаарлыг судлах, байгалийн нөөц, байгаль орчны мониторинг хийх зорилгоор АНУ нь Landsat TM төрлийн 7 хиймэл дагуулыг хөөргөснөөс 1-5 ба 7-р сувгууд нь ногоон ургамлын спектро ойлгох чадварыг хэмждэг учраас тухайн газар ургамалтай, ургамалгүй эсэхийг ялгахад ашиглаж болох ба янз бүрийн спектрийн муруйг харьцуулан тэдгээрийн физик шинж чанарт үнэлгээ өгч болдог. Нил улаан туяаны ойрын мужид пикселүүдийн бүтцийн хоорондох ялгаа эрүүл ногоон ургамлыг

гэмтэлтэй ургамлаас ялгаж өгдөг. Нил улаан туяаны дундын мужид ургамлын чийг агууламжийг хэмжих замаар спектрийн ойлт болон шингээлтийн шинж чанараар нь эрүүл ургамлыг гэмтэлтэй ургамлаас ялгаж болдог. Энэ нь өвчин хортон тархсан ой болон таримал ургамалтай газрыг ялгах боломжтой болохоос гадна ургамлын нөмрөгийг төрлүүдээр нь ялгах боломжтой.

Хиймэл дагуулын мэдээг боловсруулахдаа ERDAS Imagine программ хангамжийг ашиглах ба дүрс боловсруулалтын хяналттай ба хяналтгүй ангиллын аргыг хослуулан ашиглаж газрын санг ангилах, талбайн хэмжээг га-аар тооцоолох боломжтой.

Ландшафтын үндсэн хэв шинжүүд болон газрын бүрхэвчид гарсан өөрчлөлтийг тооцон гаргахын тулд ландсат TM, ETM хиймэл дагуулын мэдээг ашигласан бөгөөд хиймэл дагуулын мэдээнээс ландшафтын хэв шинжүүдийг сонгон авахын тулд спектрийн хувьд сайжруулсан голлох бүрдлүүдийг ашиглан байгуулсан дүрс зураг, локал болон контекстийн мэдлэгийг ашигласан болно.

Спектрийн зайн хувьд өндөр давхцалтай ангиудыг өөр хооронд нь салгах үүднээс локал болон контекстийн мэдлэг дээр тулгуурлан тодорхойлсон орон зайн зааглагчуудыг ашигласан бөгөөд локал мэдлэгийг ГМС-д хадгалагдсан мэдээнээс, харин контекстийн мэдлэгийг дүрс зурган дээрх ангиудын текстур болон спектрийн хувирал дээр үндэслэн тодорхойлсон болно.

2.2.2. Хүний үйл ажиллагааны нөлөөллийн үнэлгээ хийсэн арга зүй

Хүний үйл ажиллагааны нөлөөллийн үнэлгээг байгаль хамгаалах арга хэмжээг зардал багатай хэрэгжүүлэх ерөнхий арга гэж үздэг. Амьдрах орчны экологийн бүрэн бүтэн байдал буюу түүхэн эсвэл байгалийн нөхцөл байдлаас хэрхэн өөрчлөгдсөнийг илэрхийлэх шууд бус хэмжүүр нь хүний үйл ажиллагааны хуримтлагдах нөлөөлөл юм. Мэдээллийн олдоч дээр тулгуурлан одоогийн хүний үйл ажиллагааны нөлөөллийн хэлбэр, эх үүсвэрийг ГМС дээр тооцоолох замаар нөлөөллийн индексийг боловсрууллаа. Тусгай хамгаалалттай газар нутаг дахь хүний үйл ажиллагааны нөлөөллийн сонгон авсан хүчин зүйл бүрээр тооцохдоо урьд өмнө нь нөлөөллийн үнэлгээний чиглэлээр хийгдэж байсан Увс нуурын ай савын дархан цаазат газруудын аялал жуулчлалын нөөц, даацын судалгаа (ТХГН-ийн Судалгааны Төв, 2018), Дарьгангын БЦГ-ын аялал жуулчлалын нөөц, даацын судалгаа (ТХГН-ийн Судалгааны Төв, 2018) зэрэг судалгааны эх сурвалж материал дээр үндэслэсэн.

Авто замын сүлжээний нягтрал, түүний нөлөөлөл: Авто зам нь зэрлэг амьтны амьдрах орчин, амьдралын хэв маягт олон хэлбэрээр сөрөг үр нөлөө үзүүлдэг (Trombulak and Frissell 2000). Монгол орны ихэнх зам нь шороон бөгөөд байнга өөрчлөгдөж байдаг. Зарим замыг бусдаас илүү эрчимтэй ашигладаг тул хэд хэдэн замыг ачаалал ихтэй зам гэж тодорхойлсон. Ачаалал ихтэй зам гэсэн ангилалд улсын чанартай авто зам болон төмөр замыг хамруулж 0.5 км-ийн алслалттайгаар 2.0 км-ээр, ачаалал багатай байнга өөрчлөгдөж байдаг шороон замыг 0.25 км-ийн алслалттайгаар 1.0 км-ээр тооцож зурагласан.

Бэлчээр ашиглалтын нөлөөлөл. Малын бэлчээр ашиглалт нь ургамлын зүйлийн бүрдэл (Fernandez-Gimenez and Allen-Diaz 2001) болон зэрлэг амьтны амьдрах орчны хэвийн нөхцөл, чанарт нөлөөлдөг. Мал зэрэгцэн оршиж буй зэрлэг амьтантай өрсөлдөж тэднийг амьдрах орчноос нь шахаж (Wingard et al. 2011, Yoshihara et al. 2008, Campos-Arceiz et al. 2004), эсвэл зэрлэг амьтны сорчлон иддэг ургамлын зүйлийн тоог бууруулах зэргээр нөлөөлдөг (Gana Wingard хэвлүүлээгүй мэдээ). Olson нар (2011)-ын судалгаагаар цагаан зээр нь малчин айл орчмын газар нутгаас зайлсхийх ба хот айлын бөөгнөрөл нь зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөнд саад учруулж, идээшил бэлчээртээ хүрэх боломжийг хязгаарладаг нь тогтоогджээ.

Малчин өрхийн бэлчээр ашиглалтын байршлын нөлөөллийг тооцохын тулд өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны байршлын цэгэн мэдээллийг ашигладаг. Малын бэлчээрийн орон зайн бүсчлэлийг тооцохдоо ArcGis 10.3 Spatial Analyse-ийг ашигласан ба өвөл, хаврын улиралд 2-4 км, зун намрын улиралд 4-6 км радиуст бэлчээрлэдэг гэсэн

судлаачдын судалгааны үр дүнд үндэслэн бэлчээрт ашиглагдаж буй газрыг тооцон гаргасан. Нөлөөллийн түвшнийг үнэлэхдээ нөлөөллийг илтгэсэн тэгшитгэлийг Systat программ дээр хүчин зүйлийн анализын аргаар тооцон гаргасан болно.

Хүний үйл ажиллагааны хүчин зүйлсийн нэгдсэн үнэлгээ. Хүний үйл ажиллагааны нөлөөлөл нь өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн үйл ажиллагааны хэлхээ, хүрээлэн буй орчинд өөрчлөлт үзүүлж байдаг. Хүний үйл ажиллагааны нөлөөллийг ердийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тогтооход бэрхшээлтэй. Хүний үйл ажиллагааны нөлөөллийг олон улсад хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ гэж нэрлэдэг. Ихэнхдээ байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хуримтлагдах нөлөөллийг огт дурдаагүй эсвэл цухас авч үзсэн байдаг (Cantor & Ross 2010). Зарим байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хуримтлагдах нөлөөний талаар хэт ерөнхий зүйл оруулсан байдаг ба орон зай, цаг хугацааны хувьд нарийвчлан тодорхойлолгүй орхисон байх нь түгээмэл (Burris & Cantor) хуримтлагдах нөлөөллийг ландшафтын түвшинд авч үзэх нь илүү зохистой (Joao 2010).

Энэ судалгаагаар ГМС-ийн мэдээллийг ашиглан хүний үйл ажиллагааны нөлөөллийг замын нягтрал, малчин өрхүүдийн бэлчээр ашиглалт гэсэн 2 хүчин зүйлээр тооцож нэгдсэн үнэлгээ гаргаж нөлөөллийг маш бага, бага, дунд зэрэг, хүчтэй, маш хүчтэй гэсэн 5 ангиллаар ялгаж үнэлсэн.

Одоогоор жуулчны бааз үйл ажиллагаа явуулаагүй байгаа тул жуулчны баазын нягтралын нөлөөллийн үнэлгээг хийх шаардлагагүй гэж үзсэн бөгөөд харин ямар хүчин чадалтай, хэчнээн жуулчны баазыг хаана байгуулах нь тохиромжтой талаар тусгаж оруулсан.

2.2.3. Байгалийн ландшафтын эрсдэлийн үнэлгээ хийсэн арга зүй

Ландшафтын эрсдэлийн үнэлгээ нь экологийн зохистой бүсчлэл тогтоох үндэслэл болдог. Ландшафтын эрсдэлийг үнэлэх үнэлгээний шалгуур үзүүлэлтээр дараах үзүүлэлтүүдийг сонгон авч болдог. Үүнд:

- Гадаргын налуу
- Хөрсний механик бүрэлдэхүүн
- Хөрсний элэгдлийн хэв шинж
- Ургамлын бүрхэвч

Хүснэгт 9. Ландшафтын эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлтүүд	Үнэлгээ зэрэглэл				
		Маш бага	Бага	Дунд	Хүчтэй	Маш хүчтэй
1.	Гадаргуугийн налуу /градусаар /	<3°	3-5°	5-8°	8-15°	>15°
2.	Хөрсний механик бүрэлдэхүүн	Хүнд шавранца р	Дунд шавранца р	Хөнгөн шавранца р	Элсэнцэр	Элс
3.	Гадаргын элсэн бүрхэвч (%-иар)	0	0-20	20-40	40-60	>60
4.	Ургамлын бүрхэвч	>45	35-45	25-35	15-25	<10

Шалгуур үзүүлэлт тус бүрээр сэдэвчилсэн давхарга үүсгэж, үүсгэсэн давхруудыг давхцуулах замаар ландшафтын эрсдэлийн нэгдсэн үнэлгээг 5 шатлалтай ангиллаар үнэлж, зурагласан.

Аялал жуулчлалын байгалийн даацыг тогтооход харгалзах үндсэн параметр бол байгалийн ландшафтын эрсдэлийн үнэлгээ юм. Энэхүү асуудлын үндэс нь аялал жуулчлалын нөлөөллийг байгалийн цогцолборуудын экологийн ачааллын дээд хязгаар, байгалийн нөхөн сэргэх чадавхаас давахгүйгээр тогтооход оршино. Тиймээс БЦГ-ын

аялал жуулчлалын даацыг тогтооход ландшафтын эрсдэлийн үнэлгээ чухал ач холбогдолтой.

Гадаргын налуу – Аялал жуулчлал хөгжүүлэхэд гадаргын налуу чухал үүрэгтэй. Судалгаагаар 2-6° налууутай нутаг дэвсгэрийн ургамлын нөмрөгийн талхагдлын хурдац харьцангуй бага, 6-12° болоход харьцангуй өндөр болдог, нутаг дэвсгэрийн налууугийн байдал 12°-аас дээш болоход талхагдал хэт хурдан явагдах тул 12°-аас дээш налууутай нөхцөлд рекреацийн үйл ажиллагааг хязгаарлах шаардлагатай болдгийг тогтоосон байна (Marsz.1972). Дэлхийн жуулчны байгууллагын санал асуултаар 10° буюу түүнээс дээш налууутай зам аялагчдын эрүүл мэнд, аялах хурдад нөлөөлж байдгийг тогтоожээ.

Гадаргын налууугийн шатлалыг боловсруулахдаа:

- Талархаг байдал;
- Уулархаг байдал;
- Аялал жуулчлал хөгжүүлэх хэрэгцээ шаардлага зэргийг харгалзан, гадаргын налуу тооцох шалгуур үзүүлэлтүүдийг үндэс болгож 20°-аас их, 12°-20°, 6°-12°, 3°-6°, 3-аас бага налуу гэж үндсэнд нь 5 ангиллыг гаргасан (*Хүснэгт 10*)

Хүснэгт 10. Аялал жуулчлалд гадаргын налууг харгалзах үзүүлэлтүүд

Налуу	Үйл явц	Аялал жуулчлал хөгжүүлэх боломж
3°-аас бага	Тэгш тал ба харьцангуй талархаг, нам доор газрууд хамарна.	Нэн тохиромжтой
3-6°	Уулсын хоорондох хөндий, голын дэнж, татам зэрэг харьцангуй талархаг газрыг хамарна. Ийм хэвгий гадарга бага зэргийн налуу гадаргад тооцогдоно.	Тохиромжтой
6-12°	Аялал жуулчлал хөгжүүлж болох боловч ажлын бүтээмж 10-15%-иар буурдаг.	Дунд зэргийн тохиромжтой
12-20°	Уулархаг нутгаар нэлээд тохиолдох бөгөөд ихээхэн дунд хэрчигдэж бартаатай болсон байдаг. Ийм хэвгий гадарга ашиглах шаардлагатай бол эвдрэлээс хамгаалах нэмэлт байгууламж барих хэрэгтэй.	Тохиромжгүй
20°- дээш	Гадаргын байдал ихээхэн хэрчигдэж бартаа ихтэй тул зөвхөн морин аялалд тогтоосон замналын дагуу явагдана.	Нэн тохиромжгүй

Хөрсөн бүрхэвч Аялал жуулчлал хөгжүүлэхэд хотгор гүдгэрийн хэв шинж, гадаргын бартаа, хэрчигдэл зэргээс гадна аялал жуулчлалд шууд нөлөө бүхий хөрсний бүрэлдэхүүн, үржил шимт гадаргын морфометр шинж, зүсэлтийн хэлбэр зэрэг онцгой үүрэгтэй байдаг. Түүнчлэн хөрсний хэв шинж, түүний бүтэц бүрэлдэхүүн чухал ач холбогдолтой ба хөрсний чанарын үнэлгээ хэдий чинээ сайн байх тусам рекреацийн даац төдий чинээ сайн байна.

Аялал жуулчлалын нөлөөгөөр хөрс элэгдэж эвдрэн хөрсний үржил шимт чанар алдагдан ургамал ургахгүй, амьд организмын амьдрах орчин өөрчлөгдөж улмаар экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүрнэ. Амьд бие организмын амьдрах орчин, ургамлын нөмрөг үүсэж бүрэлдэх суурь нь хөрс учраас рекреацийн даацад хөрсний чанарын үзүүлэлт чухал ач холбогдолтой. Хүний үйл ажиллагаанд удаан хугацаанд ашиглагдсан, эсвэл уур амьсгалын хуурайшилтын нөлөөгөөр органик нь эрдэсэжсэнээр хөрсний үржил шим буурдаг. Рекреацийн даацад хамгийн өртөмтгий эмзэг зүйл бол хөрс, ургамлын бүрхэвч юм. Судалгаагаар хүн зогсож байхдаа газрын гадарга дээр 200 г/см² дарамт үүсгэж байдаг бол явж байхдаа 47 кг/см² хүртэл дарамтыг үүсгэдэг болохыг тогтоосон байдаг.

Гаднаас нь харахад хөрсний эвдрэл нь сүүлчийн шатанд орсны дараа буюу ургамлын бүрхэвч үгүй болж, рекреацийн алдрал бий болсон үед л мэдэгддэг. Хөрсний

жигжиг хэсгүүдийн хооронд хуурайшил ихэссэн хэсэгт элсжилт үүсэн чөлөөтэй шилжиж байдаг. Чийгшил онцгой ихэссэн үед дээд давхарга намагжина. Гишгэлт даралтын дараа хөрсний дээд давхарга нягтарч (10–15 см), түүний нөлөө бүх хэсэгт нь усан хангамж болон тэжээлийн бодисын агууламжид нөлөөлдөг. Нутаг дэвсгэрийн экологийн байдал болон түүнд үзүүлж буй гаднын нөлөөллийн зэрэглэлийг тодорхойлж байдаг гол үзүүлэлт бол хөрсний нягтрал юм.

Газар бүр тухайн нутгийн байгаль газар зүйн онцлогоос хамааран янз бүрийн үржил шимтэй хөрстэй байдаг учраас тухайн газрын хөрсний шинж чанарыг иж бүрэн тусгасан чанарын үнэлгээ хийгдсэн байх ёстой. Хөрсний чанарын үнэлгээ нь хөрсөн дээр тогтворжсон ургамлын бүрхэвч, эдгээрийн уялдаа холбоог илэрхийлэх ландшафтын хэв шинжүүдийн даацыг тодорхойлох гол үндэс юм.

Их Газрын Чулууны БЦГ-ын хөрсний чанарын үнэлгээг 2012 онд Газарзүйн хүрээлэнгийн Хөрс судлалын лабораторид боловсруулсан хөрсний чанарын үнэлгээний стандартаар тогтоов (*Хүснэгт 11*).

Хүснэгт 11. Хөрсний чанарын үнэлгээ

Байгалийн бүс	Хэв шинж, дэд хэв шинж	Хөрсний чанарын үнэлгээ
Уулын цөлөрхөг хээр	Уулын цөлөрхөг хээрийн бор	4.0
	Уулын хээржүү цөлийн бор	3.1
	Уулын цөлийн бор саарал	1.0
Хээрийн бүсийн чанарын үнэлгээ		
Хээр (нам уулс толгод)	Сайр чулуурхаг хар шороон	58.5
	Сайр чулуурхаг хар хүрэн	40.5
	Сайр чулуурхаг хүрэн	25.2
	Сайр чулуурхаг цайвар хүрэн	16.4
	Хүрэн	38.7
	Цайвар хүрэн	23.5
	Цайвар хүрэн хужир мараалаг	16.1
	Элсэн хучаастай цайвар хүрэн	13.2
	Мараалаг цайвар хүрэн	9.6
	Элсэн хүрэн	12.0
Бусад	Хужир мараалаг нугат хүрэн	15.6
	Эвдэрсэн хөрс (хээрийн бүс)	5.0
Цөлжүү хээр	Хужир мараалаг бүрдэл	9.8
	Элсэн хужирлаг	10.6
	Хагас бэхжсэн элс	2.0
	Хөдөлгөөнт элс	0.2

Эндээс үзэхэд рекреацийн үйл ажиллагаа явуулах хамгийн тохиромжтой хэв шинж бол 3°-аас ихгүй налуутай, 5,0-6,0 м хэрчигдлийн шигүүтэй, хөрсний чанар 80 %-иас дээш ургамал бүрхэвч бүхий голуудын уужим тавиу хөндий дагуух аллюви-нугын хөрстэй өлөн-үетэнт, элдэв өвс-үетэнт татмын нугын ландшафтууд юм.

Рекреацийн үйл ажиллагаа явуулахад тохиромжтой хэв шинжид голуудын хөндий рүү түрж орсон 3°-6° налуу бүхий нам уулсаар тохиолдох 4,0-5,0 м хэрчигдлийн шигүүтэй, хөрсний чанар 60-80 %-д хэлбэлзэх, 70-80 %-ийн ургамал бүрхэвч бүхий нам уулсаар тохиолдох уулын карбонатгүй хар шороон хөрсөн дээр тогтворжих элдэв өвс, үет ургамалт ойт болон нугат хээр, ойн бараан хөрсөнд тогтворжсон ойн ландшафтууд хамаарна.

Рекреацийн даацын хувьд дунд зэрэг тохиромжтой хэв шинж бол 5°-8° налуу бүхий дундаж өндөр уулсаар тохиолдох хөрсний механик бүрэлдэхүүн хөнгөн шавранцар, 25-35%-ийн ургамал бүрхэвч бүхий сайр чулуурхаг карбонатгүй хар хүрэн

уулын карбонатгүй хар шороон, сайр чулуурхаг хар шороон, сайр чулуурхаг карбонатгүй хар шороон зэрэг хээрийн хөрсөн дээр тогтворжих үетэн-алаг өвс, алаг өвс-хялганат хээрийн ландшафт юм.

2.2.4. Аялал жуулчлалын даацыг хүрээлэн буй орчин, нийгэм-хүн ам зүйн, улс төр-эдийн засгийн үзүүлэлтээр үнэлсэн үнэлгээ хийсэн арга зүй

ТХГН-ийн аялал жуулчлалын даацыг хүрээлэн буй орчин, нийгэм-хүн ам зүйн, улс төр-эдийн засгийн үзүүлэлтээр тодорхойлдог арга зүйг олон улсад ашигладаг. Аялал жуулчлалын даац, багтаамжийг тооцох үндсэн хүчин зүйлсэд аялан жуулчлах газрын хэмжээ, байгалийн бүс, байгаль болон түүх, соёлын дурсгалт газруудын тоо, жуулчны баазын хүчин чадал, дэд бүтэц, тав тухтай байдал, үйлчилгээ зэрэг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс чухал нөлөө үзүүлдэг.

Аялал жуулчлалаас ТХГН-т үзүүлэх нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүдийг НҮБХХ-ийн “ТХГН-ийн сүлжээг бэхжүүлэх” төслийн хүрээнд 2011 онд боловсруулсан бөгөөд БОАЖЯ-ны Мэргэжлийн Зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан байдаг. Тэрхүү арга зүйн асуулгын дагуу Их Газрын Чулууны БЦГ-ийн байгаль орчин, нийгэм, соёл, эдийн засагт аялал жуулчлалаас үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийсэн.

Тус арга зүйд дараах шалгуур үзүүлэлтүүд багтсан байдаг. Үүнд:

1. *Аялал жуулчлалаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тооцох шалгуур үзүүлэлтүүд:*
 - Аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдаж буй газар
 - Аялал жуулчлалын хөгжлөөс үүдэлтэй газар ашиглалтын хэлбэрт гарч буй өөрчлөлт, хөрсөн бүрхэвчинд гарч буй өөрчлөлт
 - ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазуудын тоо, хоорондын зай
 - Аялал жуулчлалын үйл ажиллагаанд зориулсан газрын менежмент
 - Аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл, түүнээс үүдэн гарах үр дагаврыг бууруулах
 - Тээврийн салбарын үйл ажиллагаанд аялал жуулчлалаас үүдэн гарч буй өөрчлөлт
 - Жуулчны тээврийн хэрэгслийн ашиглалтын төрөл
 - Тухайн тээврийн хэрэгслүүдээр аялал жуулчлалын гол үзмэр газруудад хүрэх боломж
 - Эрчим хүчний хэрэглээ, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих
 - Аялал жуулчлалын үйлчилгээнд ашиглагдаж буй эрчим хүчний төрөл, эрчим хүч хэмнэх хөтөлбөртэй эсэх
 - Сэргээгдэх эрчим хүч хэрэглэдэг эсэх
 - Усны зохистой хэрэглээ, усны нөөц баялгийг хамгаалах
 - Аялал жуулчлалын салбарын усны хэрэглээ
 - Ахуйн хэрэгцээний усны ашиглалт, чанарын нөлөөлөл
 - Борооны усыг цуглуулан ахуйн хэрэглээнд ашигладаг байх, ус хэмнэх арга хэмжээний хөтөлбөртэй эсэх
 - Бохир ус зайлуулах, цэвэрлэх технологи
 - Хог хаягдлын менежмент, дахин боловсруулалт
 - Аялал жуулчлалаас үүдэлтэй хог хаягдлын хэмжээ
 - Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн нөхөрлөл нь хог хаягдлыг дахин боловсруулж ашиглах хөтөлбөртэй буюу ийм хөтөлбөрт хамрагдсан эсэх
 - Биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийн шалгуур

- ТХГН-ийг зорин ирэгсдийн тооны давтамжаас үүдэлтэй биологийн төрөл зүйлийн хомсдол
- Ой бүхий талбай, аялал жуулчлалаас үүдэн ойн санд учирч буй нөлөөлөл
- Аялал жуулчлалын бизнес эрхлэгчид байгалийн унаган төрх, ургамлыг хэвийн байдалд нь байлгах, хамгаалах, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд оролцдог эсэх
- Байгаль хамгаалах үйл ажиллагааны менежмент
 - Бүс нутгийн цогцолбор газар, паркийн бүтээн байгуулалт
 - Аялал жуулчлалын бүс нутагт байгалийн гамшгаас сэргийлэх төлөвлөгөө
 - ТХГН-т явагддаг тусгай сонирхлын аяллаас үүдэлтэй нөлөөллүүд
 - ТХГН-т барьж байгуулсан зочин байршуулах байгууламжийн хүрээлэн буй орчинд ээлтэй байдал
 - Аялал жуулчлалын зорин очих газрууд, голлох үзмэрүүд, зам маршрутын тэмдэг, тэмдэглэгээ
 - Эко аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг дэмждэг эсэх
 - Жуулчдын төлж буй төлбөр татвараас ТХГН-ийн хөгжил ба хамгаалалтад зарцуулах байдал
- 2. Аялал жуулчлалаас эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцох шалгуур үзүүлэлтүүд:
 - Орон нутгийн эдийн засагт оруулах хувь нэмэр
 - Жижиг дунд бизнест оруулах хувь нэмэр
 - Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтэд оруулах хувь нэмэр
- 3. Аялал жуулчлалаас нийгэмд үзүүлэх нөлөөллийг тооцох шалгуур үзүүлэлтүүд:
 - Хүн амын хэт төвлөрөл
 - ТХГН-ийн талаарх хууль дүрмийн мэдээлэл сурталчилгаа
 - Нийгмийн аюулгүй байдал
- 4. Аялал жуулчлалаас соёлд үзүүлэх нөлөөллийг тооцох шалгуур үзүүлэлтүүд:
 - Үндэсний хэв шинж хадгалагдаж буй байдал
 - Уламжлалт соёл болон гаднын соёлын уусалт

Дээрх үзүүлэлтүүдээс аялал жуулчлал төдийлөн хөгжөөгүй байгаа ТХГН-т одоохондоо тооцох шаардлагагүй үзүүлэлтүүдийг хасаж тооцсон.

ТХГН-ийн байгаль, нийгэм соёл, эдийн засагт аялал жуулчлалаас үзүүлэх нөлөөллийг шалгуур үзүүлэлт тус бүрээр үнэлсний дараагаар бүлэг тус бүрээр ерөнхий үнэлгээ гаргаж -3-аас +3 баллаар үнэлсэн (Хүснэгт 12).

Хүснэгт 12. ТХГН-ийн нийгэм, эдийн засагт аялал жуулчлалын үзүүлэх нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүдийг үнэлэх аргачлал

-3	-2	-1	0	1	2	3
сөрөг нөлөө маш их	Сөрөг нөлөө дунд зэрэг	Сөрөг нөлөө багатай	Огт нөлөөгүй	Эерэг нөлөө багатай	Эерэг нөлөө дунд зэрэг	Эерэг нөлөө маш их

2.2.5. Аялал жуулчлалын даац тогтоосон арга зүй

Дэлхийн улс орнууд өөрийн байгаль нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан даацаа тогтоодог бөгөөд аялал жуулчлалын даацыг хамгийн дээд хязгаар ямар байх ёстой гэдэг асуулт өнөөдрийг хүртэл маргаантай хэвээр байна. Тухайлбал хөрс, ургамлын талхагдлын байдал, усны нөөц, бохирдол, наран шарлагын газар гэх мэтээр олон үзүүлэлтийг сонгож 1 га талбайд хэдэн хүн байх боломжтой гэх мэтээр тогтоосон нь бий.

Бид Их Газрын чулууны БЦГ-ын аялал жуулчлалын даацыг “ТХГН-ийн Судалгааны Төв” ТББ-ын ТХГН-уудын аялал жуулчлалын нөөц, даацыг тогтоохдоо баримталдаг арга зүйг ашиглан тооцсон. Ингэхдээ тус цогцолборт газрын батлагдсан маршрут (А хувилбар) болон бидний санал болгож буй шинэ маршрут (Б хувилбар)-аар тус тус физик болон бодит даацыг ялгаатай тооцсон болно.

2.2.6. Рекреацийн нөхцөлийн тааламжийн үнэлгээ хийсэн арга зүй

Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын аялал рекреацийн тааламжийн үнэлгээг хийхдээ доорх үзүүлэлтүүдийг гол болгон сонгон авсан.

- Температурын хувьд тохиромжтой (зуны улиралд 13-20⁰С) хоногийн тоо говийн бүсэд 100 – 120 хоног, ойт хээрийн бүсэд 70 – 90 хоног, уулархаг нутагт 60 хоног байна. Температурын горим 12.2 – 21.7⁰С байх нь хамгийн тохиромжтой гэж тооцсон.
- Голын усны температур 8-16⁰С байвал тохиромжгүй, 17-19⁰С бол дунд зэрэг, 20-24⁰С бол тохиромжтой, 25-27⁰С бол нэн тохиромжтой нөхцөл гэж үзсэн.
- Агаарын чийгийг 56-70% байх нь Монгол орны хувьд нэн тохиромжтой гэж тооцох бөгөөд Говийн бүсэд 50%, тал хээрийн бүсэд 50%, ойт хээрийн бүсэд 65-70%, уулархаг нутагт 70% байна.
- Нарны гийгүүлэх хугацаа говьд 1000 цаг, ойт хээрт 800 цаг байна.
- Рекреацийн үйл ажиллагаанд салхины хурд 6м/сек-ээс илүү, агаарын температур, 0⁰С-аас бага байвал тохиромжгүй гэж тооцсон.
- Хотгор гүдгэрийг үнэлэхэд уулархаг нутаг рекреацийн нөхцөлөөр тохиромжтой ба өндөр уул, дундаж өндөр уул, нам уул, тал гэж үнэлсэн.
- Ургамлын нөмрөгийг үнэлэхдээ тайгын шилмүүст ба навчит ойг хамгийн тохиромжтой гэж тооцсон. Өндөр уулын нуга, нугат хээр нь дараагийн шатлалд орно.
- Гол мөрний сүлжээний нягтшилыг 0,20-0,25 км/км² нэн тохиромжтой гэж үзнэ.
- Орчин үед рекреацийн үйл ажиллагааг дараах хүчин зүйлүүдээр өвөл, зуны улирлын ялгаагаар үнэлсэн. (Даш, Баясгалан, Мандах, 2005). Үүнд:

Хүснэгт 13. Рекреацийн үйл ажиллагааг улирлын ялгаагаар үнэлэх үзүүлэлтүүд

№	Рекреацийн үйл ажиллагааны улирлын хүчин зүйлс	
	Өвөл	Зун
1.	Агаарын температурын тохиромжтой үеийн үргэлжлэх хугацаа	Агаарын температурын тохиромжтой үеийн үргэлжлэх хугацаа
2.	Нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа	Нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа
3.	Салхины горим	Нуур, голын усны дулааны горим
4.	Хотгор гүдгэр	Агаарын харьцангуй чийгшил
5.	Цасан бүрхүүл	Хотгор гүдгэр
6.	Ургамалжилт	Усан хангамж
7.		Ургамалжилт

Байгалийн эдгээр хүчин зүйлсийг үнэлэхдээ хүний биеийн эрүүл мэндийн байдалд нөлөөлөх, амралт сувилал, аялал жуулчлалыг зохион байгуулахад нөлөөлөх үзүүлэлтүүд гэж 2 хувааж үздэг. Хүний биеийн эрүүл мэндэд нөлөөлөх үзүүлэлтэд агаарын температур, нуур, голын усны горим, харьцангуй чийгшил, нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа, салхины горим орно. Амралт сувилал, жуулчлалыг хөгжүүлэх, зохион байгуулахад нөлөөлөх үзүүлэлтэд газрын гадарга, өндөр, намын байдал, хэрчигдэл, ургамалжилт, ус зүйн сүлжээ зэрэг орно. Үнэлгээг Олон улсад хэрэглэгдэж буй шалгуурыг баримтлан хийлээ.

Тухайн газар дахь тааламжийн үнэлгээг олох томъёо:

$$K = \sum A_n / n$$

K- байгалийн нөхцөлийн тааламжийн итгэлцүүр

n- үзүүлэлт

$\sum A_n$ – үзүүлэлтүүдийн онооны нийлбэр

Тааламжтай нөхцөлийн үнэлгээг тохирох нэгжүүдэд 0-4 баллаар үнэлэх бөгөөд 4 рүү тэмүүлэх тусам тааламжтай байдлыг илтгэнэ. Хэрэв 3-4 балл бол нэн тааламжтай, 2-3 балл бол тааламжтай, 1-2 балл дунд зэргийн тааламжтай, 0-1 балл бол тааламж муутай байна.

2.2.7. Аялал-рекреацийн чадавхын нэгдсэн үнэлгээ хийсэн арга зүй

Их Газрын Чулууны БЦГ-ын байгалийн аялал рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/200 тоот тушаалаар батлагдсан “Байгалийн аялал, рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтүүд”-ийг ашиглан дараах арга зүйгээр хийсэн болно.

Нутаг дэвсгэрийн аялал-рекреацийн үнэлгээ хийх эхний үе шат нь байгалийн нөхцөл байдлыг судлахаас эхэлдэг. Учир нь байгалийн нөөц нь аялал рекреацийн нутаг дэвсгэрийн ашиглалтын урьдчилсан нөхцөлүүдийн нэг гол хүчин зүйл, байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийн төдийгүй түүний иж бүрдлийг бүхэлд нь хамардаг онцлогтой. Гол зорилго нь Монгол оронд байгалийн аялал, рекреацид тохиромжтой болон тохиромжгүй бүс нутгийг үнэлэх ажлыг нэгдсэн зааварчилгаагаар хангахад оршино.

Ландшафт–рекреацийн чадавхын үнэлгээнд дараах хүчин зүйлсийг харгалзан үзэж шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлдог.

1. Ландшафтын үнэлгээ

- ✓ Газрын гадаргын аялал рекреацийн үнэлгээ
- ✓ Уур амьсгалын аялал рекреацийн үнэлгээ
- ✓ Гадаргын ус, рашааны аялал рекреацийн үнэлгээ
- ✓ Био-нөөцийн аялал рекреацийн үнэлгээ
- ✓ Ландшафтын гоо зүйн үнэлгээ

2. Байгаль-түүх соёлын дурсгалт газрын үнэлгээ

- ✓ Байгаль түүх соёлын дурсгалт газруудын үнэлгээ
- ✓ Түүх соёлын дурсгалт газруудын үнэлгээ

3. Дэд бүтцийн үнэлгээ

- ✓ Гатлага, зам, даваа, ус, элс, намаг, шавар, сөөгөн ширгэнэ
- ✓ Хот болон байнгын оршин суух газарт ойр эсэх
- ✓ Төхижилтын түвшин

4. Газар ашиглалтын суурь нөхцөлийн үнэлгээ

- ✓ Тариалангийн талбай
- ✓ Одоо байгаа суурин газар
- ✓ Уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай
- ✓ Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн онгон болон онцгой бүс

Тухайн орон нутаг, бүс нутгийн ландшафт, байгаль түүх соёлын дурсгал, дэд бүтэц, газар ашиглалтын онцлогоос хамааран үндсэн болон дэд үзүүлэлтүүдийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтүүдийг нэгтгэн "Байгалийн аялал-рекреацийг хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн үнэлгээ"-г боловсруулна. Байгалийн аялал рекреацийг хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн үнэлгээг 3 шатлалтай ангиллаар нийт 4 үндсэн, 27 дэд үзүүлэлтүүдийг үндэслэн гүйцэтгэнэ.

Хотгор гүдгэрийн аялал, рекреацийн үнэлгээний арга зүй

Газрын гадаргын хотгор гүдгэр нь аялал рекреацийн үйл ажиллагаанд тодорхой үүрэгтэй. Үүнд:

1. Хотгор гүдгэрийн танин мэдэхүйн үүрэг. Энэ нь тухайн газрын гадаргын онцлог байдлаар тодорхойлогдоно.
2. Хотгор гүдгэрийн гоозүйн үүрэг. Энэ нь газар нутгийн гоо зүйн чанар, аялагчдад сэтгэл хөдлөл үүсгэж буй хэмжээгээр илэрхийлэгдэнэ.
3. Хотгор гүдгэрийн технологийн үүрэг. Гуу, жалгын сүлжээний нягтшилаар тодорхойлогдоно.

Тус нутгийн хотгор гүдгэр, тухайлбал гадаргын хэрчигдлийн шигүү, гадаргын хэрчигдлийн гүн, гадаргын налуу нь байгалийн бусад иж бүрдлийнхээ хамт тухайн нутагт рекреацийн үйл ажиллагааг явуулах боломжийг тодорхойлогч гол хүчин зүйл болдог. Улмаар аялал рекреацийн төрлийг нэмэгдүүлэх, эсвэл хязгаарлах нөлөө үзүүлдэг. Тухайлбал, эдгээр нь технологийн маш чухал хүчин зүйл бөгөөд рекреацийн төрөл бүрийн барилга байгууламж, амралт, сувиллын газрууд, жуулчны бааз, хүүхдийн зуслан зэрэг байгууламжийг байршуулахад нөлөөлөх тул уулын чулуулаг, түүний бүтэц, жуулчны тээврийн хэрэгслийн туулах чадвар, аюулгүй ажиллагааг хангах магадлал зэргийг сайн тооцох шаардлагатай юм. Энэ нь рекреацийн үйл ажиллагаа дахь эрсдэлийг багасгана.

Газрын гадаргын хэрчигдлийн шигүү, гадаргын хэрчигдлийн гүн, гадаргын налууг баллын аргаар дараах байдлаар үнэлнэ (Хүснэгт 14).

Хүснэгт 14. Газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээний шатлал

1. Хэрчигдлийн шигүү		Үнэлгээний балл
Голын голдирол хоорондын болон нам дор газрын хоорондох дундаж зай / метр/		
1000-аас доош		1
1000-2000		2
2000-3000		3
3000-4000		4
2. Хэрчигдлийн гүн		
Хөх нуурын төвшнөөс дээш өргөгдсөн усны хагалбар газрын зонхилох өндөр, м		Үнэлгээний балл
2000-аас дээш		1
1500-2000		2
1000-1500		3
1000-аас доош		4
3. Гадаргын налуу(градус)		
Газрын хэвгийн зонхилох өнцөг / градус/		Үнэлгээний балл
20 ⁰ -аас дээш		1
12 ⁰ -20 ⁰		2
6 ⁰ -12 ⁰		3
6 ⁰ хүртэл		4

Уур амьсгалын аялал, рекреацийн үнэлгээний арга зүй

Уур амьсгалын рекреацийн үнэлгээний шатлал, шалгуурыг үндэсний атласт орсон нар гийгүүлэх хугацаа, агаарын температурын хоногийн дундаж 100 ба түүнээс дээш байх өдөр, агаарын харьцангуй чийгшлийн дундаж, 13 цагт (1-р сар, 4-р сар, 7-р сар, 10-р сар) гэсэн 3 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар дараах хүснэгтийн дагуу хийж гүйцэтгэсэн (Хүснэгт 15).

Хүснэгт 15. Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын уур амьсгалын рекреацийн үнэлгээний шатлал

Зуны аялал-рекреацийн тохиромжтой үеийн үргэлжлэх хугацаа	Үнэлгээний балл
1. Агаарын дундаж температур нэмэх 10⁰-түүнээс давах хоногийн тоо	
70 доош	1
70-90	2
90-110	3
110-аас дээш	4
2. Нар гийгүүлэх хугацаа	
Жилд нар гийгүүлэх цаг	Үнэлгээний балл
2600-аас доош	1
2600-2700	2
2700-2800	3
2800-аас дээш	4
3. Харьцангуй чийгшлийн дундаж утга, 13 цагт /%/	
Харьцангуй чийгийн дундаж утга	Үнэлгээний балл
40-доош ба 90-100	1
40-50 ба 80-90	2
50-60 ба 70-80	3
60-70	4

Дээрх 5 шалгуур үзүүлэлт, дөрвөн шатлалын дагуу хийсэн

Био нөөцийн аялал рекреацийн үнэлгээний арга зүй

Энэхүү үнэлгээг хийхдээ ургамалжилт ба амьтны аялал рекреацийн үнэлгээг дараах шатлал, шалгуураар тус тус хийсэн болно (Хүснэгт 16, 17).

Хүснэгт 16. Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын ургамлын рекреацийн нөөцийн үнэлгээний шалгуур, шатлал

1. Ховор ургамал	
Ховор ургамал	Үнэлгээний балл
Байхгүй	0
1	1
2-3	2
3 дээш	3
2. Ургамалжилт	
Ургамлын хэв шинж	Үнэлгээний балл
Өндөр уулын таг, нуга, намаг, усны ургамал	1
Цөлөрхөг хээр, цөл	2
Хээр	3
Уулын ойт хээр, уулын тайга	4

Хүснэгт 17. Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын амьтны рекреацийн нөөцийн үнэлгээний шалгуур, шатлал

1. Ховор хөхтөн	
Тархсан байдал	Үнэлгээний балл
Байхгүй	0
1	1
2-3	2
3 дээш	3
2. Ховор шувуу	
Тархсан байдал	Үнэлгээний балл
Байхгүй	0
1	1
2-3	2
3 дээш	3

Ландшафт-рекреацийн нэгдсэн үнэлгээний арга зүй

Ландшафт-рекреацийн нэгдсэн үнэлгээгээр ландшафтын болон аялал-рекреацийн хувьд онцгой ач холбогдолтой газруудыг олж тогтоох, ашиглаж байгаа болон ашиглаж болохуйц газруудад учирч буй эрсдэл, энэ эрсдэлийг бууруулах болон арилгах боломж, хүн ам байнга оршин суудаг болон эзэмшигдээгүй нутаг дэвсгэрийн хөгжлийн асуудал, түүнтэй уялдан тухайн газарт аялал-рекреацийн нутаг дэвсгэрийн систем бүрэлдэх урьдчилсан нөхцөлийг илрүүлдэг.

2.3. Их Газрын Чулууны БЦГ-ын аялал жуулчлалын нөөц, даацын үнэлгээ

2.3.1. Ландшафт, газрын бүрхэвчийн ангилал, түүний өөрчлөлтийн үнэлгээ


Их Газрын Чулууны БЦГ-ын ландшафт-газрын бүрхэвчид гарсан өөрчлөлтийг цаг хугацааны 2 үндсэн хэсэгт хуваан, улмаар өөрчлөлтүүдийг нийгэм-эдийн засгийн хүчин зүйлтэй нь холбон судлах зорилтыг дэвшүүлсэн. Тус БЦГ-ын ландшафт-газрын бүрхэвчид гарсан өөрчлөлтүүдийг үндсэн ангилал тус бүрээр нь тооцон гаргаж, түүнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр ландшафтын өөрчлөлтийг хуурай хээр, цөлжүү хээр, хад асга, марз гэсэн үндсэн хэв шинжүүдийн түвшинд тооцон гаргасан (*Хүснэгт 18*).

Хүснэгт 18. Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын ландшафт-газрын бүрхэвчид гарсан өөрчлөлт

№	Үндсэн хэв шинж	Нийт талбайд үндсэн хэв шинжүүдийн эзлэх талбайн хэмжээ /2010 он/		Нийт талбайд үндсэн хэв шинжүүдийн эзлэх талбайн хэмжээ /2021 он/		Өөрчлөлт	
		га	хувь	Га	хувь	га	хувь
1	Цөлжүү хээр	59472.82	33.81	54779.45	31.14	4693.37	2.67
2	Хуурай хээр	79904.90	45.42	90927.60	51.69	-11022.70	6.27
3	Хад асга	36424.94	20.71	29679.25	16.87	6745.69	3.83
4	Шал, хужир марз	103.48	0.06	519.84	0.30	-416.36	0.24
	Нийт дүн	175906.14	100.00	175906.14	100.00		

Ландшафт-газрын бүрхэвчийн өөрчлөлтийн судалгааны үр дүнгээс харахад Их Газрын Чулууны БЦГ-ын хуурай хээрийн талбай 110222.70 га-аар, шал, хужир, марзын талбай 416.36 га-аар тус тус багассан бол цөлжүү хээрийн талбай 4693,37 га-аар, хад

асгын талбай 6745,69 га-аар тус тус нэмэгдсэн байна. Гэвч газрын бүрхэвчийн өөрчлөлт нь ижил төвшний бусад газар нутагтай харьцуулахад дунджаас доогуур буюу доройтолд бага өртсөн хэмээн үзэж болохоор байна (Зураг 14).



Зураг 13. Их Газрын Чулууны БЦГ-ын газрын бүрхэвч

2.3.2. Хүний үйл ажиллагааны нөлөөллийн үнэлгээ

Тус байгалийн цогцолборт газарт нийт 77 байршилд өвөлжөө, 26 байршилд хаваржаа, 4 байршилд зуслан, 15 байршилд намаржаа, 2 байршилд өвөлжөө, хаваржаа, 2 байршилд намаржаа, өвөлжөө, 14 байршилд дөрвөн улирал тус тус бүртгэгдсэн байна (*Хүснэгт 19*). Одоогийн байдлаар (2021 оны 7 сар) Их Газрын Чулуу БЦГ-ын хил дотор жуулчны бааз байхгүй.

Хүснэгт 19. Их Газрын Чулуу БЦГ-ын газар ашиглалтын байдал

№	Өвөлжөө, хаваржаа, зуслан намаржаа	Тоо
1.	Өвөлжөө	77
2.	Хаваржаа	26
3.	Зуслан	4
4.	Намаржаа	4
5.	Намаржаа, өвөлжөө	2
6.	Өвөлжөө, хаваржаа	15
7.	Өвөлжөө, хаваржаа, намаржаа	2
8.	Дөрвөн улирал	14
9.	Замын нийт урт	691.3
10.	Сайжруулсан	229.8
11.	Шороон	461.5
12.	Жуулчны бааз	0
13.	Худаг	115
14.	Булаг	7


Их Газрын Чулууны БЦГ-ын малчин өрхийн бэлчээр ашиглалтын байршлын нөлөөллийг тооцохын тулд өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны байршлын дээрх мэдээллийг ашигласан. Бэлчээрт ашиглагдаж буй газрыг өвөл, хаврын улиралд 2-4 км, зун намрын улиралд 4-6 км радиуст мал бэлчээрлэдэг гэсэн судлаачдын судалгааны үр дүнд үндэслэн тооцож, ArcGis 10.8 Spatial Analyse программаар малын бэлчээрийн орон зайн бүсчлэлийг гаргасан. Нөлөөллийн түвшнийг үнэлэхдээ нөлөөллийг илтгэсэн тэгшитгэлийг Systat программ дээр хүчин зүйлийн анализын аргаар тооцон гаргасан болно (*Зураг 15*).

Их газрын чулуу байгалийн цогцолборт газарт нийт 461.5 км шороон зам гарсан бөгөөд энэ нь ачаалал багатай байнга өөрчлөгдөж байдаг учир шороон замын нөлөөллийн хүрээг 0.25 км-ийн алслагдмалтайгаар 1.0 км-ээр тооцож зурагласан (*Зураг 16*).


Хүний үйл ажиллагааны нөлөөллийн нэгдсэн үнэлгээгээр (*Зураг 17*) Их Газрын Чулууны БЦГ-ын нийт нутаг дэвсгэрийн 5.39% нь хүний үйл ажиллагаанд маш бага өртсөн, 13.12% нь бага, 40.36% нь дунд зэрэг, 21.09% нь хүчтэй, 20.05% нь маш хүчтэй өртсөн байна (*Хүснэгт 20*).

Хүснэгт 20. Их Газрын Чулууны БЦГ-ын хүний үйл ажиллагааны нөлөөлөл


Нөлөөллийн зэрэглэл	Талбай	
	Га	Хувь
Маш бага	9478.08	5.39
Бага	23072.68	13.12
Дунд зэрэг	70999.89	40.36
Хүчтэй	37092.34	21.09
Маш хүчтэй	35263.15	20.05
Нийт дүн	175906.14	100.00



Зураг 14. Их Газрын Чулууны БЦГ-ын бэлчээр ашиглалтын нөлөөлөл



Зураг 15. Их Газрын Чулууны БЦГ-ын авто замын нөлөөллийн зураг



Зураг 16. Их Газрын Чулууны БЦГ-ын хүний үйл ажиллагааны нэгдсэн нөлөөлөл

Их Газрын Чулууны БЦГ-т аялсан дотоодын 200 аялагчдаас 2021 оны 7 сард авсан судалгаанаас үзэхэд байгаль орчинд хүний хүчин зүйлийн сөрөг нөлөөллийг дараах байдлаар үнэлсэн байна (Хүснэгт 21).

Хүснэгт 21. Байгаль орчинд аялал жуулчлалаас үзүүлж буй сөрөг нөлөөлөл

№	Нөлөөллийн үзүүлэлтүүд		Маш их	Их	Дунд	Бага	Маш бага
1	Хог хаягдал	Хүний тоо	48	39	42	30	41
		Хувь	24	19,5	21	15	20,5
2	Усны бохирдол	Хүний тоо	14	17	38	50	81
		Хувь	7	8,5	19	25	40,5
3	Амьтан үргэх, ургамал сүйдэх	Хүний тоо	20	18	35	61	66
		Хувь	10	9	17,5	30,5	33
4	Хөрсний эвдрэл, элэгдэл	Хүний тоо	23	21	53	50	53
		Хувь	11,5	10,5	26,5	25	26,5
5	Агаарын бохирдол	Хүний тоо	9	10	22	46	113
		Хувь	4,5	5	11	23	56,5

Судалгаанаас үзэхэд хүний хүчин зүйлээс байгаль орчинд үзүүлэх хамгийн их сөрөг нөлөөг хог хаягдал 24%, ан амьтан үргэх, ургамал сүйдэх 10%, хөрсний эвдрэл, элэгдэл 11.5% эзэлж байгаа бол хамгийн бага сөрөг нөлөөг агаарын бохирдол 56.5%, усны бохирдол 40.5% эзэлж байна.

2.3.3. Байгалийн ландшафтын иж бүрдлийн эрсдэлийн үнэлгээ

Ландшафтын эрсдэлийг үнэлэх үнэлгээний шалгуур үзүүлэлтээр дараах үзүүлэлтүүдийг сонгон авсан. Үүнд:

- Гадаргын налуу
- Хөрсний механик бүрэлдэхүүн
- Хөрсний элэгдлийн хэв шинж

Их Газрын Чулууны БЦГ-ын хөрсний чанарын үнэлгээг 2012 онд Газарзүйн хүрээлэнгийн Хөрс судлалын лабораторид боловсруулсан хөрсний чанарын үнэлгээний стандарт, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 34 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралтад заасан “Газрын төлөв байдал, чанарын захиалга хянан баталгааны ажлын заавар”-ын дагуу хөрсний ангиллыг харьцуулж, тохируулан хийсэн болно. Тухайлбал, цайвар хүрэн хөрсийг сайр чулуурхаг цайвар хүрэн хөрстэй, нугын хүрэн хөрсийг уулын нугат-хээрийн нарийн ялзмагт хөрстэй, жинхэнэ хүрэн хөрсийг сайр чулуурхаг хүрэн хөрстэй, цөлөрхөг хээрийн бор хөрсийг уулын хээржүү цөлийн бор хөрстэй, нугын хужир хөрсийг хужир мараалаг бүрдэл, аллюви хайрган хөрстэй тус тус тохируулан хийсэн (Хүснэгт 22).

Хүснэгт 22. Их Газрын Чулууны БЦГ-ын хөрсний чанарын үнэлгээ

Байгалийн бүс	Хэв шинж дэд хэв шинж	Хөрсний чанарын үнэлгээ	Их Газрын Чулууны БЦГ-ын хөрсний чанарын үнэлгээ
Уулын тундрийн хөрс	Уулын тундрийн	20.9	
	Уулын нугын	27.0	
	Уулын нугат-хээрийн нарийн ялзмагт хөрс	22.0	22.0
	Уулын нугат бүдүүн ялзмагт	25.9	
Уулын ой тайга	Уулын цэвдэгт	32.3	
	Уулын чандруулаг	24	
	Уулын тайгын ширэгт	34.7	
	Уулын ойн бараан	36.6	

Уулын хээр	Уулын хар шороон	55.6	
	Уулын хар хүрэн	38.2	
	Уулын хүрэн	18.9	18.9
	Уулын цайвар хүрэн	12.1	12.1
Уулын цөлөрхөг хээр	Уулын цөлөрхөг хээрийн бор	4.0	4.0
	Уулын хээржүү цөлийн бор	3.1	3.1
	Уулын цөлийн бор саарал	1.0	
Хээр, нам уулс	Сайр чулуурхаг хар шороон	58.5	
	Сайр чулуурхаг хар хүрэн	40.5	
	Сайр чулуурхаг хүрэн	25.2	25.2
	Сайр чулуурхаг цайвар хүрэн	16.4	16.4
	Ойн элсэн	21.0	
Цөлжүү хээр	Аллюви хайрган	11.2	11.2
	Хужир мараалаг бүрдэл	9.8	9.8
	Элсэн хужирлаг	10.6	
	Хагас бэхэжсэн элс	2.0	
	Хөдөлгөөнт элс	0.2	
Нийт үнэлгээ			122.7

Хүснэгтээс харахад Их Газрын Чулууны БЦГ-ын хувьд рекреацийн үйл ажиллагаа явуулах хамгийн тохиромжтой хэв шинж бол 3°-аас ихгүй налуутай, 5,0-6,0 м хэрчигдлийн шигүүтэй, хөрсний чанар уулын нугат-хээрийн нарийн ялзмагт хөрс (22), сайр чулуурхаг хүрэн хөрс (25,2)-тэй хээр, нам уулсын хэв шинжийн хөрстэй, хээр, цөлөрхөг хээрийн бэлчээрийн өвслөг ургамжилттай газрууд байна. Хөрсний чанарын үнэлгээгээр Их Газрын Чулууны БЦГ нь нийт 122.7 үнэлгээтэй гарсан байна.


Мөн 2014 онд Доктор (PhD) П.Ариунсүрэн, Ж.Миеэгомбо нарын хийсэн “Их Газрын Чулууны БЦГ-ын ургамалжлын судалгаа”-г хөрсний чанарын үнэлгээнд ургамлын бүрхэвчийг тодорхойлоход ашигласан. Ургамлын ландшафт эрсдлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу ургамлын бүрхэвчийн зургийг гаргахад бэлчээрийн даац тодорхой бус байсан тул эрсдлийн үнэлгээний шалгуурт оруулах боломжгүй байсан.

Их Газрын Чулууны БЦГ-ын хөрсний механик бүрэлдэхүүний эрсдлийн үнэлгээ дараах байдалтай байна (Хүснэгт 23).

Хүснэгт 23. Их Газрын Чулуу БЦГ-ын хөрсний механик бүрэлдэхүүний эрсдэлийн үнэлгээ

<i>№</i>	<i>Нөлөөллийн зэрэглэл</i>	<i>Талбайн хэмжээ га</i>	<i>Эзлэх хувь</i>
1.	Маш бага	5245.24	2.98
2.	Бага	2719.64	1.55
3.	Дунд	74803.48	42.52
4.	Хүчтэй	93137.78	52.95
5.	Маш хүчтэй	0.00	0.00
	Нийт	175906.14	100.00

Хөрсний механик бүрэлдэхүүний эрсдэлийн үнэлгээгээр Их Газрын Чулууны БЦГ-ын хөрсний 2.98% нь маш бага, 1.55% нь бага, 42.52% нь дунд, 52.95% нь хүчтэй нөлөөлөлтэй байна (Зураг 18).




Зураг 17. Их Газрын Чулууны БЦГ-ын хөрсний механик бүрэлдэхүүний үнэлгээ

Хүснэгт 24. Их Газрын Чулууны БЦГ-ын ландшафтын эрсдэлийн газрын гадаргын налуугийн үнэлгээ

№	Ангилал	Талбай	Эзлэх хувь
1	Нэн тохиромжтой	1523.21га	0.87%
2	Тохиромжтой	171727.53га	97.62%
3	Дунд зэргийн тохиромжтой	2275.09га	1.29%
4	Тохиромжгүй	352.020га	0.20%
5	Нэн тохиромжгүй	27.93га	0.02%
6	Нийт	175906.14	100%

Газрын гадаргуугийн үнэлгээнээс харахад тус цогцолборт газрын 0.87% нь нэн тохиромжтой, 97.62% нь тохиромжтой, 1.29% нь дунд зэргийн тохиромжтой, 0.2% нь тохиромжгүй, 0.02% нь нэн тохиромжгүй газрууд байна. Нийт нутаг дэвсгэрийн 98.49% буюу дийлэнх газар нутаг нь аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах боломжтой болохыг харуулж байна (Зураг 19).



Зураг 18. Их Газрын Чулууны БЦГ-ын газрын гадаргын налуугийн үнэлгээ

2.3.4. Аялал жуулчлалын даацыг хүрээлэн буй орчин, нийгэм-хүн ам зүйн, улс төр-эдийн засгийн үзүүлэлтээр үнэлсэн үнэлгээ

Байгалийн цогцолборуудыг доройтлоос урьдчилан сэргийлэх, ая тухтай байдлыг алдагдуулахгүй байх үүднээс аялал жуулчлалын даацыг үнэлэх асуудал хурцаар тавигдаж байна. Энэхүү асуудлын үндэс нь аялал жуулчлалын нөлөөллийг экологийн даацын дээд хязгаар буюу байгалийн нөхөн сэргэх чадавхаас давахгүйгээр тогтооход оршино.

Аялал жуулчлалаас ТХГН-т үзүүлэх нөлөөллийн шалгуур үзүүлэлтүүдийг НҮБХХ-ийн “ТХГН-ийн сүлжээг бэхжүүлэх” төслийн хүрээнд 2011 онд боловсруулсан бөгөөд БОАЖЯ-ны Мэргэжлийн Зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан байдаг. Тэрхүү арга зүйн асуулгын дагуу Их Газрын Чулууны БЦГ-ийн байгаль орчин, нийгэм, соёл, эдийн засагт аялал жуулчлалаас үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийсэн (Хүснэгт 25).

Хүснэгт 25. Хүрээлэн буй орчин, нийгэм-хүн ам зүйн, улс төр-эдийн засгийн үзүүлэлтээр сонгож авсан газруудын даацын үнэлгээ

Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ
1. Хүрээлэн буй орчны үзүүлэлтүүд	
Голлох экосистемийн талбай/Нийт талбай	175906 га
Аялал жуулчлалтай холбоотой эрчим хүчний хэрэглээ/орон нутгийн эрчим хүчний хангамжийн хүчин чадал	-3
Аялал жуулчлалын үйлдвэрлэлийн усны хэрэглээ/нийт хэрэглээ	-3
Нийт усны нөөцтэй харьцуулахад АЖ-н салбарын ус ашиглалт	-3
Аялал жуулчлалын оргил улиралд хаях хатуу хог хаягдлын хэмжээ/өдөр	+2
Аялал жуулчлалын оргил улиралд хаях шингэн хог хаягдлын хэмжээ/өдөр	+1
Аялал жуулчлалын оргил улиралд хаях хатуу хог хаягдлын хоногийн хэмжээ/хатуу хог хаягдал цуглуулах болон боловсруулах хүчин чадал/өдөрт	-2
Аялал жуулчлалын оргил улиралд хаях шингэн хог хаягдлын хоногийн хэмжээ/бохир ус цэвэрлэх хүчин чадал/өдөрт	-2
Аялал жуулчлалын зориулалттай барилга байгууламжийн газрын талбай/ нийт барилга байгууламж бүхий талбай	-3
Аялал жуулчлалын нягтшил (Орны тоо/ жуулчны байршуулах байгууламжуудын талбай)	-3
Зорин очих газрын зай болон хүрэх хугацаа /дунджаар Тоног төхөөрөмжийг хүлээх хугацаа: морь, тэмээ хүлээх, музейд нэвтрэхэд зарцуулах цаг г.м	+1
Авто машин байршуулах талбай/өдөрт зорчих машины тоо, дунджаар	+3
Жуулчны урсгал (Жуулчны тоо/нийт хүн ам):	
• Хамгийн их хэмжээ/оргил үед	-1
• хамгийн бага-дундаж хэмжээ	
100 хүн тутамд ноогдох орны тоо	-3
100 хүн тутамд ноогдох зорчигчдын тоо	-2
Жуулчны тоо/гол сайтуудын талбай:	
• оргил үед,	+1
• жуулчны бус улиралд	
Жуулчны тоо/ нийт ТХГН-ийн талбай:	
• оргил үед,	+1
• жуулчны бус улиралд	
Жуулчид/сар (жилийн тархалт)	-1
Ажил эрхлэлт:	
Орон нутгийн ажилчид/Аялал жуулчлалын байгууллага	-3
Нүүдлийн ажилчид/нутгийн нийт хүн ам	-3
Жуулчны сэтгэл ханамж: Жуулчдаас гарсан гомдлын тоо	+2

Аялал жуулчлалын талаар орон нутгийн иргэдээс ирсэн гомдлын тоо /дуу чимээ г.м	+3
Орон нутгийн иргэд аялал жуулчлалаас ашиг хүртэх байдал (Орон нутгийн ажил олгогчид+орон нутгийн ажил эрхэлж буй иргэд/нийт хүн ам)	-3
Аялал жуулчлалын хөгжлөөс шалтгаалан орон нутгийн иргэдийг нүүлгэн шилжүүлсэн байдал	-3
2. Улс төр-эдийн засгийн үзүүлэлтүүд	
Аялал жуулчлалын салбарын нэг хүнд ноогдох орлого	-3
Аялал жуулчлалын салбарын нийт ажил эрхлэлтэд улирлын ажил эрхлэлтийн эзлэх хувь	-3
ТХГН-ийн захиргааны нийт орлогод аялал жуулчлалын эзлэх хувь	-1
Аялал жуулчлалыг хөгжлийг хянах эдийн засгийн болон бусад менежментийн арга хэрэгсэл	-2
Аялал жуулчлалын хөгжилтэй уялдуулан орон нутгийн иргэд, нөхөрлөлийг чиглүүлэх ба чадавхжуулах ажилчид	-2

Хүснэгтээс харахад хүрээлэн буй орчны 23 үзүүлэлтээр үнэлж үзэхэд Их Газрын Чулууны БЦГ нь -19 буюу дундаж үнэлгээ нь -0.82 байна. Харин нийгэм-хүн ам зүйн 5 үзүүлэлтээр -11 буюу дундаж үзүүлэлт нь -2.2 байна. Эдгээрийг харгалзан Их Газрын Чулууны БЦГ-ыг нийт 28 үзүүлэлтээр үнэлэхэд -30, дундаж үнэлгээ нь -1.07 байна. Өөрөөр хэлбэл нийгэм, соёлын болон улс төр-эдийн засгийн нөлөөллийн үнэлгээгээр сөрөг үнэлгээ ихтэй байгаа бөгөөд байгаль, хүрээлэн буй орчны сөрөг нөлөөлөл нь одоогоор харьцангуй бага гарсан байна.

2.3.5. Аялал жуулчлалын даац тогтоох

Бид Их Газрын чулууны БЦГ-ын аялал жуулчлалын даацыг “ТХГН-ийн Судалгааны Төв” ТББ-ын Монгол орны ТХГН-уудын аялал жуулчлалын нөөц, даацыг тогтоохдоо баримталдаг арга зүйг ашиглан тооцсон. Ингэхдээ тус цогцолборт газрын батлагдсан маршрут (А хувилбар) болон бидний санал болгож буй шинэ маршрут (Б хувилбар)-аар тус тус физик болон бодит даацыг ялгаатай тооцсон болно.

А хувилбар (Батлагдсан маршрутаар)

- 1. Физик даац.** Аялагчид автомашинаар ирэх тул нийт Их Газрын Чулууны БЦГ-ын аяллын батлагдсан маршрут нь автомашинаар 19 км, явган 6.2 км зам дагуу явна. Энд тухайн зорьж очиж байгаа үзмэр биш, аяллын улиралд зорьж очих машины тоо, тэдгээрийн хоорондын зай чухал юм. Иймээс 2 машиныг хоорондоо 500 м-ийн зайтай /тоос босох, бороотой үед гулгаа ихтэй зэргийг харгалзан/ гэж тооцож байна. Аялал жуулчлалын улирал жилд 6 сар, зам ирэх буцахын 720км, үзмэр үзэх боломжтой хугацаа 12 цаг, бодитоор жуулчин байх хугацааг 6 цаг гэж тооцвол

$$\text{Эргэлтийн фактор} = \frac{\text{үзвэр үзэх боломжтой хугацаа}}{\text{аялагчийн байх дундаж хугацаа}} = 2 \text{ болно.}$$

Их Газрын Чулууны БЦГ-т газарт аялал жуулчлалын улирлын үеэр буюу 2021 оны 7 сарын байдлаар өдөрт дунджаар 40-50 жуулчин аялж байсан. Тэдгээрийн 10% нь буюу 4-5 хүн морин болон явган аяллаар аялдаг гэж үзвэл физик даац дээр 4-5 аялагчийг нэмж тооцно. Тэгвэл:

Физик /биет/ даац = 19км х 2 авто машин / км х 2 + 5 аялагч = өдөрт 81 аялагч байна.

Физик даац нь тухайн аялал жуулчлалын бүсийн онцлог шинжүүд болох нөлөөллийн хүчин зүйлүүдийг харгалзан энд зөвшөөрөгдөх аялагчид, жуулчдын тооны дээд хязгаарыг илэрхийлдэг.

2. **Бодит даац.** Бодит даацыг тооцохын тулд "нөлөөллийн хүчин зүйлс"-ийг тооцох шаардлагатай.

$$БД = ФД - ЗК_1 - ЗК_2 - \dots - ЗК_n$$

Нөлөөллийн хүчин зүйлс буюу залруулгын коэффициент (ЗК) гэдэг нь биофизик, байгаль орчин, экологи, нийгмийн болон менежментийн хувьсагчид юм. ЗК-ийг хувиар илэрхийлэхийн тулд дээрх томъёог дараах байдлаар харуулж болно:

$$Бод = ФД * \frac{100 - ЗК_1}{100} * \frac{100 - ЗК_2}{100} * \dots * \frac{100 - ЗК_n}{100}$$

Залруулгын коэффициент тухайн газрын онцлогтой холбоотой бөгөөд дараах байдлаар хувиар илэрхийлэгдэнэ:

$$ЗК = \frac{X_{Хяз}}{X_{Нх}} * 100$$

Үүнд:

ЗК = залруулгын коэффициент

Ххяз = хувьсагчийн функцийн хязгаар

Хнх = хувьсагчийн нийт хэмжээ

Бид залруулгын коэффициент болгон замын эвдрэл, зэрлэг ам амьтан үргээх, эндемик амьтан шувууг авч үзсэн.

- 2.1. **Замын эвдрэл:** Үүнд зам дагуух эвдрэлд өртөгдөх байдлыг харгалзана. Нийт замын урт = 19 км (Хнх), дунд зэргийн элэгдэлтэй ховил бүхий зам 3 км, (жигнэх үзүүлэлт-2), ихээхэн элэгдэлтэй ховил бүхий байхгүй гэж үзвэл:

$$Ххяз = 3 \times 2 = 6 \text{ км}, Хнх = 19 \text{ км болно.}$$

Ерөнхийдөө эко аялагчид ирэх боломжтой тул, замын эвдрэх магадлалыг хэт өндрөөр авч үзээгүй. Тэгвэл:

$$ЗК_{эвд} = \frac{6}{19} * 100 = 32\%$$

- 2.2. **Зэрлэг ан амьтад үргээх:** Авто хэрэгсэл, хүн, малын дуу чимээнд эндемик зүйлүүд эмзгээр өртдөг.

$$\text{Залруулгын коэффициент (ЗК)} = \frac{\frac{\text{хязгаартай сарууд}}{\frac{\text{жил}}{12 \text{ сар}}}}{\text{жил}} * 100$$

Тиймээс эндемик болон нүүдлийн шувуудын залруулгын коэффициентийг:

$$ЗК_1 = \frac{1}{9} * 100 = 11.1\%$$

Хөхтөн амьтадын залруулгын коэффициентийг:

$$ЗК_2 = \frac{2}{9} * 100 = 22.2\%$$

БЦГ-т дахь зэрлэг амьтдад сөргөөр нөлөөлөх залруулгын коэффициент

$$ЗК \text{ з.а.} = ЗК_1 + ЗК_2 = 11.1 + 22.2 = 33.3 \text{ буюу } 33\% \text{ байна.}$$

Ачаалал багатай, авто хэрэгслийн тоо цөөн тооцсон тул авто хэрэгслийг хязгаарлах залруулгын коэффициентийг энд тооцсонгүй. Тэгвэл аялал жуулчлалын бодит даац нь

$$\text{Бод} = 81 * \frac{100 - 32}{100} * \frac{100 - 33}{100} = 37$$

Их газрын чулуу байгалийн цогцолборт газарт аялагчдын биет даац өдөрт 81 аялагчид байж болох ба харин зам эвдэхгүйгээр, зэрлэг ан амьтдад ч сөрөг нөлөөгүйгээр аялах боломжтой бодит даац нь өдөрт 37 аялагч байна. Үүнийг аялал жуулчлалын улирлыг жилд 6 сар байдаг гэж үзвэл:

$$\text{Жилд аялах боломжит аялагчдын тоо} = 37 * 30 * 6 = 6660$$

буюу жилд 6660 аялагчдыг тус цогцолборт газраар аялуулах боломжтой юм.

Б хувилбар (санал болгож буй маршрутаар):

Бидний шинээр санал болгож буй маршрут нь автомашинаар 95.2 км, морин ба дугуйн аялал 22.3 км, явган аялал 7.6 км аялах байна гэж үзвэл:

1. Физик /биет/ даац

Физик даац = 95.2 км х 2 авто машин / км х 2 + 5 = 386 өдөрт аялагч

2. Бодит даац. Нийт замын урт = 95.2 км (Хнх), дунд зэргийн элэгдэлтэй ховил бүхий зам = 9,5 км (жигнэх үзүүлэлт-2), ихээхэн элэгдэлтэй ховил бүхий зам байхгүй гэж үзвэл:

$$\text{Ххяз} = 9.5 \times 2 = 19 \text{ км}, \text{ Хнх} = 95.2 \text{ км болж байна.}$$

Эко аялагчид ирнэ гэж үзээд замын эвдрэх магадлалыг хэт өндрөөр авч үзсэнгүй. Тэгвэл:

$$3K_{\text{эвд}} = \frac{19}{95.2} * 100 = 20$$

$$3K \text{ з.а.} = 3K1 + 3K2 = 11.1 + 22.2 = 33.3 \text{ буюу } 33\% \text{ байна.}$$

Тэгвэл аяллын бодит даац:

$$\text{Бод} = 386 * \frac{100 - 20}{100} * \frac{100 - 33}{100} = 206$$

Буюу Их Газрын Чулууны БЦГ-т аялагчдын биет даац өдөрт 386 аялагчид байж болох боловч зам эвдэхгүйгээр, зэрлэг ан амьтдад сөрөг нөлөөгүйгээр аялах боломжтой даац нь өдөрт 206 аялагч байна.

2.3.6. Рекреацийн нөхцөлийн тааламжийн үнэлгээ

Хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээ, хэт төвлөрөл, амьдралын боломж, хувийн болон нийтийн тээврийн хэрэгслийн хөгжил, хүн их хотын утаа тоос, дуу чимээ зэрэг нь хүн амын идэвхтэй амралтын хэлбэрүүд болон аялал жуулчлалын хүрээг ихээхэн өргөжүүлэх хүчин зүйл болж байна. Амралт, жуулчлалыг үр ашигтай, зохистой чиглүүлэн хөгжүүлэхэд тухайн нутаг дэвсгэрийн байгалийн нөөц, нөхцөлд рекреацийн үүднээс үнэлгээ өгөх явдал зайлшгүй шаардлагатай (Даш, Баясгалан, Мандах, 2005).

Рекреацийн нөхцөлийн тааламжийн үнэлгээг дараах томъёогоор тооцсон.

$$K = \sum A_n / n$$

Үүнд:

K- байгалийн нөхцөлийн тааламжийн итгэлцүүр

n- үзүүлэлт

$\sum A_n$ – үзүүлэлтүүдийн онооны нийлбэр

Их Газрын Чулууны БЦГ нь рекреацийн тааламжийн үнэлгээгээр дараах байдалтай байна (*Хүснэгт 26*).

Хүснэгт 26. Их Газрын Чулууны БЦГ-ын рекреацийн тааламжийн үнэлгээ

№	Үзүүлэлтүүд	4	3	2	1	0
A1	Дундаж t^0 нь 10 с дээш халах хоногийн тоо	130<	110-130	90-110	70-90	70>
A2	Жилд нар гийгүүлэх хугацаа /цаг/	3200<	3000-3200	2800-3000	2500-2800	2500>
A3	Цэлмэг өдрийн тоо	120<	80-120	60-80	50-60	50>
A4	7-р сарын харьцангуй чийг	60<	40-60	30-40	20-30	20>
A5	30°-аас давж халах өдрийн тоо	10>	10-20	20-30	30-40	40<
A6	Хүйтрэлгүй үргэлжлэх хоногийн тоо	130<	110-130	100-110	70-90	70>
A7	30°-аас бууж халах өдрийн тоо	20>	20-40	40-50	50-70	70<
A8	Хүчтэй салхитай өдөр	10<	10-30	30-40	40-50	50>
A9	Цастай байх хоногийн тоо	50>	50-100	100-130	130-150	150<
A10	Цасны зузаан /см/	5>	5-10	10-15	15-20	20<
A11	Тунадасны хэмжээ /мм/	400<	200-400	100-200	90-100	90>
A12	Голын сүлжээний нягтшил км/км ²	0.1-0.15	0.05-0.01	0.01-0.05	0.01-0	0
A13	Зуны улиралд гадаргын усны дулаан	Бүлээн	Бүлээвтэр	Хүйтэвтэр	Хүйтэн	Их хүйтэн
A14	Замын элс шавар, намгийн байдал	Үгүй	Бага зэрэг	Бий	Бий	Их биш
A15	Газрын гадаргын хотгор гүдгэрийн байдал	Нам уул тал	Нам уул тал	толгодорхог	Өндөр уул	Хэрчигдэл их
A16	Нэн ховор ургамлын зүйл	Их олон	Олон	Нэлээд	Ховор	Үгүй
A17	Нэн ховор, ховор ан амьтны зүйл	Их олон	Олон	Нэлээд	Ховор	Үгүй
A18	Олон улсын хэмжээний хамгаалалттай газар	Их олон	Олон	Нэлээд	Ховор	Үгүй
A19	Улсын тусгай хамгаалалттай газар	Их олон	Олон	Нэлээд	Ховор	Үгүй
A20	Улсын тусгай хамгаалалттай түүх соёлын дурсгал	Их олон	Олон	Нэлээд	Ховор	Үгүй

Эндээс харахад Их Газрын Чулууны БЦГ нь аялал рекреацийн тааламжийн үнэлгээгээр дундаж үзүүлэлт нь 2,1 баллаар үнэлэгдэж байгаа бөгөөд энэ бүс нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахад “тааламжтай” гэж дүгнэж болохоор байна.

2.3.7. Аялал-рекреацийн чадавхын нэгдсэн үнэлгээ

Их Газрын Чулууны БЦГ-ын газрын гадаргын аялал, рекреацийн үнэлгээ

Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын хотгор гүдгэр нь өндөрлөг тал, хотгорыг хамарч түүний гадаад төрх нь үзэсгэлэнт байдлыг бий болгож байна. Их газрын


чулуу байгалийн цогцолборт газрын хотгор гүдгэрийн үнэлгээг хийхдээ газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээг гадаргын хэрчигдлийн шигүү, гадаргын хэрчигдлийн гүн, гадаргын налуу, суурин амралтын газар байгуулах нутаг дэвсгэр гэсэн дөрвөн шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийсэн.

Газрын гадаргын хотгор, гүдгэрийн рекреацийн үнэлгээ хийх үзүүлэлтийн тоон утгыг Р.А.Курушин, Ч.Баяр, Г.Лхасүрэн, Ж.Нацаг нарын “Үндэсний атлас”-т орсон 1:3000000 масштабтай “Гадаргын налуу”, 1:6000000 масштабтай “Гадаргын хэрчигдлийн шигүү”, “Гадаргын хэрчигдлийн гүн” гэсэн газрын зургуудад дүн шинжилгээ хийж, тулгуур материал болгон ашигласан. Эдгээр шалгуур үзүүлэлтүүд, шатлалын дагуу боловсруулсан арга зүйг үндэслэн Их Газрын Чулууны БЦГ-ын хотгор, гүдгэрийн аялал-рекреацийн үнэлгээ хийж, үр дүнг нэгтгэн үзүүлэв (Хүснэгт 27).

Хүснэгт 27. Их Газрын Чулууны БЦГ-ын хотгор, гүдгэрийн аялал, рекреацийн үнэлгээ

Индекс	Хэвшинж	Гадаргын налуу	Хэрчигдлийн шигүү	Хэрчигдлийн гүн	Суурин амралтын газар байгуулах нутаг	Нийт балл	Чанарын үнэлгээ
ЛХШ1	Цөлжүү хээр 100	2	4	2	2	10	Өндөр
ЛХШ2	Заримдаг цөл (107)	1	1	1	1	4	Сул
ЛХШ3	Өмнөд хуурай хээр 92	2	2	2	1	7	Дунд
ЛХШ4	Өмнөд хуурай хээрийн (95, 96)	1	3	1	2	7	Дунд
ЛХШ5	Заримдаг цөл (180)	1	1	1	2	5	Сул
ЛХШ6	Цөлжүү хээр (171)	2	1	1	1	5	Сул
ЛХШ7	Марз 207	1	1	1	1	4	Сул

Их Газрын Чулууны БЦГ-ын хотгор, гүдгэрийн аялал, рекреацийн үнэлгээг гадаргын налуу, хэрчигдлийн шигүү, хэрчигдлийн гүн болон суурин газар байгуулах боломж зэрэг 4 шатлал, 3 шалгуураар үнэлж үзэхэд хотгор, гүдгэрийн аялал, рекреацийн чадавхаараа сул, дунд, өндөр гэсэн 3 бүс нутаг илэрч байна. Нэн өндөр бүс нутаг илрээгүй (Зураг 20).



Зураг 19. Их Газрын Чулууны БЦГ-ын хотгор, гүдгэрийн аялал рекреацийн үнэлгээ

Их Газрын Чулууны БЦГ-ын уур амьсгалын аялал, рекреацийн үнэлгээ

Их Газрын Чулууны БЦГ-ын уур амьсгалын аялал рекреацийн үнэлгээг 1:3000000 масштабтай газрын зургийг тулгуур материал болгон ашиглан хийж, үр дүнг үзүүлээ (Хүснэгт 28).

Хүснэгт 28. Их газрын чулууны БЦГ-ын уур амьсгалын аялал, рекреацийн үнэлгээ

Индекс	Хэвшинж	Нар гийүүлэх хугацаа	Агаарын температурын хоногийн дундаж 10 ба түүнээс дээш байх өдөр	Харьцангуй чийгийн дундаж утга 13 цагт%	Нийт балл	Чанарын үнэлгээ
ЛХШ1	Цөлжүү хээр 100	3	4	1	8	Дунд
ЛХШ2	Заримдаг цөл (107)	4	4	2	9	Өндөр
ЛХШ3	Өмнөд хуурай хээр 92	4	2	2	8	Дунд
ЛХШ4	Өмнөд хуурай хээрийн (95.96)	4	4	2	10	Өндөр
ЛХШ5	Заримдаг цөл (180)	4	3	1	8	Дунд
ЛХШ6	Цөлжүү хээр (171)	4	3	2	9	Өндөр
ЛХШ7	Марз 207	4	4	1	9	Өндөр

Бидний судалгаагаар аялал рекреацийн тохиромжтой хугацаа нь Их Газрын БЦГ-т олон жилийн дунджаар 90-110 хоног байна.

Их Газрын Чулууны БЦГ уур амьсгалын хувьд аялал, рекреацийн чадавх өндөр болон дунд үнэлгээтэй нутгуудад ялгарч байна (Зураг 21).

Их Газрын Чулууны БЦГ-ын ургамалжилтын аялал, рекреацийн үнэлгээ


Их Газрын Чулууны БЦГ-ын ургамалжилтын аялал, рекреацийн үнэлгээний шатлал, шалгуурыг Үндэсний атласт орсон “Ургамлын бүлгэмдлийн хэв шинж”, “Ховор ургамал” гэсэн 2 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар 1:3000000 масштабтай газрын зураг болон 2014 онд доктор П.Ариунсүрэн, Ж.Миеэгомбо нарын хийсэн “Их Газрын Чулууны БЦГ-ын ургамалжлын судалгааны материалыг тулгуур болгон ашиглан хийсэн.

Энэхүү 2 шалгуур үзүүлэлт, 4 шатлалын дагуу хийсэн ургамлын аялал-рекреацийн үнэлгээг баллын аргаар хийж, үр дүнг үзүүлэв (Хүснэгт 29).

Хүснэгт 29. Их Газрын Чулуу БЦГ-ын ургамалжлын рекреацийн үнэлгээ


Индекс	Хэв шинж	Ургамалын бүлгэмдлийн хэв	Ховор ургамал	Нийт балл	Чанарын үнэлгээ
ЛХШ1	Цөлжүү хээр 100	2	0	2	Сул
ЛХШ2	Заримдаг цөл (107)	2	0	2	Сул

ЛХШЗ	Өмнөд хуурай хээр 92	2	1	3	Дунд
ЛХШ4	Өмнөд хуурай хээрийн (95,96)	2	1	3	Дунд
ЛХШ5	Заримдаг цөл (171)	2	0	3	Дунд
ЛХШ6	Заримдаг цөл (180)	2	1	3	Дунд
ЛХШ7	Марз 207	2	0	3	Дунд



**Зураг 20. Их Газрын Чулууны БЦГ-ын уур амьсгалын аялал, рекреацийн
чадавхын үнэлгээ**

Их Газрын Чулууны БЦГ нь ургамалжилтын хувьд аялал, рекреацийн чадавхаараа дунд болон сул гэсэн бүс нутагт ялгарсан (Зураг 22).



Зураг 21. Их Газрын Чулууны БЦГ-ын ургамалжилтын аялал рекреацийн чадавхын үнэлгээ

Их Газрын Чулууны БЦГ-ын амьтны аялал, рекреацийн үнэлгээ

Их Газрын Чулууны БЦГ-ын амьтны аялал, рекреацийн үнэлгээний шатлал, шалгуурыг Үндэсний атласт орсон “Шувууны газар зүйн мужлал, ховор шувуу”, “Хөхтний газар зүйн мужлал, ховор хөхтөн” гэсэн 2 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар 1:3.000.000 масштабтай газрын зураг, “Их газрын чулууны БЦГ-т уулын туруутан амьтдын тооллого судалгаа” (2020 оны 5 сар), “Монгол орны янгир ямааны (*Capra sibirica* /Pallas, 1776) популяцийн митохондрийн ДНХ-ийн судалгаа” Ц.Билгүүн, З.Өнөдбаясгалан, Б. Цэрэндулам нарын хийж гүйцэтгэсэн судалгааны тайланг тулгуур материал болгон хийлээ (*Хүснэгт 30*).

Хүснэгт 30. Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын амьтны рекреацийн үнэлгээ


Индекс	Хэв шинж	Ховор хөхтөн	Ховор шувуу	Нийт балл	Чанарын үнэлгээ
ЛХШ1	Цөлжүү хээр 100	1	0	1	Сул
ЛХШ2	Заримдаг цөл (107)	1	0	1	Сул
ЛХШ3	Өмнөд хуурай хээр 92	2	0	2	Дунд
ЛХШ4	Өмнөд хуурай хээрийн (95,96)	2	1	3	Өндөр
ЛХШ15	Заримдаг цөл (180)	0	1	0	Сул
ЛХШ16	цөлжүү хээр (171)	2	1	3	Өндөр
ЛХШ17	Марз 207	0	1	1	Сул

Их Газрын Чулууны БЦГ-ын хувьд ховор амьтны аялал рекреацийн чадавхын үнэлгээгээр өндөр, дунд, сул гэсэн 3 хэв шинжийн нутаг дэвсгэрүүд ялгарсан бөгөөд нутаг дэвсгэрийг ерөнхийд нь авч үзвэл хойд болон өмнөд хэсэг нь өндөр, дунд хэсэг нь ховор амьтдын аялал рекреацийн чадавхаар дунд гэсэн үнэлгээтэй байна (*Зураг 23*).

Нарийвчлан авч үзвэл цогцолборт газрын “Аялал жуулчлалын I бүс” бүхэлдээ, “Аялал жуулчлалын III” бүсийн дийлэнх хэсэг, “Аялал жуулчлалын II бүс”-ийн зүүн өмнөд үзүүр хэсэг нь ховор амьтдын аялал рекреацийн чадавхаар өндөр бүс нутагт багтаж байгаа бол “Аялал жуулчлалын II бүс”-ийн ихэнх хэсэг нь ховор амьтдын аялал рекреацийн чадавхаар дунд гэсэн үзүүлэлттэй бүс нутагт багтаж байна.

Харин Говь-Угтаал сумын нутаг дэвсгэрт орших Их Газрын Чулууны БЦГ-ын зүүн хойд хэсгийн багахан нутаг дэвсгэр ховор амьтдын аялал рекреацийн чадавхаар сул үнэлгээтэй байна.

Их Газрын Чулууны БЦГ-ын био нөөцийн аялал рекреацийн үнэлгээг тус газрын ургамалжилт болон амьтны аялал рекреацийн нөөцийн үнэлгээгээр гаргасан болно.



Зураг 22. Их Газрын Чулууны БЦГ-ын ан амьтдын аялал рекреацийн чадавхын үнэлгээ

Их Газрын Чулууны БЦГ-ын ландшафт – рекреацийн чадавхын нэгдсэн үнэлгээ


Их Газрын Чулууны БЦГ-ын ландшафтын рекреацийн нэгдсэн үнэлгээг байгалийн иж бүрдлүүдийн үзүүлэлт тус бүрээр хийсэн үнэлгээний үр дүнг нэгтгэж, гаргав (Хүснэгт 31).

Хүснэгт 31. Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын ландшафтын рекреацийн чадавхын нэгдсэн үнэлгээ

Ландшафт		Хотгор гүдгэр		Уур амьсгал		Ургамал		Амьтан		Нийт	
Индекс	Хэв шинж	Балл үнэлгээ	Чанар үнэлгээ	Балл үнэлгээ	Чанар үнэлгээ	Балл үнэлгээ	Чанар үнэлгээ	Балл үнэлгээ	Чанар үнэлгээ	Балл үнэлгээ	Чанар үнэлгээ
ЛХШ1	Цөлжүү хээр 100	10	Өндөр	8	Дунд	2	Сул	1	Сул	21	Өндөр
ЛХШ2	Заримдаг цөл (107)	4	Сул	9	Өндөр	2	Сул	1	Сул	16	Сул
ЛХШ3	Өмнөд хуурай хээр 92	7	Дунд	8	Дунд	3	Дунд	2	Дунд	20	Дунд
ЛХШ4	Өмнөд хуурай хээрийн (95.96)	7	Дунд	10	Өндөр	3	Дунд	3	Өндөр	23	Өндөр
ЛХШ5	Заримдаг цөл (180)	5	Сул	8	Дунд	3	Дунд	0	Сул	16	Сул
ЛХШ6	Цөлжүү хээр (171)	5	Сул	9	Өндөр	3	Дунд	3	Өндөр	20	Дунд
ЛХШ7	Марз 207	4	Сул	9	Өндөр	3	Дунд	1	Сул	17	Сул

Их Газрын Чулууны БЦГ-ын нутаг дэвсгэрийг ландшафт–рекреацийн чадавхийн хувьд сул, дунд, өндөр гэсэн түвшин бүхий 3 бүс нутагт ангиллаа. Өндөр үнэлгээ бүхий бүс нутаг дэвсгэрт цөлжүү хээр (100) болон өмнөд хуурай хээр (95.96)-ийн ландшафтын хэв шинж бүхий цогцолборт газрын хойд болон төвийн хэсгийн нутаг дэвсгэр багтаж байгаа бол дунд үнэлгээ бүхий бүс нутаг дэвсгэрт өмнөд хуурай хээр (92), цөлжүү хээр (171)-ийн ландшафтын хэв шинж бүхий нутаг дэвсгэр, сул үнэлгээ бүхий нутагт заримдаг цөл (107; 180), марз (207) хэв шинж бүхий цогцолборт газрын өмнөд хэсгийн нутаг дэвсгэрүүд тус тус хамрагдаж байна (Зураг 24).

Бидний хийсэн ландшафтын болон байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийн аялал рекреацийн чадавхийн үнэлгээний үр дүнг харгалзан Их Газрын Чулууны БЦГ-ын нутаг дэвсгэрийг аялал рекреацийн чадавхиар ялган бүсчилэх, ашиглалтын хэтийн төлөвийг тодорхойлох боломжтой юм. Ландшафт-рекреацийн нэгдсэн үнэлгээгээр өндөр бүс нутагт байгалийн болон танин мэдэхүй, судалгаа шинжилгээний аяллыг хөгжүүлэх боломжтой бол дунд үнэлгээ бүхий бүсэд түүх соёлын болон нүүдлийн соёл иргэншилтэй танилцах аяллыг хөгжүүлэх боломжтой ба харин сул бүс нутагт нөөц бүтээгдэхүүний судалгаа хийж цаашид хөгжүүлж болох аяллын төрлүүдийг тогтоох шаардлагатай.



Зураг 23. Их Газрын Чулууны БЦГ-ын ландшафт-рекреацийн нэгдсэн үнэлгээ

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

ИХ ГАЗРЫН ЧУЛУУНЫ БЦГ-Т АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА, БАРИМТЛАХ БОДЛОГО, ЗӨВЛӨМЖ

3.1. Их Газрын Чулууны БЦГ-т аялах аялагчдын хэв шинж, хэтийн төлөв

3.1.1. Аялагч, жуулчдын зах зээлийн хэв шинж, эрэлт хэрэгцээ

Их Газрын Чулууны БЦГ-ыг зорин очиж буй аялагчдыг зах зээлийн хувьд ерөнхийд нь гадаадын жуулчид болон дотоодын аялагчид гэж 2 хуваан үзэх боломжтой.

Бид 2021 оны 7 сарын 3-ны өдрөөс 7 сарын 30-ны өдрүүдэд Их Газрын Чулууны БЦГ-т аялагч 200 дотоодын жуулчдаас 18 асуулга бүхий судалгааг анкетын аргаар авч үр дүнг боловсруулсан. Ковид-19 цар тахлаас шалтгаалан энэ жил гадаадын жуулчид хүлээн аваагүй тул тэднээс судалгаа авах боломжгүй байлаа. Дотоодын жуулчдаас авсан судалгааны зарим үр дүнг аялал жуулчлалаас байгаль орчин, нийгэм соёл, эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг тооцсон бол жуулчдын хэв шинжийг тодорхойлох боломжтой хэсгийг энэ хэсэгт оруулсан юм.

Судалгааны үр дүнгээс харахад дотоодын жуулчдын 58.5% нь Улаанбаатар хотоос, 41.5% нь бусад орон нутгаас буюу Дундговь, Говьсүмбэр, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Завхан аймгуудаас тус цогцолборт газрыг зорин очсон байна (График 3).



График 3. Их Газрын Чулууны БЦГ-ыг зорин очих дотоодын жуулчдын харьяалал

Судалгаанд хамрагдсан аялагч, жуулчдыг аяллын зорилгоор нь авч үзвэл 81% нь амарч, зугаалах, 14% нь найз нөхөд, хамаатан садныдаа зочлох, 5% нь бусад шалтгаанаар зорчжээ (График 4).



График 4. Их Газрын Чулууны БЦГ-ыг зорих дотоодын жуулчдын аяллын зорилго

Дотоодын аялагчид Монгол орноороо аялах аяллын хугацааг авч үзвэл 49.5% нь 4-7 хоног, 29.5% нь 1-3 хоног, 19% нь 10-14 хоног аялдаг бол ердөө 2% нь 15 ба түүнээс

дээш хоног аялдаг байна. Тэгвэл Их Газрын Чулууны БЦГ-т ирсэн аялагчдын 63.5% нь 1-3 хоног, 35% нь 4-7 хоног, 1% нь 10-14 хоног, 0.5% нь 15 ба түүнээс дээш хоног аялахаар төлөвлөж ирсэн байна (График 5).



График 5. Монгол орноор аялагч дотоодын жуулчдын аяллын хоног болон Их Газрын Чулууны БЦГ-т аялагчдын аяллын хоногийн харьцуулалт

Эндээс харахад Их Газрын Чулууны БЦГ-т аялагч, жуулчид ихэвчлэн богино хугацаагаар буюу 1-3 хоногийн хугацаагаар тус цогцолборт газраар аялж, хоноглодог байна.

Дотоодын жуулчдын 78.5% нь аяллын хугацаандаа майханд хоноглодог гэсэн бол 2.5% нь найз нөхөд, хамаатан садныдаа, 7% нь жуулчны баазад, 12% нь бусад (авто машин г.м) газарт хоноглодог байна (График 6).



График 6. Дотоодын аялагчдын байршуулах хэрэгслийн сонголт

Их Газрын Чулууны БЦГ-т аялагсдыг тус цогцолборт газарт аялсан давтамжаар нь авч үзвэл 65.5% нь анх удаа ирж байгаа, 25.5% нь 2-3 удаа ирж байгаа, 2% нь 4-6 удаа ирж байгаа бол 7% нь 7 ба түүнээс дээш удаа аялж, амрахаар ирсэн байна. 7 ба түүнээс дээш удаа тус цогцолборт газраар аялж байгаа иргэд нь энэ нутгийн иргэд бөгөөд амралтаараа нутагтаа ирж байгаа хүмүүс байсан (График 7).



График 7. Аялагчдын ирэх давтамж

Их Газрын Чулууны БЦГ-т аялагчдын хувьд 61.5% нь тус цогцолборт газрын тухай мэдээллийг гэр бүл, найз нөхөд, хамаатан садан, хамт олноосоо, 18.5% нь интернэтээс (фэйсбүүк, инстаграм), 17% нь орон нутгийн иргэдээс, 8% нь сонин, сэтгүүл, хэвлэлээс, 4% нь телевиз, радиогоос, 1.5% нь Хамгаалалтын захиргаанаас, 5% нь бусад эх сурвалжаас олж авсан байна (График 8).



График 8. Их Газрын Чулууны БЦГ-аар аялагчдын тус цогцолборт газрын тухай мэдээлэл олж авсан эх сурвалж

Аялагч, жуулчдын хувьд тус цогцолборт газарт аялах хугацаанд хамгийн их таалагдсан зүйл нь байгаль орчин 84%, байгаль хамгаалагч (ажил үүргээ гүйцэтгэж буй байдал, зан харилцаа) 7%, үйлчилгээ (бие засах газар, тэмдэг тэмдэглэгээ) 6.5%, нутгийн иргэд (ахуй амьдрал, зан харилцаа) 2.5% гэсэн хариулт өгсөн байна (График 9).




График 9. Их Газрын Чулууны БЦГ-аар аялагчдад хамгийн их таалагдсан зүйлс

Аялагч жуулчдын 46% нь сүү, цагаан идээ, 31% нь хоолны үйлчилгээ, 26% нь жуулчны баазын үйлчилгээ, 6.5% нь нутгийн иргэдийн гэр буудалд хоноглох, 22.5% морь, тэмээ унуулах үйлчилгээ, 22.5% нь гар урлалын зүйлсийг нутгийн иргэд болон холбогдох байгууллагаас худалдан авах сонирхолтой байна (График 10).



График 10. Аялагч, жуулчдын нутгийн иргэдээс худалдан авахыг хүссэн үйлчилгээ

Аялагчдыг сэтгэл ханамжийн хувьд авч үзвэл 47% нь маш сайхан, 44.5% нь сайхан, 8.5% нь дунд хэмээн тус цогцолборт газраар аялсан сэтгэгдлээ хуваалцсан байна (График 11).



График 11. Их Газрын Чулууны БЦГ-аар аялагчдын сэтгэл ханамж

Тус цогцолбор газрын цэвэрлэгээ, хамгаалалтад зориулж аялагч жуулчдын 15% нь 300 төгрөг, 15% нь 500 төгрөг, 1% нь 800 төгрөг, 42.5% нь 1000 төгрөг хураамж

болгон төлөхөд бэлэн байгаа бол 26.5% нь 1000-аас дээш төгрөг төлөхөд бэлэн хэмээн хариулжээ (График 12).




График 12. Аялагчдын Их Газрын Чулууны БЦГ-ын цэвэрлэгээ, хамгаалалтын үйл ажиллагаанд төлөхөд бэлэн байгаа хураамжийн хэмжээ

Аялагчдын 98% нь тус цогцолборт газрыг үзэж сонирхохыг гэр бүл, найз нөхөд, хамт олондоо санал болгоно гэж хариулжээ (График 13).



График 13. Аялагчдын Их Газрын Чулууны БЦГ-аар аялахыг бусдад санал болгох байдал

Түүнчлэн тус БЦГ-т аялал жуулчлалыг хөгжүүлэхэд ямар ажлуудыг цаашид хийх шаардлагатай талаар аялагч жуулчид өөрсдийн саналыг дараах байдлаар тусгасан байна.

- ✓ Үзмэр болгоны ойролцоо хогийн цэг, хогийн сав байрлуулах
- ✓ Замын тэмдэг, тэмдэглэгээ, хаяг, явах чиглэл заах самбар нэмж байрлуулах, сайжруулах
- ✓ Гарын авлага, танилцуулга бэлтгэж тараах
- ✓ Хүүхэд тоглуулах газар, спортын талбай байгуулах
- ✓ Ундны ус, худаг гаргах
- ✓ Хоолны газар, хүнсний дэлгүүр байгуулах
- ✓ Тог цахилгаан, интернэттэй болох
- ✓ БЦГ-ыг хашиж хамгаалах
- ✓ Жуулчны бааз, үйлчилгээний цогцолбор барих
- ✓ Хөтөч тайлбарлагчтай болох
- ✓ Бие засах газар нэмж байгуулах
- ✓ Эмийн ургамал болон гар урлалын зүйлс худалдаалах
- ✓ Дэд бүтцийг сайжруулах
- ✓ Ан амьтдыг өсгөн үржүүлэх, хамгаалах
- ✓ Амрах сандал, сүүдрэвч барих
- ✓ Аяллын маршрут бүхий газрын зураг гаргах

- ✓ Нутгийн брэндийг бий болгох, орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах
- ✓ Зам засах
- ✓ Хиймэл нуур байгуулах, тохижуулах, мод тарих
- ✓ Буудаллах газрыг үзмэрээс зайтай байгуулах
- ✓ Мэдээлэл сурталчилгааг сайн хийх

Дээрх судалгааг дүгнэж үзэхэд Их Газрын Чулууны БЦГ-ыг зорин очих дотоодын жуулчдын 60 орчим хувь нь Улаанбаатараас очдог бол 40% нь орон нутгийн аялагчид байдаг байна. Аялагчдын 81% нь амарч, зугаалах зорилгоор тус цогцолборт газрыг зорьдог бөгөөд 63.5% нь 1-3 өдрийг тус газарт өнгөрүүлдэг байна. Ирж буй жуулчдын дийлэнх хэсэг нь буюу 65.5% нь анх удаа тус газраар аялсан ба 91.5% нь үзэсгэлэнтэй өвөрмөц байгальд сэтгэл ханамж өндөр байгаагаа илэрхийлжээ.

Дотоодын аялагчдын 78.5% нь майханд хоноглохыг илүүд үздэг учир Их Газрын Чулууны БЦГ-т цаашид отоглох цэгийг нэмж байгуулах, жуулчны баазыг байгуулахдаа жуулчдын хэтийн төлөв, чиг хандлагыг харгалзан үзэх нь зүйтэй юм. Түүнчлэн ирсэн аялагчдын 18.5% нь л интернэт орчноос мэдээлэл авсан гэснээс харахад уг эх сурвалжийг ашиглан мэдээлэл, сурталчилгааг сайжруулах хэрэгтэй юм.

Хэдийгээр аялагчдад цогцолборт газрын байгаль орчин ихээр таалагдсан бөгөөд 98% нь бусдад тус газрыг санал болгоно гэжээ. Гэвч орон нутгийн иргэдийн сүү, цагаан идээний худалдаа болон байр, хоолны үйлчилгээ зайлшгүй шаардлагатай байгаа нь жуулчдын эрэлт хэрэгцээнээс харагдаж байна.

Түүнчлэн 69% нь цогцолборт газрын хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээнд зориулж 1000 болон түүнээс дээш төгрөгийн хураамж төлөхөд бэлэн байгаагаас харахад ТХГН-ийн нөхөн сэргээлт, хамгаалалт, бусад үйлчилгээнд зориулж хураамжийг нэмэгдүүлэх нь зүйтэй болох нь харагдаж байна.

3.1.2. Их Газрын Чулууны БЦГ-т аялах аялагч, жуулчдын хэтийн төлөв

Дэлхийн II дайн дууссаны дараагаас дэлхийн эдийн засаг сэргэхийн хамт хүн амын өсөлт, орлого нэмэгдэж аялал жуулчлалын салбар аажмаар сэргэж хөгжиж эхэлсэн. 1950-иад онд дэлхийн хэмжээнд жилд 25 сая жуулчин аялж байсан бол 1970 он гэхэд дэлхийн хэмжээнд 166 сая жуулчин аялж өсөлт эрс нэмэгдсэн.



Зураг 24. Олон улсын аялал жуулчлалын 1950-2030 онд хүрэх төлөв байдал

Эх сурвалж: Дэлхийн аялал жуулчлалын байгууллага

Тэгвэл 2019 онд 1.5 тэрбум хүн аялал жуулчлал хийж энэ статистик 2030 он гэхэд 1.8 тэрбум жуулчинд хүрнэ (Зураг 25) гэсэн төлөв байдал ажиглагдаж байсан боловч Ковид-19 цар тахалтай холбоотой 2020-2021 онуудад олон улсын аялал жуулчлал эрс буурсан ч эргээд өсөх болно хэмээн судлаачид үзэж байна.

2019 оны байдлаар олон улсын нийт аяллын 55% амралт чөлөөт цаг, 28% эрүүл мэнд, шашин мөргөл, 16% нь бизнес ажил хэрэг, 6% нь бусад төрлийн зорилгоор хийгдсэн байна. Аяллын 59% нь нислэг, 35% нь автомашин, 1% нь галт тэрэг, 5% нь усан онгоцоор тус тус явагджээ.

2019 онд Монгол улсад айлчилсан гадаадын жуулчдаас түүврийн аргаар авсан судалгаагаар гадаадын аялагч, жуулчдын сонирхол дараах байдалтай байсан байна. (Хүснэгт 32)

Хүснэгт 32. Монголд ирсэн гадаадын жуулчдын сонирхдог зүйлс

	<i>Монголд ирэхээс өмнө хийхийг хүсэж байсан</i>	<i>Хийж үзээд сэтгэл хангалуун байна</i>	<i>Дараа ирэхдээ хийж үзнэ</i>
<i>Зэрлэг, онгон байгаль</i>	256	290	254
<i>Байгальд алхах</i>	188	207	207
<i>Морь унах</i>	243	253	204
<i>Монгол хоол идэх</i>	237	271	161
<i>Дэлгүүр</i>	174	201	120
<i>Музей, үзвэр</i>	141	173	135
<i>Соёл</i>	218	209	170
<i>Наадам</i>	144	80	236
<i>Спорт</i>	90	73	174
<i>Гэр</i>	234	300	175
<i>Дуу</i>	174	218	156
<i>Чингис Хаан</i>	146	111	121
<i>Бусад</i>	22	18	19

Эх сурвалж: Монголд аялсан гадаадын жуулчдаас авсан Монгол банкны судалгааны дүн

Дээрх судалгаануудаас харахад Их Газрын Чулууны БЦГ нь байгалийн онцлогоороо цаашид жуулчдын анхаарлыг татах бүрэн боломжтой юм.

Их Газрын Чулууны БЦГ-т аялсан гадаад, дотоодын жуулчид 2014-2020 онуудад дунджаар 11.3 хувиар өссөн байна. Ирэх 5 жилд тухайн бүс нутагт зорчигчдын харьцангуй өсөлтийн хувийг регрессийн тэгшитгэлээр бодож үзэхэд дараах байдалтай байна (Хүснэгт 33).

Хүснэгт 33. Нийт жуулчдын тоог тэгшитгэлийн X утгад шилжүүлсэн байдал

ОН	ДОТООД ЖУУЛЧИД	ГАДААД ЖУУЛЧИД	НИЙТ	X ₁	X ₂
2014	240	56	296		
2015	545	95	640	0.559633028	0.410526
2016	320	82	402	-0.703125	-0.15854
2017	480	90	570	0.333333333	0.088889
2018	348	167	515	-0.379310345	0.461078
2019	489	327	816	0.288343558	0.489297
2020	1170	0	1170	0.582051282	0

Үүнийг,

$$Y = a + a_1x_1 + a_2x_2$$

хэлбэртэйгээр регрессийн тэгшитгэлээр авч үзсэн. Stata программын тусламжтайгаар тооцоолол хийж үзэхэд дараах үр дүн гарав (Зураг 26).

. reg y x1 x2						
Source	SS	df	MS	Number of obs = 6		
Model	205565.942	2	102782.971	F(2, 3) = 1.80		
Residual	171057.558	3	57019.186	Prob > F = 0.3061		
Total	376623.5	5	75324.7	R-squared = 0.5458		
				Adj R-squared = 0.2430		
				Root MSE = 238.79		
y	Coef.	Std. Err.	t	P> t	[95% Conf. Interval]	
x1	396.0352	208.5802	1.90	0.154	-267.76	1059.83
x2	-197.5201	403.6848	-0.49	0.658	-1482.225	1087.185
_cons	683.063	128.5825	5.31	0.013	273.8559	1092.27

Зураг 25. Stata программын тооцоолол

2014-2020 оны амрагч, жуулчдын тоог харьцангуй давтамжаар нь тооцоолол хийвэл дээрх регрессийн тэгшитгэл нь

$$Y = 683.063 + 396.0352x_1 - 197.5201x_2$$

хэлбэртэй болов. Эндээс харахад нийт жуулчдын тоонд дотоодын жуулчид эерэг үзүүлэлттэй байгаа бол гадаадын жуулчдын үзүүлэх нөлөө бага байна. 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой гадаадын жуулчдын тоо 0 байгаа нь ч мөн үүнд нөлөөлсөн байна.

Хэрэв 5 жилийн дараах байдлаар урьдчилан таамаглаж үзвэл нийт жуулчдын тоо 1675.6385 буюу 1676 жуулчин болохоор үр дүн гарч байна.

$$Y = 683.063 + 396.0352 \cdot 5 - 197.5201 \cdot 5 = 1675.6385 \approx 1676$$

жуулчин болно. Энэ нь 2014-2020 оны аялагчдын нийт дундажтай харьцуулахад дараагийн 5 жилд 37.58 хувь өсөх боломжтойг харуулж байна. Тус тооцоолол нь зөвхөн ТХГН-т зорчих тасалбар авсан хүмүүсийн тоогоор авч үзсэн тооцоолол бөгөөд үүнийг 60%-иар нэмэгдүүлж үзвэл 2681.6 жуулчин болох юм.

Жуулчдын тоо өсөн нэмэгдэхийн хирээр түүх, соёлын дурсгалт зүйлс, үзмэрүүд, байгаль орчны хамгаалал, экосистемийн зөв зохистой хэрэглээ болон нүүдэлчин ард түмний оролцоо зэргийг ханган ажиллах шаардлагатай. Уур амьсгал, ландшафтын нөхцөл байдлын нөлөөллийг тооцож аяллын үзмэрийн мэдээ мэдээлэл, жуулчдад зориулсан танин мэдэхүйн үйл ажиллагааг оновчтой төлөвлөх нь чухал юм.

3.2. Их Газрын Чулууны БЦГ-ын аялал жуулчлалыг хөгжүүлэх чадавх

3.2.1. Аялагчдыг тогтвортой нэвтрүүлэх Хамгаалалтын Захиргааны хүний нөөцийн чадавх

Их Газрын Чулууны БЦГ-ын Хамгаалалтын захиргаанд хэчнээн аялагчийг өдөр бүр тогтвортойгоор нэвтрүүлэх, хяналт тавих боломж байна вэ гэдгийг бид хүний нөөцийн чадавх буюу ХНЧ гэсэн нэр томъёогоор тодорхойлсон.

ТХГН-ийн Хамгаалалтын Захиргаанаас өөрийн чиг үүргээ оновчтой түвшинд гүйцэтгэх хэрэгцээ шаардлага, хяналтын пост дээр ажиллах ажилтны тоо, дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдал зэргээс шалтгаалан аялал жуулчлалын даац тодорхой хязгаартай байхыг шаардаж байгаа учраас энэхүү үзүүлэлтийг оруулсан.

Өнөөгийн байдлаар Их Газрын Чулууны БЦГ-т аялал жуулчлалын оргил үед хяналт тавьж ажиллах хүний нөөцийн хүрэлцээ 23% байна. Энэ нь 3 байгаль хамгаалагч жуулчны оргил үед тус цогцолборт газарт ажилладаг гэсэн үг ба одоогийн байгаа ХНЧ-г тооцвол:

$$\text{ХНЧ} = 206 \cdot 0.23 = 47.38 \text{ буюу } 47 \text{ машин}$$

л аялал жуулчлалын бүсэд өдөрт оруулж хяналт тавих боломжтой байгааг харуулж байна.

Хэрэв оргил үед ажиллах хүний нөөцийн хүрэлцээг 30% болгож нэмэгдүүлбэл,

$$\text{ХНЧ} = 206 \cdot 0.30 = 61.8 \text{ буюу } 62 \text{ машин}$$

50% болгож нэмэгдүүлбэл,

$$\text{ХНЧ} = 206 \cdot 0.50 = 103 \text{ машиныг}$$

өдөрт тус цогцолборт газраар аялуулах, тэдгээрт хяналт тавих боломжтой болох юм.

Цаашид аялал жуулчлалын үйл ажиллагааг нэмэгдүүлнэ гэж үзвэл хүний нөөцийн хүрэлцээг нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд үүний тулд сайн дурын байгаль хамгаалагчид болон Хамгаалалтын Захиргааны аялал жуулчлалын болон бусад мэргэжилтнүүдийг жуулчны оргил үеүдэд ашиглаж болох юм.

Гэвч тээврийн хэрэгслийг хэт олноор нэвтрүүлэх нь зэрлэг ан амьтдыг стрессүүлж, тэднийг амьдралын хэв маягаа өөрчлөхөд хүргэх, хөрсний эвдрэлийг нэмэгдүүлж болзошгүйг анхаарч, аялал жуулчлалын тодорхойлсон даацыг харгалзан үзэх шаардлагатай.

3.2.2. Хамгаалалтын захиргааны менежментийн чадавх

Хамгаалалтын захиргааны менежментийн чадавхыг маркетинг, үйлдвэрлэл үйлчилгээ, бүтээгдэхүүн, хүний нөөцийн менежмент, менежмент, санхүүгийн чадавх гэсэн үзүүлэлтүүдийг ашиглан тус бүр 5 асуулгаар дүгнэсэн (Хүснэгт 34-39).

Хүснэгт 34. Маркетингийн чадавх

№	Шалгуур асуултууд	Тийм	Үгүй
1.	Цогцолборт газрын талаарх зар сурталчилгаа хүртээмжтэй эсэх?		0
2.	Бусад ТХГН-тай харьцуулахад өрсөлдөх чадвар сайтай эсэх?		0
3.	Аялагч, жуулчдын эрэлт, хэрэгцээ нэмэгдэж байгаа эсэх?	1	
4.	Аялагч, жуулчдаас сэтгэл ханамжийн судалгаа тогтмол авдаг эсэх?		0
5.	Зах зээлд эзлэх хэмжээ өмнөх 5 жилээс өсөх боломжтой эсэх	1	
	Нийлбэр дүн	2	0

Хүснэгт 35. Үйлдвэрлэл, үйлчилгээний чадавх

№	Шалгуур асуултууд	Тийм	Үгүй
1.	Үйлчилгээний нийлүүлэлт тогтвортой эсэх?	1	
2.	Үйлчилгээний чанар нь эко стандартад нийцсэн эсэх		0
3.	Үйл ажиллагааны хүчин чадлыг бүрэн ашиглаж чаддаг эсэх?		0
4.	Байршуулах болон хоол, ундааны үйлчилгээгээр хангагдсан эсэх?		0
5.	Олон улсын болон дотоодын төсөл, хөтөлбөрүүд хэрэгждэг эсэх?	1	
	Нийлбэр дүн	2	0

Хүснэгт 36. Бүтээгдэхүүний чадавх

№	Шалгуур асуултууд	Тийм	Үгүй
1.	Ижил төрлийн бусад ТХГН-ийн бүтээгдэхүүнээс ялгардаг эсэх?		0
2.	Олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгож чаддаг эсэх?		0
3.	Бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ зах зээлд танигдаж чадсан эсэх?	1	
4.	Аялагч, жуулчид бүтээгдэхүүн, үйлчилгээнд сэтгэл ханамжтай эсэх?	1	
5.	Бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртэх боломж	1	
	Нийлбэр дүн	3	0

Хүснэгт 37. Менежментийн чадавх

№	Шалгуур асуултууд	Тийм	Үгүй
1.	Байгууллагын бүтэц, зохион байгуулалт тохиромжтой эсэх?	1	
2.	ТХГН-ийн менежментийн болон аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажилладаг эсэх?	1	
3.	Байгаль хамгаалах болон аялал жуулчлалыг хөгжүүлэх ажилд нутгийн иргэдийн оролцоог хангадаг эсэх?		0
4.	Цэвэрлэгээ болон биотехникийн арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг эсэх?	1	
5.	ТХГН-ийн хэмжээнд тогтмол хяналт тавьж чаддаг эсэх?	1	
	Нийлбэр дүн	4	0

Хүснэгт 38. Хүний нөөцийн чадавх

№	Шалгуур асуултууд	Тийм	Үгүй
1.	Мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээ	1	
2.	Байгаль хамгаалагчдыг ажиллах нөхцөл, техник хэрэгслээр хангаж чадсан эсэх?	1	
3.	Мэргэжлийн чадварлаг удирдлага бий эсэх?	1	
4.	Цалин, урамшууллын систем сайн эсэх?	1	
5.	Хүний нөөцийг тасралтгүй сургаж, хөгжүүлэх боломж бий эсэх?	1	
	Нийлбэр дүн	5	0

Хүснэгт 39. Санхүүгийн чадавх

№	Шалгуур асуултууд	Тийм	Үгүй
1.	Нийт хөрөнгийн өсөлт	1	
2.	Богино хугацаат өр төлбөрийг цаг хугацаанд нь төлж чаддаг эсэх?	1	
3.	Байгаль орчин, ургамал, амьтдыг хамгаалах, таниулах санхүүжилт хангалттай эсэх?		0
4.	Олон улсын болон дотоодын хандив, тусламж, төсөл хөтөлбөрийн шугамаар нэмэлт санхүүжилт, хөрөнгө оруулалт бий эсэх?		0
5.	Төсөв санхүү нээлттэй, ил тод эсэх?	1	
	Нийлбэр дүн	3	

Дээрх үзүүлэлтүүдийн үр дүнг графикаар харуулбал;




График 14. ИГЧБЦГ-ын менежментийн чадавхын шинжилгээний үр дүн

байна (График 14).

Менежментийн чадавхын шинжилгээнээс үзэхэд Их Газрын Чулууны БЦГ-ын хүний нөөцийн менежмент болон байгууллагын менежментийн үйл ажиллагааны чадавх бусад үзүүлэлтүүдийг бодвол хамгийн өндөр байгаа боловч нутгийн иргэдийн байгаль хамгаалал болон аялал жуулчлалын үйл ажиллагаа дахь оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай юм.

Түүнчлэн цаашид сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, ижил төрлийн бүтээгдэхүүн санал болгодог ТХГН-тай өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, аялагч жуулчдаас тогтмол сэтгэл ханамжийн судалгаа авч, үнэлэлт дүгнэлт хийх зэрэг маркетингийн үйл ажиллагаа болон жуулчны бааз, хоолны үйлчилгээний байгууллагыг цогцолборт газрын даацад тохируулан бий болгох, үйл ажиллагааны хүчин чадлаа бүрэн ашиглах, ижил төрлийн бусад хамгаалалттай нутаг дэвсгэрээс өөрийн онцлогоор ялгарах, аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулах, олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрүүдийг татаж ТХГН-т оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг ажлуудад анхаарал хандуулах хэрэгтэй байна.

3.2.3. Аялагч, жуулчдыг хүлээн авах байршуулах хэрэгслийн чадавх, зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Их Газрын Чулууны БЦГ-ын ойролцоо өнөөгийн байдлаар амралт, жуулчны бааз үйл ажиллагаа явуулаагүй байгаа бөгөөд цаашид ямар хүчин чадалтай, хэчнээн жуулчны бааз байгуулах асуудлыг аялал жуулчлалын даацад тохируулан төлөвлөх хэрэгтэй.

Их Газрын Чулууны БЦГ-ын аялал жуулчлалын даацыг А хувилбар (одоогийн батлагдсан маршрут) болон Б хувилбар (санал болгосон аяллын маршрут)-аар тус тус тооцсон бөгөөд тус цогцолборт газарт байгуулах жуулчны баазын тоог санал болгож буй маршрутаар тооцсон Б хувилбарыг үндэслэн дээд тал нь 5 жуулчны бааз байгуулах боломжтой гэж үзлээ.

Аялал жуулчлалын даацыг Б хувилбараар тооцоход биет даац буюу өдөрт хүлээн авах жуулчдын дээд хязгаар 386 хүн, бодит даац буюу замын эвдрэл, ан амьтад үргэх зэрэг нөлөөллийг үзүүлэхгүйгээр аялах жуулчдын тоо 206 хүн байгаа.

Тэгвэл бодит даацаар буюу цогцолборт газарт нөлөө үзүүлэхгүйгээр аялах боломжтой аялагчдын тоо болох 206 аялагчаар 5 жуулчны бааз (дунджаар 40 ортой)-ыг жилийн жуулчны улиралд ажиллах хоногийн тоо болон хүчин чадал ашиглалтын хувиар авч үзвэл дараах байдалтай болно (*Хүснэгт 40*).


Хүснэгт 40. Их Газрын Чулууны БЦГ-т байгуулах боломжтой жуулчны баазын хүчин чадал (жилээр)

Байршуулах байгууллага	Ажиллах хугацаа 150 хоног бол (5, 6, 7, 8, 9 сар)				Ажиллах хугацаа 90 хоног бол (6, 7, 8 сар)				Ажиллах дундаж хугацаа 120 хоног бол (05.15-09.15)			
	Дүүргэлтийн хувь											
	25%	50%	75%	100%	25%	50%	75%	100%	25%	50%	75%	100%
Жуулчны бааз 1 (40 ор)	1500	3000	4500	6000	900	1800	2700	3600	1200	2400	3600	4800
Жуулчны бааз 2 (40 ор)	1500	3000	4500	6000	900	1800	2700	3600	1200	2400	3600	4800
Жуулчны бааз 3 (40 ор)	1500	3000	4500	6000	900	1800	2700	3600	1200	2400	3600	4800
Жуулчны бааз 4 (40 ор)	1500	3000	4500	6000	900	1800	2700	3600	1200	2400	3600	4800
Жуулчны бааз 5	1500	3000	4500	6000	900	1800	2700	3600	1200	2400	3600	4800

(40 ор)												
Нийт баазуудын жилд хүлээн авах жуулчны тоо	7500	1500 0	2250 0	30000	4500	9000	1350 0	18000	6000	12000	18000	2400 0
Нэг жуулчны баазын өдөрт хүлээн авах жуулчны тоо	10	20	30	40	10	20	30	40	10	20	30	40

Дээрх тооцооллоос харвал 40 ортой 5 жуулчны бааз өдөрт хүчин чадлынхаа 25%-ийг ашиглавал 50 хүн, 50%-ийг ашиглавал 100 хүн, 75%-ийг ашиглавал 150 хүн, 100%-ийг ашиглавал 200 хүн хүлээн авах боломжтой. Тэгэхээр 5 бааз бүгд хүчин чадлаа 100% ашигласан ч Их Газрын Чулууны БЦГ-ын өдөрт хүлээн авах боломжтой бодит даац болох 206 хүнээс хэтрэхгүй байна.

Одоогоор Хамгаалалтын Захиргааны зүгээс хуучин үйл ажиллагаа явуулж байсан 2, шинээр байгуулах 4 жуулчны баазыг дараах газруудад төлөвлөсөн байна (Зураг 27).



Зураг 26. Их Газрын Чулууны БЦГ дахь жуулчны баазын төлөвлөлт

Зураг дээр жуулчны баазыг байшингийн дүрсээр зураглан харуулсан бөгөөд баазын төлөвлөлтөд дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

1. Зургаас харахад үйл ажиллагаа явуулахаар төлөвлөгдсөн байгаа баазуудын 50% нь “Аялал жуулчлалын I бүс” дотор, үлдсэн 50% нь тус бүсээс гадна оршиж байна. Ер нь бол БЦГ-т аялал жуулчлалын үйл ажиллагааг хөгжүүлэхдээ аль болох хязгаарлалтын бүс болон орчны бүсэд жуулчны баазуудыг төлөвлөх нь зүйтэй юм. Орчин үед олон улсын жуулчид яг үзмэр дээрээ байрлан хоноглохоос илүүтэй нэг талаас тогтвортой аялал жуулчлалыг дэмжих, нөгөө талаас идэвхтэй аялал хийж адал явдал эрэлхийлэхийг илүүд үзэх болсон. Тиймээс баазуудыг аялал жуулчлалын бүсээс гадна төлөвлөж баазад хоноглосон жуулчид үзмэрт очихын тулд явган аялал, морин болон тэмээн аялал, дугуйн аялал, авто машинтай аялал зэрэг аяллын төрлүүдээс сонгон явдаг болох нь байгаль орчин, хамгаалалттай нутаг дэвсгэрийн экосистемд ач холбогдолтой юм.
2. Түүнчлэн жуулчны төлөвлөгдсөн жуулчны баазууд хэтэрхий нэг дор төвлөрсөн байгааг анхаарах хэрэгтэй. Жуулчны баазыг жуулчдын тухайн цогцолборт газарт хүрэлцэн ирэх зам чиглэл, үзмэрүүдийн байрлал, орон зай, хүрэх боломж, цаг хугацаа, аялал жуулчлалын даац болон бизнесийн ашигтай байдлыг харгалзан тараан байршуулах нь байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлэх нэг гарц болно.

Цаашид тус цогцолборт газрыг зорин ирэх аялагч, жуулчдын тоо нэмэгдэхийн хирээр үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазуудыг өргөжүүлэх, эсвэл даацад тохируулан нэмж байгуулах боломжтой. Гэхдээ өдөрт аялах аялагчдын тоог биет даац буюу физик даац болох 386 хүнээс хэтрүүлэхгүй байх нь чухал юм.

Бидний 2021 оны 7 сард дотоодын жуулчдаас авсан судалгаанаас харахад тэдний дөнгөж 7% нь жуулчны баазад хоноглох хүсэлтэй байгаа бол дийлэнх нь буюу 78.5% нь майханд хоноглохыг илүүд үзсэн байсан. Үүнээс үзвэл бодит байдал дээр дотоодын жуулчдаас гадаадын жуулчид жуулчны баазуудад илүүтэй байрлан хоноглох бөгөөд жуулчны олон бааз байгуулахаас илүү отоглох цэгийг нэмж байгуулах нь зүйтэй юм.

Жуулчны баазын хүчин чадлыг бүрэн ашиглахын тулд баазууд аялагч, жуулчдад санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ сонголт, нэр төрлийг нэмэгдүүлэх, өрсөлдөхүйц үнэ санал болгох хэрэгтэй. Түүнчлэн Их Газрын Чулууны БЦГ-ын Хамгаалалтын Захиргааны зүгээс тус цогцолборт газарт үйл ажиллагаа явуулах жуулчны баазуудад энэхүү тайлангийн 3.3.3. хэсэгт заагдсан Монгол улсын болон олон улсын эко стандарт, шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үйл ажиллагаа явуулахыг шаардах, хяналт тавих хэрэгтэй юм.

3.3. Их Газрын Чулууны БЦГ-ын аялал жуулчлалын нөөц, даацад үндэслэн аялал жуулчлал хөгжүүлэх боломж, зөвлөмж

3.3.1. SWOT-АНР шинжилгээ

Их Газрын Чулууны БЦГ-ын давуу, сул талууд болон боломж, учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох зорилгоор SWOT шинжилгээ хийсэн (*Хүснэгт 41*).

Хүснэгт 41. ИГЧБЦГ-ын SWOT шинжилгээ

Давуу талууд (STRENGTHS)	Сул талууд (WEAKNESSES)
○ Зүүн талаас Дорноговь, баруун талаас Өмнөговь аймгуудын засмал замаас шууд очих боломжтой ○ Олон улсын эвент үйл ажиллагаатай ○ Байгалийн өвөрмөц тогтоцтой ○ Ховор, ховордсон амьтан, ургамалтай	○ Хүний үйл ажиллагааны нөлөөлөл ихтэй (уул, уурхайн машин, технологитой холбоотой хөрсний эвдрэл) ○ Тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа үйлчилгээний байгууллага байхгүй

○ Устсан амьтдыг сэргээн нутагшуулсан	○ Нутгийн иргэд аялал жуулчлалын талаар ойлголт, оролцоо муутай ○ Аяллын бүтээгдэхүүнд бага тусгагддаг ○ Хүний нөөцийн хүрэлцээ муу
Боломжууд (OPPORTUNITIES)	Аюулууд (THREATS)
○ ТХГН-д экологийн аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар төрөөс авч буй арга хэмжээ ○ Дотоодын аялагч, жуулчдын тоон өсөлт ○ Эдийн засгийн өсөлт ○ ТХГН-ийг дэмжсэн олон улсын төсөл хөтөлбөр, байгаль хамгаалах үйл ажиллагаа нэмэгдэж байгаа ○ Иргэдийн аялал жуулчлалын боловсрол дээшилж, хог хаягдалгүй, байгаль орчинд ээлтэй аялах болсон	○ Цөлжилт ○ Амьтдын нүүдэллэх хөдөлгөөн ○ Байгалийн гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс ○ Өрсөлдөгчдийн үйл ажиллагааны идэвх ○ Халдварт өвчнөөс болж аялагч жуулчдын тоо буурах

SWOT шинжилгээний аргыг ашиглах нь хүчин зүйлсийн нөлөөллийг тоон бүс утгаар ерөнхийд нь тодорхойлдог учир нэгтгэн дүгнэхэд хүндрэлтэй байдаг. Тиймээс SWOT-АНР аргыг ашиглан тоогоор үл илэрхийлэгдэх шинжтэй үзүүлэлтийг тоон утгад шилжүүлж тэдгээрийг ач холбогдлоор нь эрэмбэлсэн (*Хүснэгт 42*).

Хүснэгт 42. SWOT-АНР шинжилгээний үр дүн

Үе шат	Бүлгийн эрэмбэ	Асуудал	Бүлэгт хамаарах асуудлын эрэмбэ	Нийт асуудлын эрэмбэ
S	0.512486	Зүүн талаас Дорноговь, баруун талаас Өмнөговь аймгуудын засмал замаас шууд очих боломжтой	0.133	0.068
		Олон улсын эвент үйл ажиллагаатай	0.274	0.140
		Байгалийн өвөрмөц тогтоцтой	0.397	0.203
		Ховор, ховордсон амьтан, ургамалтай	0.147	0.075
		Устсан амьтдыг сэргээн нутагшуулсан	0.049	0.025
W	0.275474	Хүний үйл ажиллагааны нөлөөлөл ихтэй (уул, уурхайн машин, технологитой холбоотой хөрсний эвдрэл)	0.468	0.129
		Тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа үйлчилгээний байгууллага байхгүй	0.268	0.074
		Нутгийн иргэд аялал жуулчлалын талаар ойлголт, оролцоо муутай	0.144	0.040
		Аяллын бүтээгдэхүүнд бага тусгагддаг	0.076	0.021
		Хоноглохоос илүү дайран өнгөрөх аялагч, жуулчдын тоо илүү	0.044	0.012
O	0.137737	Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ	0.314	0.043
		Аялагч, жуулчдын тоон өсөлт (ялангуяа дотоодын аялагчид)	0.373	0.051
		Монголд ирж буй гадаадын жуулчдын эрэлт хэрэгцээ нь онгон байгаль, түүх соёлын дурсгалт зүйлстэй танилцах	0.090	0.012
		ТХГН-ийг дэмжсэн олон улсын төсөл хөтөлбөр, байгаль хамгаалах үйл ажиллагаа нэмэгдэж байгаа	0.148	0.020

		Иргэдийн аялал жуулчлалын боловсрол дээшилж, хог хаягдалгүй, байгаль орчинд ээлтэй аялах болсон	0.075	0.010
Т	0.074303	Цөлжилт	0.468	0.035
		Амьтдын тоо толгойн хорогдол, нутаг сэлгэлт, эндемик амьтан, ургамал устгах	0.268	0.020
		Байгалийн гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс	0.144	0.011
		Өрсөлдөгчдийн үйл ажиллагааны идэвх	0.076	0.006
		Халдварт өвчнөөс болж аялагч жуулчдын тоо буурах	0.044	0.003
SUM				1

SWOT-АНР шинжилгээний үр дүнгээс харахад дараах давуу тал, боломжуудыг бид хамгийн түрүүнд ашиглах хэрэгтэй юм. Үүнд:

1. Их Газрын Чулууны БЦГ-ын хамгийн чухал давуу тал нь байгалийн өвөрмөц тогтоц болон зохион байгуулдаг олон улсын эвент арга хэмжээ байна. Тиймээс эдгээрийг өөрсдийн мэдээлэл, сурталчилгаандаа түлхүү ашиглах, сурталчлах шаардлагатай.
2. Тус цогцолборт газрын ховор, ховордсон амьтан, ургамал нь мөн тухайн газрын онцлог шинж, үнэ цэнийг илэрхийлж байгаа тул тэдгээрийн хамгаалалт, нөхөн сэргээлт, судалгаа шинжилгээний ажлуудыг тогтмолжуулах, үр дүнг нийтэд түгээн дэлгэрүүлж, сурталчлах хэрэгтэй. Түүнчлэн энэ чиглэлээр оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, олон улсын болон дотоодын төсөл, хөтөлбөр, дэмжлэгийг татах тал дээр анхаарал хандуулах нь зүйтэй.
3. Аялагч жуулчдын тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь Их Газрын Чулууны БЦГ-т аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын тоог нэмэгдүүлэх боломжтой байгаа харуулж байна. Хэдийгээр 2020, 2021 онуудад Ковид-19 цар тахалтай холбоотой олон улсын жуулчдын тоо буурсан ч, улс орнууд дахь дотоодын аялал жуулчлал өссөн нь тус цогцолборт газрын хувьд боломж юм. Олон улсын судлаачдын үзэж байгаагаар цар тахлын дараа хурдацтай сэргэх салбараар аялал жуулчлалын салбарыг нэрлэсэн байна. Үүнээс харвал Хамгаалалтын захиргааны зүгээс цогцолбор газрын хэмжээнд тогтвортой эко аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар төлөвлөгөө гаргаж ажиллах нь зүйтэй.
4. Сүүлийн жилүүдэд “Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”, “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдийг батлан гаргаж, аялал жуулчлалын салбарыг стратегийн чухал салбарын нэг хэмээн үзэн анхаарал хандуулах болсон нь цогцолборт газрын хэмжээнд аялал жуулчлалыг зүй зохистой хөгжүүлэхэд дэмжлэг, чиглэл болж байна.

SWOT шинжилгээний үр дүнгээс харахад дараах сул талууд болон учирч болзошгүй аюулд анхаарлаа зайлшгүй хандуулах шаардлагатай байна.

1. Их Газрын Чулууны БЦГ-ын хувьд тус нутаг дэвсгэр дэх хүний үйл ажиллагааны нөлөөллийг бууруулах талаар нэн даруй арга хэмжээ авах шаардлагатай. Тус цогцолборт газрын нийт нутаг дэвсгэрийн 40.36% нь дунд зэрэг, 21.09% нь хүчтэй, 20.05% нь маш хүчтэйгээр хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн байна. Үүнд нөлөөлсөн гол хүчин зүйлс нь авто машины замбараагүй зам болон уул уурхайн машин техникийн тээвэрлэлтийн зам тус хамгаалалттай газрын нутаг дэвсгэрээр дайран өнгөрч байгаа явдал юм. Энэ нь тус нутаг дэвсгэрийг

хөрсний элэгдэл, эвдрэлээс гадна цөлжилт, агаарын бохирдол, тоосжилт, ан амьтад үргэх, ургамал талхлагдах зэрэг сөрөг нөлөөллүүдийг үзүүлэх болно. Тиймээс энэхүү асуудлыг хамгийн түрүүнд шийдвэрлэх шаардлагатай.

2. Цогцолборт газрын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байхгүй байгаа нь хамгаалалттай газар нутгийн ашиглалт, хамгаалалтад эерэг нөлөөтэй хэдий ч жуулчны үйлчилгээний байгууллагууд, ялангуяа байршуулах байгууллага байхгүй байгаа нь аялал жуулчлалын хөгжилд сөрөг нөлөөтэй. Тиймээс тогтоосон аялал жуулчлалын даацад тохируулан жуулчны бааз байгуулах нь зүйтэй.
3. Тус цогцолборт газрын хязгаарлалтын бүс болон аялал жуулчлалын бүсэд оршин суугч иргэд аялал жуулчлалын талаар ойлголтгүй, аялал жуулчлал бол нэмэлт орлогын эх үүсвэр болох талаар мэдлэггүй, түүнд оролцох сонирхолгүй байгаа нь тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд мөн сөрөг нөлөөтэй. Учир нь тогтвортой аялал жуулчлалын нэг чухал элемент бол нутгийн иргэд аялал жуулчлалаас тодорхой үр өгөөжийг хүртэж байх ёстой бөгөөд үүний тулд Хамгаалалтын захиргаанаас тэдэнд чиглэсэн сургалт, уулзалт семинарыг шат дараатай зохион байгуулах, нутгийн иргэдтэй хамтран ажиллах тал дээр анхаарал хандуулах шаардлагатай.
4. Гадаад орчноос учирч болох хамгийн том аюул нь тус цогцолборт газрын нутаг дэвсгэрийн цөлжилтийн асуудал юм. Хамгаалалтын Захиргаанаас энэ тал дээр анхаарч, судалгааны ажлыг эрчимжүүлж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

3.3.2. Өрсөлдөгчийн шинжилгээ

Хэдийгээр улсын хамгаалалтад авсан газар нутаг бүр өөр өөрийн байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан, түүх, соёлын дурсгалт зүйлс, үзэсгэлэнт байгаль бүхий байдаг боловч Их Газрын Чулууны БЦГ-ыг газар зүйн байршлын хувьд болон аялал жуулчлалын нөөцийн хувьд ойролцоо ТХГН-тай харьцуулан СРМ матрицыг ашиглан шинжилгээ хийлээ. Энэхүү матриц нь салбарын гол өрсөлдөгчид болон салбарыг амжилтад хүргэх хүчин зүйлсийг үнэлж, харьцуулсан үзүүлэлтүүдийг илэрхийлнэ (*Хүснэгт 43*)

Хүснэгт 43. СРМ матриц

№	Хүчин зүйлс	Жин	Их Газрын чулуу БЦГ		Бага газрын чулуу БНГ		Их нарт БЦГ	
			Балл	Жинлэ гдсэн оноо	Балл	Жинлэ гдсэн оноо	Балл	Жинлэ гдсэн оноо
1.	Байгалийн нөөц	0.2	4	0.8	3	0.6	4	0.8
2.	Түүх, соёлын нөөц	0.2	4	0.8	1	0.2	4	0.8
3.	Дэд бүтцийн хөгжил	0.15	1	0.15	2	0.3	3	0.45
4.	Хөрөнгө оруулалт	0.15	3	0.45	1	0.15	4	0.6
5.	Жуулчны үйлчилгээний байгууллага	0.08	0	0	4	0.32	3	0.24
6.	Аяллын бүтээгдэхүүн (маршрут)	0.05	3	0.15	2	0.1	4	0.2
7.	Зохион байгуулдаг эвент	0.12	4	0.48	0	0	0	0
8.	Бүсийн аяллын маршрутад тусгагдсан байдал	0.05	2	0.1	2	0.1	4	0.2
	Нийт	1		2.93		1.77		3.29

CRM матрицаас харахад Их Газрын Чулууны БЦГ нь Их Нартын БЦГ-тай харьцуулахад байгалийн болон түүх, соёлын аялал жуулчлалын нөөцийн хувьд адил боловч жуулчны үйлчилгээний байгууллага ажиллаагүй байгаа, олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрүүдэд хамрагдаж хөрөнгө оруулалт татаж чадаагүй, говийн бүсийн аяллын маршрутад харьцангуй бага тусгагдсан байдаг зэрэг талаараа тус БЦГ-аас сул байна. Тиймээс энэ тал дээр анхаарал хандуулах хэрэгтэй.

3.3.3. ТХГН-т нэвтрэх гадаад, дотоод жуулчдын тоо, орлого, зарлагыг тооцох аргачлал

Их Газрын Чулууны БЦГ-т аялах амрагч, жуулчдын тоог нарийн гаргаж мэдээллийн сан бүрдүүлэх нь тус цогцолборт газрын статистик мэдээллийн сан төдийгүй бүс нутаг, улсын аялал жуулчлалын статистик мэдээллийн санг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой. Энэ нь аялал жуулчлалын салбарын судалгаа шинжилгээ хийх, бүс нутгийн болон улс орны аялал жуулчлалын эдийн засгийн загварчлал гаргах, ирээдүйн таамаглалыг тооцох зэрэг ажлуудын судалгааны суурь болж өгнө.

Их Газрын Чулуу БЦГ-т нэвтэрсэн, амарч аялсан гадаад, дотоодын жуулчдын статистик тоон үзүүлэлтийг тооцохдоо Монгол улсын “Аялал жуулчлалын статистик үзүүлэлтийг тооцох аргачлал” (2011)-ыг ашиглах нь зүйтэй.

Тус цогцолборт газрын аялал жуулчлалын статистик үзүүлэлтийг тооцох мэдээллийн эх үүсвэрт дараах зүйлсийг харгалзан үзэж боломжтой.

1. Хяналтын постоор орсон, гарсан гадаад, дотоодын нийт амрагч, жуулчдын тоон мэдээлэл;
2. Аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааны улирал, жилийн албан ёсны статистикийн (“Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны мэдээ”-АЖ-1, “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын 20.. оны ... –р улирлын мэдээ”-АЖ-1а) мэдээлэл;
3. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын жуулчдын дунд хийх түүвэр судалгааны дүн;
4. Хамгаалалтын захиргаанаас гадаад, дотоодын жуулчдын дунд хийх түүвэр судалгааны үр дүн;

Дээрх эх үүсвэрүүдийг ашиглан боловсруулалт хийж дараах үзүүлэлтүүдийг тооцно.

- *Цогцолборт газраар аялах нийт амрагч, аялагчдын тоо.* Үүнийг хяналтын постоор орсон, гарсан аялагч, жуулчдын тоогоор гаргах боломжтой.
- *Аялагч, жуулчдын аяллын зорилго, аяллын төрлийг ангилан гаргана.* Үүнийг Хамгаалалтын захиргаанаас авсан түүвэр судалгаанд үндэслэн гаргах боломжтой.
- *Үйлчилгээ авсан нийт жуулчдын тоо.* Үүнийг аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг жуулчны бааз болон бусад үйлчилгээний байгууллагуудын аяллын улиралд хүлээн авч үйлчилсэн нийт гадаад, дотоодын амрагч, жуулчдын тоогоор гаргах боломжтой (*Хүснэгт 44*). Үйлчилгээ авсан жуулчдын тоог аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тайлант хугацаанд үйлчилгээ авсан жуулчдын тооны нийлбэрээр гаргана.

$$A = \sum_{i=1}^N (Bi + Di)$$

Үүнд:

A – Үйлчилгээ авсан нийт жуулчдын тоо

N – Аж ахуйн нэгж, байгууллагын нийт тоо

Bi – Дотоодын жуулчдын тоо

Di – Гадаадын жуулчдын тоо

Жишээлбэл:

Хүснэгт 44. Их Газрын Чулууны БЦГ-ын үйлчилгээ авсан нийт жуулчдын тоо (2021 оны 3-р улирал)

№	Үйлчилгээний байгууллагын нэр	Үйлчилгээ үзүүлсэн дотоодын жуулчдын тоо	Үйлчилгээ үзүүлсэн гадаадын жуулчдын тоо
1.	Жуулчны бааз 1	78	40
2.	Жуулчны бааз 2	96	62
3.	Жуулчны бааз 3	42	28
4.	Жуулчны бааз 4	85	37
5.	Жуулчны бааз 5	92	58
	Нийт	393	225

$$A = \sum_{i=1}^N (B_i + D_i) = (78+40) + (96+62) + (42+28) \dots\dots\dots + (92+58) = 618$$

- *Нийт орны тоо.* аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны бааз, ангийн отог болон жуулчин хүлээн авч, өөрийн зочид буудал, түр хоноглох байраар хангадаг байгууллага, иргэдийн жуулчид хоноглоход зориулсан, бүх эд зүйлээр тоноглогдсон, дэлгээтэй, үйлчилгээнд бэлэн байгаа орыг хамруулна.
- *Нийт өрөөний тоо.* Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны бааз, ангийн отог болон жуулчин хүлээн авч, өөрийн зочид буудал, түр хоноглох байраар хангадаг байгууллага, иргэдийн жуулчид хүлээн авч байрлуулахад зориулагдсан бэлэн байгаа гэр болон өрөөг хамруулна.
- *Жуулчдад үйлчилгээ үзүүлсэн ор хоногийн тоо.* Жуулчны бааз, ангийн отог болон жуулчин хүлээн авч, өөрийн зочид буудал, түр хоноглох байраар хангадаг байгууллага, иргэдийн хүлээн авсан жуулчин тус бүрд үйлчилсэн ор хоногийн нийлбэр буюу хүлээн авсан жуулчдын тоо болон хоносон хоногийн тооны үржвэрүүдийн нийлбэрээр гаргана.
- *Үйл ажиллагаа явуулсан өдрийн тоо.* Тайлант хугацаанд жуулчдад зориулан үйлчилгээ үзүүлсэн нийт өдрийг ойлгоно. Өөрөөр хэлбэл тухайн тайлант улиралд (2-р улирал, 3-р улирал г.м) ажилласан өдрийн тоо юм. Үйл ажиллагаа явуулсан нийт өдрийн тоог аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын үйлчилгээний газрын төрлөөр ангилан гаргана (*Хүснэгт 45*). Тайлант хугацаанд үйлчилгээ үзүүлсэн нийт өдрийн тоог аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тоонд харьцуулж аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын тухайн хугацаанд үйлчилгээ явуулсан дундаж өдрийн тоог тооцно.

$$\overline{X_2} = \frac{U}{N} = \frac{\sum_{i=1}^N U_i}{N} =$$

Үүнд:

$\overline{X_2}$ – Үйлчилгээ үзүүлсэн дундаж өдрийн тоо

N – Аж ахуйн нэгж байгууллагын тоо

U_i – Үйлчилгээ үзүүлсэн нийт өдрийн тоо

Жишээлбэл:

Хүснэгт 45. Их Газрын Чулууны БЦГ-ын аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа явуулсан нийт өдрийн тоо (2021 оны 3-р улирал)

№	Үйлчилгээний байгууллагын нэр	Үйлчилгээ явуулсан нийт өдрийн тоо
1.	Жуулчны бааз 1	98
2.	Жуулчны бааз 2	120
3.	Жуулчны бааз 3	90
4.	Жуулчны бааз 4	85
5.	Жуулчны бааз 5	130
	Нийт	523

$$\overline{X_2} = \frac{U}{N} = \frac{\sum_{i=1}^N U_i}{N} = \frac{98+120+90+85+130}{5} = \frac{523}{5} = 104.6$$

- *Аялал жуулчлалын салбарын ажилчдын тоо.* Тайлант хугацаанд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдэд ажиллаж буй бүх төрлийн мэргэжилтэй ажилчдыг оруулна.
- *Аялал жуулчлалын салбарт ажиллаж буй аялал жуулчлалын мэргэжилтний тоо.* Тайлант хугацаанд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдэд ажиллаж буй аялал жуулчлалын мэргэжилтэй (аялал жуулчлалын менежер, хөтөч тайлбарлагч, орчуулагч г.м) ажилчдыг хамруулна. Үүнээс хөтөч, тайлбарлагчийн тоог тусад нь гаргана.
- *Аялал жуулчлалаас орох орлого.* ТХГН-т аялж буй гадаад, дотоодын жуулчдын аливаа үйлчилгээ, барааг худалдан авахад зориулан зарцуулсан мөнгөний хэмжээний нийлбэрээр гаргах боломжтой.

Аялал жуулчлалаас орох орлогыг хоёр аргаар тодорхойлж болно.

- 1) Аялал жуулчлалын орлогыг аяллын дундаж зардлаас хамааруулан тооцох. ТХГН-ийн нутаг дэвсгэрт аялал жуулчлал хийж буй жуулчдын тоог (гадаад, дотоодын жуулчдын тоо) аялалд зарцуулсан дундаж хугацаа, хоногт зарцуулсан мөнгөний дундаж хэмжээний үржвэрийн нийлбэр дүнгээр орлогын нийт хэмжээг тооцно.

Аялал жуулчлалын орлого = жуулчдын тоо * аяллын үргэлжлэх дундаж хугацаа * хоногийн дундаж зардал

- 2) Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын жуулчдаас олсон орлогоор тооцох. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын жуулчдаас олсон орлогыг тэдгээр аж ахуйн нэгж, байгууллагын улирлын болон жилийн мэдээнээс авч нэгтгэн гаргана.

- *Аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын жуулчдаас олсон орлого.* Аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын жуулчдад үйлчилгээ үзүүлж олсон орлогыг оруулна.
- *Дотоодын нэг жуулчинд ногдох аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын дундаж орлого.* Тайлант хугацаанд дотоодын жуулчдаас олсон аж ахуйн нэгж, байгууллагын нийт орлогын хэмжээг тухайн хугацаанд үйлчилгээ авсан нийт дотоодын жуулчдын тоонд харьцуулж дотоодын нэг жуулчинд ногдох ААНБ-ын дундаж орлогыг тооцно (*Хүснэгт 46*).

$$\overline{X_{\text{ААНБДО}}} = \frac{O_A}{E_A} = \frac{\sum_{i=1}^N O_{Ai}}{\sum_{i=1}^N E_{Ai}}$$

Үүнд:

$X_{\text{ААНБДО}}$ – Дотоодын нэг жуулчинд ногдох ААНБ-ын дундаж орлого

N – Аж ахуйн нэгж, байгууллагын тоо

O_{Ai} – Дотоодын жуулчдаас олсон ААНБ-ын орлого

E_{Ai} – Дотоодын жуулчдын тоо

Жишээлбэл:

Хүснэгт 46. Их Газрын Чулууны БЦГ-ын дотоодын нэг жуулчинд ногдох аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын дундаж орлого (2021 оны 3-р улирал)

№	Үйлчилгээний байгууллагын нэр	Дотоодын жуулчдаас орсон орлого(мян.төг)	Дотоодын жуулчдын тоо
1.	Жуулчны бааз 1	26500	78
2.	Жуулчны бааз 2	33600	96
3.	Жуулчны бааз 3	18750	42
4.	Жуулчны бааз 4	29430	85
5.	Жуулчны бааз 5	30428	92
	Нийт	138708	393

$$\overline{X_{\text{ААНБДО}}} = \frac{O_A}{E_A} = \frac{\sum_{i=1}^N O_{Ai}}{\sum_{i=1}^N E_{Ai}} = \frac{26500 + 33600 + 18750 + 29430 + 30428}{78 + 96 + 42 + 85 + 92} = \frac{138708}{393} = 352.95$$

- *Аялал жуулчлалын зардал.* Тус ТХГН-т аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын нийт зардлын жуулчидтай холбоотой зардлыг эдгээр аж ахуйн нэгж, байгууллагын улирлын болон жилийн мэдээнээс авч нэгтгэн гаргана.
- *Аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын ТХГН-д аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардал.* Тайлант хугацаанд ТХГН-аар аялуулсан аялалд зарцуулсан ААНБ-ын нийт зардлын хэмжээг тухайн хугацаанд үйлчилгээ авсан дотоодын жуулчдын тоо, гадаадын жуулчдын тооны нийлбэрт харьцуулж ААНБ-ын ТХГН-аар аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардлыг тооцно (*Хүснэгт 47*).

$$\overline{X_{\text{1жндз}}} = \frac{\sum_{i=1}^N Z_{Mi}}{\sum_{i=1}^N (E_{Ai} + E_{Ai})}$$

Хүснэгт 47. Их Газрын Чулууны БЦГ-ын аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагын ТХГН-д аялуулсан аяллын нэг жуулчинд ногдох дундаж зардал (2021 оны 3-р улирал)

№	Үйлчилгээний байгууллагын нэр	ААНБ-ын ТХГН-д аялуулсан аяллын нэг жуулчинд	Дотоодын жуулчдын тоо	Гадаадын жуулчдын тоо
---	-------------------------------	--	-----------------------	-----------------------

		ногдох дундаж зардал (мян.төг)		
1.	Жуулчны бааз 1	10600	78	40
2.	Жуулчны бааз 2	13440	96	62
3.	Жуулчны бааз 3	7500	42	28
4.	Жуулчны бааз 4	11772	85	37
5.	Жуулчны бааз 5	12171	92	58
	Нийт	55483	393	225

$$\overline{X}_{\text{хндэ}} = \frac{\sum_{i=1}^N Z_{Mi}}{\sum_{i=1}^N (E_{Ai} + E_{Ti})} = \frac{10600+13440+7500+11772+12171}{(78+40)+(96+62)+(42+28)+(85+37)+(92+58)} = \frac{55483}{618} = 141.17$$

3.3.4. ТХГН-ийн нөөц, даацын онцлогийг харгалзан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний норм стандартыг тогтоох

Байгаль орчны доройтол, дэлхийн дулааралтай холбоотойгоор байгалийн нөөцийг ашиглах шинэ арга зам нь дэлхий даяар экологийн жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх асуудал гэж үзэж байна. Олон улсын жуулчлалын нийт орлогод эко жуулчлалын орлогын хэмжээ 10 орчим хувийг эзэлж байгаа гэсэн баримт бий. Эко жуулчлалын хөгжил эрчимжиж байгаа өөр нэг хүчин зүйл бол аялал жуулчлалын төвлөрсөн орон зайд амралтын нягтрал нэмэгдэхийн зэрэгцээ хүн амын аж байдал дээшилж улмаар чөлөөт цагийг ухаалаг ашиглах арга сүвийг эрэлхийлж байгаатай холбон тайлбарлаж байна [“Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн үндэс” хуудас 80].

Аливаа нутаг орны амралт, аялал жуулчлалын орон зайн зохион байгуулалтыг боловсронгуй болгохын тулд 1-рт эрэлт, нийлүүлэлт, 2-рт рекреацийн үйлчилгээний менежмент, 3-рт байгалийн нөөц, экологийн менежмент, 4-рт маркетингийн менежмент, 5-рт газар зохион байгуулалт зэрэг асуудлуудыг нэгдмэл байдлаар авч үзэх бодит шаардлага урган гардаг. Иймээс аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ тухайн орон нутгийн байгаль, түүх соёлын нөөц, түүний даацын онцлогийг харгалзан бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөж өгөх нь оновчтой.

Их Газрын Чулууны БЦГ нь экосистемийн хувьд тал хээр, говийн бүсийн хэв шинжийг агуулсан эмзэг бүтэцтэй нутагт тооцогдоно. Аялал жуулчлалын нөөцүүдийн хувьд одоогоор судлагдаад байгаа үзмэрүүдийн 54% нь байгалийн өвөрмөц тогтоцтой байхад 46% нь түүх, соёлын онцлогтой нөөцүүд байгаа нь байгальд түшиглэсэн эко аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтойг харуулж байна.

Байгалийн рекреацийн нэгдсэн үнэлгээний зургаас харахад аялал жуулчлалын 1 ба 3-р бүс нөөц бололцооны хувьд өндөр гарсан байхад 2-р бүс нь дунд ба сул үнэлгээтэй байгаа нь байгаль ландшафтын хувьд өөр өөр онцлогтой аяллыг төлөвлөж, даацыг хэтрүүлэхгүй ашиглах шаардлагыг бий болгож байна. Мөн аялал-рекреацийн үнэлгээ нь амрагч, аялагчдын бие махбод, сэтгэл зүйн таатай орчныг тодорхойлж өгдөг ач холбогдолтой учраас бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэл, стандартыг тогтооход чухал үзүүлэлт нь болдог. Дээрх үндсэн судалгааг харгалзан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг дараах байдлаар төлөвлөлөө (Хүснэгт 48).

Хүснэгт 48. Хүснэгт. Их Газрын Чулууны БЦГ-ын бүсүүдэд хөгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

Дэд бүс	Аялал жуулчлалын үйл ажиллагааны чиглэл		
	Зөвшөөрөх	Хязгаарлах	Хориглох

Орчны бүс	Зохион байгуулалттай тойрон аялал, малчин өрхийн аж ахуй, төрөл бүрийн үйлчилгээний байгууллага, хүүхдийн зуслан	Нийтийн зугаалгын цогцолбор	Ан агнуур, ул хөрсний боловсруулалт бүхий үйлдвэрийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа
Хязгаарлалтын бүс	Зохион байгуулалттай тойрон аялал, малчин өрхөд түшиглэсэн ердийн хөсөгтэй аялал, эко жуулчны бааз, ангийн отог, өрхийн гэр буудал	Хүүхдийн зуслан, нийтийн зугаалгын цогцолбор	Ан агнуур, үйлдвэрийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, олборлох үйлдвэр
Аялал жуулчлалын 1-р бүс	Явган аялал, Эко аялал, ердийн хөсөгтэй аялал, тээврийн хэрэгсэлтэй богино зайн аялал, Бага оврын нисдэг тэрэгтэй аялал	Суурьшил, нөхөрлөлийн эко отог	Ан агнуур, жуулчны бааз, зочид буудал байгуулах, үйлдвэрийн аж ахуйн үйл ажиллагаа
Аялал жуулчлалын 2-р бүс	Тээврийн хэрэгсэлтэй аялал, Эко аялал	Эко жуулчны бааз, зочид буудал, нөхөрлөлийн эко отог	Ан агнуур, үйлдвэрийн аж ахуйн үйл ажиллагаа
Аялал жуулчлалын 3-р бүс	Тээврийн хэрэгсэлтэй богино зайн аялал, эко аялал, Бага оврын нисдэг тэрэгтэй аялал	Эко жуулчны бааз, зочид буудал, нөхөрлөлийн эко отог	Ан агнуур, үйлдвэрийн аж ахуйн үйл ажиллагаа

Эх сурвалж: ИГЧБЦГ-ын байгалийн рекреацийн иж бүрэн үнэлгээ. Эшлэл: “Байгалийн рекреацийн газар зүй” М.Билэгсайхан, Б.Чинбат

Тухайн бүс нутагт эко аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан дотоодын болон олон улсын стандарт, нормыг баримтлан ажиллах шаардлагатай (*Хүснэгт 49*).

Хүснэгт 49. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний стандарт, норм

Үйл ажиллагааны чиглэл	Баримтлах баримт бичиг	Анхаарах зүйлс
Эко аялал	Дэлхийн аялал жуулчлалын ёс суртахууны дүрэм, Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6426 : 2013	Ан амьтан болон цэцэг ажиглах аяллыг мэргэжлийн хөтөчтэй хийх
Ердийн хөсөгтэй аялал	Дэлхийн аялал жуулчлалын ёс суртахууны дүрэм	Орон нутгийн хөтөч, байгаль хамгаалагчийн удирдлагаар аялах
Явган аялал	Дэлхийн аялал жуулчлалын ёс суртахууны дүрэм	Ил гал түлэхгүй, хог хаягдлын менежментийн баримтлах,
Тээврийн хэрэгсэлтэй аялал	Дэлхийн аялал жуулчлалын ёс суртахууны дүрэм, Жуулчны авто тээврийн үйлчилгээ MNS 5231 : 2003	Авто замаар явах, шинээр зам гаргахгүй байх, хог хаягдлын менежмент, зориулалтын авто зогсоолд байрлуулах
Бага оврын нисдэг тэрэгтэй аялал	Дэлхийн аялал жуулчлалын ёс суртахууны дүрэм, Иргэний нисэх нэр томьёо, тодорхойлолт MNS 6409 : 2015	Мэргэжлийн хөтөчтэй явах, Тусгай хамгаалалттай газар нутгаар нислэг хийх зөвшөөрөл авах, Аялал жуулчлалын болон онцгой

		бүсэд буулт хийхгүй байх, ан амьтныг үргээхээргүй өндөрт нислэг хийх
Жуулчны бааз, амралтын газар	Амралтын газар, жуулчны баазад тавигдах ерөнхий шаардлага MNS 6034 : 2019	Зохих зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхлэх
Зочид буудал	Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага MNS 5927 : 2008	Зохих зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхлэх
Хүүхдийн зуслан	Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа, ерөнхий шаардлага MNS 5633 : 2019	Зохих зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхлэх
Эко жуулчны бааз	Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6426 : 2013	Зохих зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа эрхлэх
Өрхийн гэр буудал	Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6426 : 2013	Үйлчилгээний аюулгүй байдлыг ханган ажиллах
Нөхөрлөлийн эко отог	Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6426 : 2013	Үйлчилгээний аюулгүй байдлыг ханган ажиллах, Байгаль хамгаалагчтай хамтран ажиллах
Спорт ангийн отог	Олон улсын стандарт	Ан амьтан ажиглах болон унтуулж зураг авхуулах, судалгаа шинжилгээний ангийн аялал байна.

Эх сурвалж: Монгол улсын стандарт

Орчин үеийн хэрэглэгчид экологийн төлөв байдал, байгаль хамгаалалд анхаарал хандуулж байгааг эх дэлхий гэсэн ёс суртахуун улам төлөвшиж байгаатай холбож тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын бүх төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг эко жуулчлалын хөгжил рүү хандуулж байна. Иймээс Их газрын чулууны байгалийн цогцолборт газарт Хүснэгт 14-д заасан бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэхдээ эко стандартыг баримтлах нь чухал юм. Эко стандарт, эко шошго, батламж, ногоон гэрчилгээжүүлэлт зэргийг улс орон бүр өөрсдийн онцлогт тохируулан гаргадаг боловч эдгээрийн гол үндэслэл нь 1992 оны Риогийн тунхаглалаар баталсан “Ногоон дэлхий 21” хөтөлбөрийг баримталж болох юм (*Хүснэгт 50*).

Хүснэгт 50. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний эко стандартууд

Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Эко стандартын шалгуур
Эко аялал	• Аяллын хөтөлбөр нь хувилбартай байх, жуулчдын хүсэлтээр өөрчлөх боломжтой байх • Цөөн аялагчтай бүлэг, ганцаарчилсан аялагчдад чиглэгдсэн байх • Уламжлалт газруудыг заавал үз гэж тулгахгүй байх • Очих газрын мэдээллийг бүрэн өгөх • Орон нутгийн хөтөчтэй байх • Экологи, байгаль орчны шалгуур, шаардлагыг хангасан тээврийн хэрэгсэл ашиглах • Нутгийн гаралтай хүнсийг ашиглах • Хог хаягдлыг орхилгүй авч явах • Түр буудаллах зориулалтын талбайг ашиглах • ТХГН-аар соёлтой аялах ёс зүйг ухамсарлуулах

Эко буудал	• Химийн хоргүй угаалга, цэвэрлэгээний бодис ашиглах • Тамхигүй орчин бүрдүүлсэн байх • Нөхөн сэргээгдэх эрчих хүч ашиглах • Орон нутгийн органик хүнс ашиглах • Нэг удаагийн сав, баглаа, боодлоос татгалзах • Агаар цэвэрлэх системтэй байх • Саарал усыг цэвэрлэж аж ахуйдаа эргүүлэн ашиглах • Орон нутгийн чулуу хайрга, барилгын материал ашиглах
Эко гэр буудал	• Тээврийн хэрэгслийн зогсоолыг гэрээс 200 метрээс багагүй зайд байрлуулах • Авто болон шороон замаас 2 км-ээс багагүй зайд байрлуулах • Байгалийн тогтоц, түүх соёлын дурсгалт газар, үзмэрээс 2 км-ээс багагүй зайд байрлана • Голын хөвөө, булаг, нуурын эрэг, тогтоол ус, намаг, ойн захаас 100 метрээс багагүй зайд байрлуулна • Ашиглалтын талбай 1 га-аас ихгүй байх ба эдэлбэр газрын ерөнхий зурагтай байна • Гэр хоорондын зай 10 метрээс багагүй зайд байрлана • Гэрээс эргэн тойрон 300 метр газарт байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн байна • Бууриа сэлгэх сэлгээний газрыг төлөвлөсөн байна • Хогийн цэг гэрээс 60 метрээс багагүй зайд, салхины дор байрлуулахдаа газрын гадаргаас хөндийрсөн байгууламжид байрлуулна. • Бохир ус цэвэрлэх бичил байгууламжтай байх • Жорлонгийн нүх 2 метрээс багагүй гүнтэй байх • Борооны усыг цуглуулах, нөөцлөх бичил байгууламжтай байх • Жорлонгийн бохир усыг 7 хоногт нэг удаа задлагч бодисоор ариутгана • Зуны улиралд ашиглах хатаасан био түлшийг нөөцөлсөн байна
Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал	• Байр, сууц, хоол, тойрон аяллын үйлчилгээ • Ажил үйлчилгээний мониторинг • Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх • Ажил үйлчилгээний борлуулалт, сурталчилгаа • Засаг захиргаа, төсөл хэрэгжүүлэгчидтэй биологийн төрөл зүйл, байгаль хамгаалах ажлыг хамтран хийж гүйцэтгэх • Аяллын бүтээгдэхүүн төлөвлөх, хөгжүүлэх

Эх сурвалж: Green globe 21 хөтөлбөр

Энэхүү стандарт нь ТХГН-ийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, байр сууцны ажил үйлчилгээг эмх цэгцтэй болгоход чиглүүлэх үйл ажиллагааны үндсэн шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийн баримт бичгийг нийтээр даган хэрэглэхээр зөвшилцлийн үндсэн дээр боловсруулах нь зүйтэй юм. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллага, хувь хүн, малчин иргэн, нөхөрлөлийн зах зээлд нийлүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээ нь хэрэглэгчийн эрх ашигт харшлах, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүн эсвэл хуурамч бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхээс урьдчилан сэргийлэх бодлогын хамгийн анхан шатны арга хэрэгсэл бол стандарт юм.

3.3.5. Цаашид хэрэгжүүлэх боломжтой, санал болгож буй аяллын хөтөлбөр, маршрут

Аялал жуулчлал нь олон улсын гадаад харилцаанд тэргүүлэх байр суурийг эзэлж, дэлхийн аж ахуйн салбаруудаас хамгийн хурдацтай мөн орлоготой хөгжиж байгаа

салбарын нэг гэдгийг олон баримт нотолж байна. Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын 2020 оны мэдээнд газрын тос, химийн инженерчлэлийн дараа 3-р байранд аялал жуулчлал бичигдэж байна. 2021 онд хэдийгээр цар тахлын улмаас аялал жуулчлалын салбар уналтад орсон ч улс орнууд хилээ нээснээр эргэн хамгийн хурдан сэргэх салбарт тооцогдсон.

Байгаль орчны доройтол, дэлхийн дулааралтай холбоотойгоор байгалийн нөөцийг ашиглах шинэ арга зам нь дэлхий даяар экологийн жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх асуудал гэж үзэж байна. Олон улсын жуулчлалын нийт орлогод эко жуулчлалын орлогын хэмжээ 10 хувийг эзэлж байна гэсэн баримт бий [М.Билэгсайхан, 2010]. Экологийн жуулчлал нь орон нутгийн байгаль, соёлд нөлөөгүй, жуулчлалын олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн төрөл бөгөөд экологийн хандлагатай, суурь зарчимтай, эдийн засгийн чадамжтай, нутгийн зон олны ёс зүй, нийгмийн жуулчлал юм.

Их газрын чулууны байгалийн цогцолборт газар нь тал нутгийн эмзэг экосистемтэй, байгалийн өвөрмөц тогтоцтой, соёлын өв уламжлалыг хадгалсан нөөц бүхий газар учраас экологийн жуулчлалыг төлөвлөж хөгжүүлэх нь зохистой юм. Иймээс авто аяллаас гадна морин, унадаг дугуйн, явган аяллууд, нутгийн иргэдэд түшиглэсэн аяллын бүтээгдэхүүнийг бий болгох шаардлагатай.

Бид энэхүү шаардлагын дагуу Их Газрын БЦГ-аар аялах үндсэн 6 төрлийн маршрутыг хийж, зураглал үйлдэв.

Маршрут 1. Явган аяллын замнал (Хүснэгт 51, Зураг 28)

Хүснэгт 51. Төлөвлөж буй маршрут 1

Аяллын замын чиглэл: Лянх хад - Сэнжит хад – Хүннү булш – Тоорой бандийн агуй – Хиргисүүр – Лянх хад	
Тээврийн хэрэгсэл	Явган аялал
Нийт замын урт	6.2 км
Амрах цэг -1	Тоорой бандийн агуй

Маршрут 2. Авто машинтай аяллын замнал-1 (Хүснэгт 52, Зураг 29)

Хүснэгт 52. Төлөвлөж буй маршрут 2

Аяллын замын чиглэл: Задгай театр – Наваан мааранбын хийдийн туурь - Хадны бичээс – Норовбанзад дуучны гэрэлт хөшөө – Хайлсангийн ам – Хур харцагын таг – Эхийн умай агуй – Ус хад – Ихрийн агуй - Лянх хад	
Тээврийн хэрэгсэл	Авто машинтай аялал
Нийт замын урт	20 км
Амрах цэг -1	Хайлсангийн ам
Амрах цэг -2	Лянх хад

Маршрут 3. Авто машинтай аяллын замнал-2 (Хүснэгт 53, Зураг 30)

Хүснэгт 53. Төлөвлөж буй маршрут 3

Аяллын замын чиглэл: 25-р багана- Хөх овоо – Хиргисүүр – Лянх хад – Байгаль хамгаалагчийн байр, мэдээллийн төв – Сэнжид хад - Ихрийн агуй – Энергийн хад – Уст хад - Эхийн умай агуй – Өвгөн хад – Тоонот агуй – Гэрэлт хөшөө – Задгай театр – Адууны хашаа – Хийдийн туурь – Ханан хадны зэл чулуу – Эрэн булаг – Цагаан чулуун булш – Буган хөшөө – Тал булаг – 25-р багана	
Тээврийн хэрэгсэл	Авто машинтай аялал
Нийт замын урт	92.5 км

Маршрут 4. Авто машинтай аяллын замнал-3 (Хүснэгт 54, Зураг 31)

Хүснэгт 54. Төлөвлөж буй маршрут 4

Аяллын замын чиглэл: Гурвансайхан сум – Их хар хад – Нүхтийн агуй – Заан хад – Тангад бичээст хад – Дунд сайханы булаг – Нямбан хиргисүүр – Гурвансайхан сум	
Тээврийн хэрэгсэл	Авто машинтай аялал
Нийт замын урт	88.9 км

Маршрут 5. Морин ба дугуйн аяллын замнал (Хүснэгт 55, Зураг 32)

Хүснэгт 55. Төлөвлөж буй маршрут 5

Аяллын замын чиглэл: Бурхантын агуй – Хадны зураг – Адууны хашаа – Задгай театр – Норовбанзад дуучны гэрэлт хөшөө – Тоонот агуй – Хур харцагын таг – Эхийн агуй – Лянх хад	
Тээврийн хэрэгсэл	Морь, тэмээтэй аялал, спорт дугуй
Нийт замын урт	19,3 км


Маршрут 6. Морин аяллын замнал (Хүснэгт 56, Зураг 33)

Хүснэгт 56. Төлөвлөж буй маршрут 6


Аяллын замын чиглэл: Нүхтийн агуй – Заан хад – Тангад бичээст хад – Майхан уулын хиргисүүр – Дундсайхан булаг – Нүхтийн агуй	
Тээврийн хэрэгсэл	Морин аялал
Нийт замын урт	42.6 км

Их Газрын Чулууны БЦГ-ын нутаг дэвсгэр дэх хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл маш хүчтэй болон хүчтэй үзүүлэлттэй байгаа ба эдгээр нь газар нутгийн 40 гаруй хувийг эзэлж байна. Энэ нь байгаль хамгаалах үйл ажиллагааг дэмжсэн, экологийн үзэл баримтлалтай байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх шаардлагыг бий болгосон. Байгалийн өвөрмөц тогтцууд, түүх, соёлын дурсгалыг танин мэдэх, нутгийн иргэдийн оролцоотой аялал жуулчлал нь өөрөө тогтвортой хөгжлийн үзэл санааг агуулж байдаг. Иймээс морин, явган болон унадаг дугуйн аяллуудыг зохион байгуулалттайгаар хөгжүүлэх нь чухал юм.


Аяллын олон зам, жимийг багасгах, хөрсийг нөхөн сэргээх, санал болгож буй аяллын замналуудыг батлуулж, мөрдүүлэх зэргээр байгалийн аялал жуулчлалыг дэмжин ажиллах хэрэгтэй. Түүнчлэн байгаль хамгаалагчдын тоог нэмэгдүүлэх, идэвхтэй байгаль хамгаалагчдад аялал жуулчлалын мэдлэг олгох замаар нутгийн эко аяллыг хөгжүүлэх бодлого баримталж болно.




Зураг 27. Төлөвлөж буй явган аяллын маршрутын зураг




Зураг 28. Төлөвлөж буй авто машинтай аяллын маршрут -1



Зураг 29. Төлөвлөж буй авто машинтай аяллын маршрут -2



Зураг 30.Төлөвлөж буй авто машинтай аяллын маршрут -3



Зураг 32. Төлөвлөж буй морин аяллын маршрут

Түүнчлэн Их Газрын Чулууны БЦГ-ын хэмжээнд байх аялал жуулчлалын үзмэрүүдийн нэр, байрлах газрын нэр, байршлын солбицлыг тодорхойлж, нэгтгэв (Хүснэгт 57).


Хүснэгт 57. Аяллын газрын зурагт тусгагдсан үзмэрийн тэмдэглээ, солбицол

№	Үзмэрийн нэр	ХӨ-ийн хэмжээс	ЗУ-ын хэмжээс	Үзмэрийн төрөл
1	Хөх овоо	45° 47' 45,000" N	107° 8' 49,000" E	Овоо
2	Задгай театр	45° 43' 56,465" N	107° 14' 59,475" E	Байгалийн тогтоц
3	Тоонот агуй	45° 44' 6,000" N	107° 13' 8,430" E	Байгалийн тогтоц
4	Эхийн умайн агуй	45° 44' 46,000" N	107° 13' 31,000" E	Агуй
5	Уст хад	45° 44' 47,000" N	107° 13' 51,000" E	Байгалийн тогтоц
6	Ихрийн агуй	45° 45' 33,000" N	107° 13' 48,000" E	Агуй
7	Энергийн хад	45° 45' 25,000" N	107° 14' 28,000" E	Агуй
8	Бурхантын агуй	45° 45' 25,000" N	107° 14' 28,000" E	Агуй
9	Хайлсангийн ам	45° 44' 10,000" N	107° 11' 38,000" E	Байгалийн тогтоц
10	Их хар хад	45° 31' 39,000" N	107° 5' 56,000" E	Байгалийн тогтоц
11	Жоншны ам	45° 29' 15,000" N	107° 17' 3,000" E	Байгалийн тогтоц
12	Нүхтийн ам	45° 29' 16,000" N	107° 17' 22,000" E	Байгалийн тогтоц
13	Нүхтийн амны агуй	45° 29' 22,000" N	107° 17' 20,000" E	Агуй
14	Заан хад харах цэг	45° 26' 19,000" N	107° 18' 29,000" E	Харах цэг
15	Дундсайханы булаг	45° 19' 13,000" N	107° 18' 0,000" E	Булаг
16	Тал булаг	45° 43' 50,000" N	106° 57' 13,000" E	Булаг
17	Эрээн булаг	45° 40' 56,000" N	107° 6' 38,000" E	Булаг
18	Адууны хашаа	45° 44' 14,000" N	107° 16' 4,000" E	Байгалийн тогтоц
19	Тоорой бандийн агуй	45° 46' 23,000" N	107° 13' 9,000" E	Агуй
20	Сэнжид хад	45° 46' 8,000" N	107° 14' 23,000" E	Байгалийн тогтоц
21	Өвгөн хад	45° 44' 22,900" N	107° 13' 17,400" E	Байгалийн тогтоц
22	Лянх хад	45° 46' 46,800" N	107° 14' 47,600" E	Байгалийн тогтоц
23	Өнөрбаянхайрхан	45° 44' 54,700" N	107° 14' 55,200" E	Байгалийн тогтоц
24	Жуулчны бааз	45° 44' 8,222" N	107° 13' 4,807" E	Жуулчны бааз
25	Жуулчны бааз	45° 45' 41,052" N	107° 15' 57,050" E	Жуулчны бааз
26	Хиргисүүр	45° 47' 26,000" N	107° 12' 0,000" E	Булш хиргисүүр
27	Хиргисүүр	45° 46' 27,000" N	107° 14' 23,000" E	Булш хиргисүүр
28	Гэрэлт хөшөө	45° 43' 30,243" N	107° 13' 25,726" E	Хөшөө
29	Хур харцага хөшөө	45° 44' 43,000" N	107° 12' 54,000" E	Хөшөө
30	Хийдийн туурь	45° 50' 12,000" N	107° 11' 47,000" E	Туурь
31	Тангад бичээст хад	45° 26' 17,000" N	107° 18' 18,000" E	Хадны зураг
32	Дөрвөлжин булш, хөшөө	45° 25' 29,000" N	107° 15' 56,000" E	Булш хиргисүүр
33	Бөөн хайлаас хиргисүүр	45° 24' 24,000" N	107° 21' 2,000" E	Булш хиргисүүр
34	Нарийны арын хиргисүүр	45° 24' 25,000" N	107° 21' 4,000" E	Булш хиргисүүр
35	Майхан уулын хиргисүүр	45° 20' 46,000" N	107° 19' 13,000" E	Булш хиргисүүр
36	Баруунсайханы хиргисүүр	45° 19' 1,000" N	107° 17' 22,000" E	Булш хиргисүүр
37	Нямбан хиргисүүр	45° 22' 54,000" N	107° 15' 30,000" E	Булш хиргисүүр
38	Булш, буган хөшөө	45° 43' 28,000" N	106° 58' 12,000" E	Булш хиргисүүр
39	Цагаан чулуун булш	45° 41' 4,000" N	106° 57' 42,000" E	Булш хиргисүүр


40	Ханан хадны зэл чулуу	45° 42' 14,000" N	107° 14' 26,000" E	Булш хиргисүүр
41	Хийдийн туурь	45° 42' 15,000" N	107° 14' 42,000" E	Туурь
42	Хадны зураг	45° 45' 7,000" N	107° 16' 22,000" E	Хадны зураг
43	Хадны бичээс	45° 43' 20,000" N	107° 13' 31,000" E	Хадны зураг
44	Хүннү булш	45° 46' 17,000" N	107° 13' 14,000" E	Булш хиргисүүр
45	Хилийн цэг	45° 47' 22,000" N	106° 57' 27,000" E	ТХГН-ийн хилийн багана
46	Танилцуулга самбар	45° 47' 37,000" N	107° 10' 14,000" E	ТХГН-ийн хилийн багана
47	БХ байр	45° 46' 2,000" N	107° 15' 11,000" E	Байгаль хамгаалагчийн байр
48	Машин зогсоол	45° 43' 53,000" N	107° 14' 57,000" E	Авто зогсоол
49	Гурвансайханы хаалга	45° 43' 40,000" N	107° 12' 51,000" E	ТХГН-ийн хилийн багана
50	Говь-Угтаалын хаалга	45° 46' 44,000" N	107° 15' 30,000" E	ТХГН-ийн хилийн багана
51	15-р багана	45° 18' 59,000" N	107° 15' 54,000" E	ТХГН-ийн хилийн багана
52	Өлзийтийн самбар	45° 26' 8,000" N	107° 12' 44,000" E	ТХГН-ийн хилийн багана
53	25-р багана	45° 48' 4,000" N	106° 57' 17,000" E	ТХГН-ийн хилийн багана
54	Замналын эхлэл	45° 48' 4,000" N	106° 57' 19,000" E	ТХГН-ийн хилийн багана
55	Отоглох цэг	45° 43' 54,130" N	107° 14' 56,535" E	Отоглох цэг
56	Нийтийн бие засах	45° 43' 52,578" N	107° 14' 58,758" E	Нийтийн бие засах
57	Нийтийн бие засах	45° 43' 51,957" N	107° 14' 56,545" E	Нийтийн бие засах
58	Нийтийн бие засах	45° 45' 59,552" N	107° 15' 11,756" E	Нийтийн бие засах

Дээрх үзмэрүүдийн зургийг 4 төрлөөр гаргасан. Үүнд:


1. Их Газрын Чулууны БЦГ-ын аялал жуулчлалын нийт үзмэрүүд (Зураг 34)
2. “Аялал жуулчлалын I бүс”-эд байрлах үзмэрүүд (Зураг 35)
3. “Аялал жуулчлалын II бүс”-эд байрлах үзмэрүүд (Зураг 36)
4. “Аялал жуулчлалын III бүс”-эд байрлах үзмэрүүд (Зураг 37)



Зураг 33. Их Газрын Чулууны БЦГ-ын аялал жуулчлалын үзмэрүүд



Зураг 35. Их Газрын Чулууны БЦГ-ын “Аялал жуулчлалын II бүс”-д орших аялал жуулчлалын үзмэрүүд



**Зураг 36. Их Газрын Чулууны БЦГ-ын “Аялал жуулчлалын III бүс”-д орших
аялал жуулчлалын үзмэрүүд**

3.3.6. Их Газрын Чулууны БЦГ-т аялал жуулчлалыг түүний нөөц, даацад тохируулан хөгжүүлэхэд анхаарах зүйлс

Олон улсын аялал жуулчлал нь улирлын шинж чанараа хадгалсаар байгаа нь хөгжлийг хязгаарлах хүчин зүйл болсоор байна. Гэтэл олон улсын аялал жуулчлалын зэрэгцээ дотоодын амрагчид орон нутгийн чанартай амралт, аялал жуулчлал хүрээгээ тэлж байгаа нь байгалийн рекреаци, түүний орон зайн төлөвлөлт, зохион байгуулалтыг “ирээдүй үеийнхний хэрэгцээнд тохирсон тэдэнд хор учруулахгүй бөгөөд одоогийн хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгох бодит шаардлага нөхцөлдүүлж байна.

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын шинжээчид тухайн орны гадаадад гарсан, гадаадаас ирж байгаа болон дотоодод аялж байгаа жуулчдын тооны харьцаа 1:1:4 байвал зохистой үзэгдэл гэж үздэг. Их газрын чулууны байгалийн цогцолборт газарт ирж байгаа аялагчдын тоог харахад ямагт дотоодын аялагчид нь илүү байхын зэрэгцээ жил ирэх тусам өсөж байна. Энэ нь цаашид дотоодын аяллын томоохон зорин очих газар болох боломжтой байгааг илтгэж байна.

Амралт, аялал жуулчлалын орон зай тэлэх нь нэг талын таатай үзүүлэлт хэдий ч орон зайн бүтэц, оновчтой зохион байгуулалт нь түүнээс илүү ач холбогдолтой асуудал болно. Газар нутгийн амралт аялал жуулчлалын орон зайн зохион байгуулалтыг боловсронгуй болгохын тулд

1. Эрэлт, нийлүүлэлт
2. Рекреацийн үйлчилгээний менежмент
3. Байгалийн нөөц, экологийн менежмент
4. Маркетингийн менежмент
5. Газар зохион байгуулалт

зэрэг асуудлуудыг нэгдмэл байдлаар авч үзэх бодит шаардлага урган гарч байна.

Өнөөдрийн байдлаар бүс нутгийн аж ахуйн чиг үүргийн нэг хэлбэр нь байгалийн аялал-рекреаци болоод байна. Цаашид ч өргөжих хандлагатай байгаа бөгөөд аж ахуй энэ үйл ажиллагааны гол зорилго нь дотоодын хүн амын таатай аж төрөх, бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах, экологийн аюулгүй орчныг бүрдүүлэх, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалахад оршино. Байгалийн аялал-рекреацийн хөгжлийн түвшин нь суурьшил, бүсийн нийгэм-эдийн засгийн нөхцөл, газар зүйн байршил, физик газар зүй, байгалийн болон рекреацийн нөхцөл, нөөцөөр тодорхойлогдож байдаг.

Амралт, аялал жуулчлалын бизнес эрхлэгчид ихэвчлэн санхүүгийн хязгаартай нөөц, өөрийн туршлага чадварт тулгуурлан газар зүйн нөхцөл, нөөцийн тухай асуудлыг үл харгалзан ерөнхий төлөвлөлтгүй ажиллавал аюул үзүүлэх юм. Үүнээс сэргийлэхийн тулд:

- Нэг нэгнээ давтаагүй тодорхой үйл ажиллагааны чиглэл бүхий онцлогтой жуулчны бааз, амралтын газруудын хамтын ажиллагаа. Одоогоор төлөвлөөд байгаа 7 жуулчны баазууд бие биеэсээ ялгарах онцлогтой аяллын бүтээгдэхүүнийг төлөвлөж, үйлчилгээ үзүүлэх. Жишээ нь: нэг бааз нь цагаан идээний боловсруулалтыг амрагчдад үзүүлж, нутгийн брэнд бүтээгдэхүүний худалдаа эрхэлдэг байхад нөгөө бааз нь морин аялал явуулдаг байх гэх мэт
- Орон зайн хуваарилалт нь рекреацийн хөгжлийг удирдах сонгодог арга бөгөөд бичил бүсүүдийн оройн зайд аялал-рекреацийн бүтээгдэхүүнийг төвлөрүүлэх эсвэл сарниулах стратегийн сонголт хийх
- Рекреацийн нөхцөлийн үр дүнд тулгуурлан бичил бүсүүдийн рекреацийн дэд бүтцийг оновчтой байрлуулах, байгаа нөөцөө зах зээлийн эргэлтэд оруулж давуу тал болгох боломжийг бүрдүүлэх
- Хамгаалалтын захиргаа нь аялал жуулчлалын бизнест бодлогын чанартай хамтрагчаар оролцож, хөгжлийн үйл явцыг хянах

3.3.7. Рекреацийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах талаар өгөх зөвлөмж

Их Газрын Чулууны БЦГ-ын аялал жуулчлалын нөөц, даацыг тогтоосон дээрх судалгааг үндэслэн цаашид үйл ажиллагаандаа баримтлах дараах зөвлөмжийг санал болгож байна.

1. Аймаг, сумын засаг даргын тамгын газарт

- Аймгийн аялал жуулчлалын бодлого, төлөвлөлттэй уялдуулан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ
- Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны санал зөвлөмжийн дагуу аялал жуулчлалын аливаа үйл ажиллагааг дэмжинэ
- Бүс нутгийн аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөхүйц, аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах хэлбэрээр байгуулах ажлыг дэмжинэ
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрт аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд, нутгийн иргэдийг хамруулахыг дэмжиж ажиллана
- Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний байгууллагуудын ажил үйлчилгээг хууль дүрэм журам, стандартын дагуу явуулж хэвшүүлэх, үйлчилгээний соёл хэвшүүлэхэд Орон нутгийн удирдлагын харьяа газар, албатуудын хүч нөөцийг зөв дайчилж оролцуулж иргэд, аж ахуйн нэгжийг дэмжихдээ зөвлөж сургах, чиглүүлэх замаар ажиллана

2. Хамгаалалтын захиргаанд

- Их ашиглагдсан нөөцүүдийн хэрэглээг хязгаарлах, тэдгээрт шууд болон шууд бусаар нөлөөлөх нөлөөллийг багасгах
- Их ачааллын үед хоногт ирэх жуулчдын тоог даацын дагуу хязгаарлах
- Хүний үйл ажиллагааны нөлөөллийг бууруулахын тулд олон салаа авто замыг хаах, нөхөн сэргээхэд мэргэжлийн байгууллагын санал зөвлөмжийг тусгах
- Байгаль хамгаалах үйл ажиллагаанд олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрүүдийг татах
- Байгаль хамгаалагчдын тоог нэмэгдүүлэх, үүрэг хариуцлагыг тодорхой болгох
- Байгаль орчныг хамгаалах байгууллагатай зөвлөлдөх, байгальд ээлтэй үйл ажиллагааны хэрэгжилтэд хариуцлагатай хандах
- Амрагч, аялагчдын тогтмол хугацаанд судалгаа авч, үр дүнг үйл ажиллагаандаа тусгадаг байх
- Энэхүү бодлогын бичиг баримтад тусгагдсан эко аяллын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- Нутгийн иргэдэд аялал жуулчлалын мэдлэг олгох сургалт, зөвлөгөө зохион байгуулах
- Уламжлалт мал аж ахуй, газар тариалан, уул уурхайгаас нутаг дэвсгэрийг хамгаалах
- ТХГН-ийн аялал жуулчлал болон онцгой бүсэд төрөл бүрийн суурьшлыг төлөвлөхгүй байх

3. Нутгийн иргэдэд

- Хамгаалалтын захиргааны ажилчид, байгаль хамгаалагч нартай хамтран ажиллана
- Аялал жуулчлалын сургалт, зөвлөгөө авч, нөхөрлөл, эко отог хэлбэрээр болон морин, ердийн хөсөгтэй аяллыг хамгаалалтын захиргаатай хамтран хэрэгжүүлнэ

- Уламжлалт зан заншлыг хадгалсан аж ахуйг эрхэмлэнэ
- Байгалийн болон соёлын өв, нөөцөд ухаалаг хандана.

4. Эко отог

- Тээврийн хэрэгслийн зогсоолыг гэрээс 200 метрээс багагүй зайд байрлуулна.
- Шороон замаас 2 км-ээс багагүй зайд байрлана.
- Байгалийн тогтоц, түүх, соёлын дурсгалт газар, үзмэр, авто замаас 2 км-ээс багагүй зайд байрлана
- Голын хөвөө, нуурын эрэг, тогтоол ус, булаг шанд, ойн зах зэргээс 100-ээс багагүй метрийн зайд өндөрлөг, нөмөр газар байрлуулна.
- Эко гэрийн отгийн ашиглалтын талбай 1 га-аас ихгүй байх ба эдэлбэр газрын ерөнхий зурагтай байна.
- Гэр хоорондын зай 10 метрээс багагүй зайд байрлана.
- Гэрээс эргэн тойрон 300 метр газар байгаль орчинд нөлөөлөх байдлыг ерөнхий үнэлгээг хийлгэсэн байна.

5. Жуулчны базад

- Хогийн цэг гэрээс 60 метрээс багагүй зайд, салхины дор байрлана.
- Хогийн савыг хог ялган хийх тасалгаатай хийж, газрын гадаргаас хөндийрсөн байгууламжид байрлуулна
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгүүлж хэрэгжүүлэх зөвлөмжийг тусган ажиллана.
- Эко аяллын бүтээгдэхүүнийг аялагч, жуулчдад санал болгоно
- Хамгаалалтын захиргааны баталсан, санал болгосон аяллын замналаар жуулчдыг аялуулна.
- Хог хаягдал, цэвэр ба бохир ус, цахилгаан эрчим хүч, дулаан зохицуулалтыг эко шийдлээр гүйцэтгэнэ.
- Жуулчны баазууд бие биеэсээ ялгарах онцлогтой байх

6. Эвент үйл ажиллагааны зохион байгуулалтын талаар

- Наадам эвент арга хэмжээний үеэр холбогдох байгууллагатай хамтран баяр наадмын талбайд Жуулчны мэдээллийн төвийг Нүүдлийн хэлбэрээр зохион байгуулах
- Наадам эвент арга хэмжээний үеэр холбогдох байгууллагатай хамтран баяр наадмын талбайд урьдчилан зохион байгуулж шилж сонгосон гадаад хэлний мэдлэгтэй сайн дурын ажилтан залуучууд оюутнуудаар жуулчны цагдаа ажиллуулж мэдээлэл хүргэх, тусалж дэмжих, аюулгүй байдал хангах, замчлах хөтөчлөх зэргээр үйлчлүүлэх
- Баяр наадмын талбайн орчимд худалдаа үйлчилгээ эрхлэх, хоол ундааны үйлчилгээ үзүүлэхдээ ариун цэвэр, соёлжилт, хог хаягдал хаяхгүй байх менежмент, найрсаг соёлтой зочломтгой үйлчилгээг хэвшүүлэх аяныг зохион байгуулах
- Баяр наадам эвент арга хэмжээний үеэр жуулчдаас болон аяллын компаниас санал сэтгэгдлийг тусгай хуудсаар авч үйл ажиллагааны талаар статистик дүгнэлт гаргаж ажиллах

ДҮГНЭЛТ

- ❖ Их Газрын Чулууны БЦГ-ын ландшафт-газрын бүрхэвчид гарсан өөрчлөлтийг харьцуулж үзвэл (2011 ба 2020 онууд) хуурай хээрийн талбай 6.27%-иар, шал, хужир, марзын талбай 0.24%-иар тус тус багассан бол цөлжүү хээрийн талбай 2.67%-иар, хад асгын талбай 3.83%-иар тус тус нэмэгджээ. Үүнээс үзвэл тус БЦГ нь ижил төвшний бусад газар нутагтай харьцуулахад ландшафт-газрын бүрхэвчийн өөрчлөлт дунджаас доогуур буюу доройтолд харьцангуй бага өртсөн байна.
- ❖ Хүний үйл ажиллагааны нөлөөллийн нэгдсэн үнэлгээгээр Их Газрын Чулууны БЦГ-ын нийт нутаг дэвсгэрийн 5.39% нь хүний үйл ажиллагаанд маш бага өртсөн, 13.12% нь бага, 40.36% нь дунд зэрэг, 21.09% нь хүчтэй, 20.05% нь маш хүчтэй өртсөн байна. Хүний үйл ажиллагаанаас үзүүлж буй хамгийн гол сөрөг нөлөө нь замбараагүй авто зам их үүссэн, ялангуяа цогцолборт газрын урдуур явж буй уурхайн том машины гаргасан зам, түүнээс үүдсэн тоос тоосонцор юм.
- ❖ Их Газрын Чулууны БЦГ-ын хувьд хөрсний чанарын үнэлгээгээр 122.7 үнэлгээтэй гарсан ба хөрсний механик бүрэлдэхүүний эрсдэлийн үнэлгээгээр хөрсний 2.98% нь маш бага, 1.55% нь бага, 42.52% нь дунд, 52.95% нь хүчтэй нөлөөлөлд автсан байна. Тиймээс хөрсний бүрэлдэхүүний өөрчлөлтийг сааруулах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай. Газрын гадаргуугийн үнэлгээнээс харахад тус цогцолборт газрын 98.49% буюу дийлэнх газар нутаг нь аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах боломжтой болохыг харуулж байна.
- ❖ Их Газрын Чулууны БЦГ-ийн байгаль орчин, нийгэм, соёл, эдийн засагт аялал жуулчлалаас үзүүлэх нөлөөллийн үнэлгээнээс харахад тус цогцолборт газар нь нийгэм, соёлын болон улс төр-эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ харьцангуй их байгаа бол байгаль, хүрээлэн буй орчны үзүүлэх сөрөг нөлөөлөл одоогоор харьцангуй бага гарсан байна.
- ❖ Их Газрын Чулууны БЦГ-ын аялал жуулчлалын даацыг тус судалгааны ажлын хүрээнд санал болгож буй аяллын маршрутаар тооцож үзвэл аялал жуулчлалын физик буюу биет даац нь өдөрт 386 аялагч, бодит даац нь өдөрт 206 аялагч байна. Өөрөөр хэлбэл тус цогцолборт газраар нэг өдөрт хамгийн ихдээ 386 жуулчин байгаа бол байгаль орчинд нөлөөлөхгүйгээр өдөрт аялуулах бодит аялагчдын тоо 206 жуулчин байна. Цаашид Их Газрын Чулууны БЦГ-т аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ нутаг дэвсгэрийн даацад нь тохируулан, байгаль орчинд сөрөг нөлөөл багатайгаар хөгжүүлэх шаардлагатай.
- ❖ Их Газрын Чулууны БЦГ нь аялал рекреацийн тааламжийн үнэлгээгээр дундаж үзүүлэлт нь 2.1 балл байгаа бөгөөд тус нутагт аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахад “тааламжтай” юм.
- ❖ Ландшафт-рекреацийн чадавхийн нэгдсэн үнэлгээгээр тус цогцолборт газрыг сул, дунд, өндөр гэсэн 3 түвшин бүхий нутаг дэвсгэрт ангилж болох бөгөөд чадавхи өндөр бүс нутагт байгалийн болон танин мэдэхүй, судалгаа шинжилгээний аяллыг хөгжүүлэх боломжтой бол дунд үнэлгээ бүхий бүсэд түүх соёлын болон нүүдлийн соёл иргэншилтэй танилцах аяллыг хөгжүүлэх боломжтой. Аялал рекреацийн чадавхи сул бүс нутагт аялал жуулчлалын нөөц бүтээгдэхүүн болох тухайлбал агуй, булш хиргисүүр зэрэг одоо байгаа нөөцүүдийг тухайн бие даасан шинжлэх ухааны үүднээс нарийвчлан судлах шаардлагатай.
- ❖ Түүнчлэн аялал, рекреацийн нөөцийг зохистой ашиглах талаар дээр өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж, Хамгаалалтын захиргааны зүгээс гадаад, дотоодын аялагч, жуулчдаас сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авч, дүгнэж, гарсан саналуудыг үйл ажиллагаандаа тусгах, нутгийн иргэдийн аялал жуулчлалын

боловсролыг дээшлүүлэх, аялал жуулчлалд оролцох оролцоог нэмэгдүүлэх, олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрүүдэд хамрагдаж ТХГН-ийн байгаль хамгаалах үйл ажиллагаан дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгтэй юм.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Агуйн тооллого судалгаа. Их Газрын Чулууны БЦГ-ын Хамгаалалтын Захиргаа, 2018
2. Аялал жуулчлалын онол, практик, технологийн асуудал. Цуврал №5. М.Билэгсайхан, Х.Цогбадрал, С.Амаржаргал, Ц.Адъяасүрэн. 2010 он.
3. Аялал рекреацийн чадавхийн иж бүрэн үнэлгээ. Л.Баясгалан, 2010
4. Байгалийн аялал, рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтүүд. ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/200 тушаалаар батлагдсан
5. Байгалийн рекреацийн газар зүй. М.Билэгсайхан, Н.Чинбат. 2008 он. Улаанбаатар хот
6. БНМАУ-ын үндэсний Атлас. 1990
7. Газрын төлөв байдал, чанарын захиалга хянан баталгааны ажлын заавар. Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 34 тоот тушаалын IV хавсралт.
8. Дарьгангын байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын нөөц, даацын судалгаа. ТХГН-ийн Судалгааны Төв, 2018
9. Их Газрын Чулууны БЦГ-т нутагладаг айл, малын тоо, байршлын судалгаа. Их Газрын Чулууны БЦГ-ын Хамгаалалтын Захиргаа, 2018 он
10. Их Газрын Чулууны БЦГ-т уулын туургатан амьтдын тооллогын судалгаа. Их Газрын Чулууны БЦГ-ын Хамгаалалтын Захиргаа, 2020 оны 05 сар
11. Их Газрын Чулууны БЦГ-ын менежментийн төлөвлөгөө. Их Газрын Чулууны БЦГ-ын Хамгаалалтын Захиргаа, 2019
12. Их Газрын Чулууны БЦГ-ын ургамалжилтын судалгаа. П.Ариунсүрэн, Ж.Миеэгомбо, 2014
13. Монгол орны янгир ямааны популяцийн метакондрон ДНХ-ийн судалгаа. Ц.Билгүүн, З.Өнөдбаясгалан, Б.Цэрэндулам, 2020.05 сар
14. Монгол улсын үндэсний атлас. 2008
15. Рекреаци ба аялал жуулчлал. Д.Даш, Л.Баясгалан, Д.Мандах, 2005
16. Соёлын өвийг хамгаалах тухай. Монгол улсын хууль, 2014
17. ТХГН ба аялагчдын удирдлага, зохион байгуулалт, ТХГН-дын шилдэг туршлагауд. IUCN, цуврал дугаар №27, 2020
18. ТХГН-т аялал жуулчлал явуулах журам. Байгаль Орчны сайдын 2002 оны 117 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, 2002
19. ТХГН-т эко аялал жуулчлалыг хөгжүүлэх нь. Т.Пүрэвсүрэн, 2008
20. Увс нуурын ай савын дархан цаазат газруудын аялал жуулчлалын нөөц, даацын судалгаа. ТХГН-ийн Судалгааны Төв, 2018
21. Улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын нөөц, даацын судалгаа. Газар зүйн Хүрээлэн, 2011
22. Ховор ургамлын тархцын судалгааны тайлан. Их Газрын Чулууны БЦГ-ын Хамгаалалтын Захиргаа, 2018
23. Хөрсний чанарын үнэлгээний стандарт. Газарзүйн хүрээлэн, Хөрс судлалын лаборатори, 2012

Цахим холбоосууд


1. www.1212.mn
2. www.Montsame.mn
3. <https://ikon.mn/n/24r3>

Хавсралт 1. Орон нутгийн иргэдээс авсан судалгааны үр дүн


Энэхүү судалгааны зорилго нь Их Газрын Чулууны байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын нөөц, даацыг тодорхойлох явдал юм.

Тус судалгааг 2021 оны 7сарын 5-15 хооронд жуулчны ачааллын үед асуулгын буюу анкетын аргаар Их Газрын Чулууны байгалийн цогцолборт газарт хээрийн судалгаагаар явах үед авсан болно.


Асуулт 1. Таны эрхэлдэг ажил




Асуулт 2. Судалгаанд оролцогчдын нас




Асуулт 3. Судалгаанд оролцогчдын хүйс



Асуулт 4. Таны бодлоор аялал жуулчлал хөгжих нь танай орон нутгийн хөгжилд хэрхэн нөлөөлөх вэ?



Асуулт 5. ТХГН-т аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах нь байгаль орчинд сөрөг нөлөөтэй гэж та үздэг үү?



Асуулт 6. Аялал жуулчлалын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг та дараах үзүүлэлтээр үнэлнэ үү.

Нөлөөллийн зэрэг	Маш их	Их	Дунд	Бага	Маш бага	Хариултгүй
1. Агаарын бохирдол	0	0	11.8	23.5	35.3	29.4
2. Цэвэр усны бохирдол	11.8	5.9	23.5	5.9	23.5	29.4
3. Бохир ус	0	17.6	17.6	11.8	29.4	23.5
4. Хог хаягдал	29.4	29.4	29.4	11.8	0	0
5. Биологийн төрөл зүйлийн хомсдол	0	23.5	35.3	11.8	11.8	17.6
6. Хөрсний эвдрэл, газрын зохистой ашиглалт	5.9	35.3	29.4	11.8	11.8	5.9

Асуулт 7. ТХГН-т аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах нь тухайн нутгийн эдийн засагт ямар нөлөөтэй гэж та үздэг вэ?

Үзүүлэлт	Эерэг	Сөрөг	Хариултгүй
1. Орон нутгийн хөдөлмөр эрхлэлт	94.1	5.9	0
2. Орон нутгийн орлого бүрдүүлэлт	88.2	5.9	5.9
3. Иргэдийн амьжиргааны түвшин	82.4	11.8	5.9
4. Дэд бүтэц	94.1	5.9	0
5. Бараа бүтээгдэхүүний үнэ	70.6	29.4	0

Асуулт 8. Аялал жуулчлалын эдийн засагт үзүүлэх нөлөөг та дараах үзүүлэлтээр үнэлнэ үү?

Нөлөөллийн зэрэг	Маш их	Их	Дунд	Бага	Маш бага	Хариултгүй
1. Орон нутгийн хөдөлмөр эрхлэлт	11.8	35.3	29.4	17.6	5.9	0
2. Орон нутгийн орлого бүрдүүлэлт	23.5	29.4	17.6	17.6	11.8	0
3. Иргэдийн амьжиргааны түвшин	11.8	35.3	29.4	5.9	11.8	5.9
4. Дэд бүтэц	17.6	41.2	23.5	5.9	5.9	5.9
5. Бараа бүтээгдэхүүний үнэ	23.5	23.5	29.4	5.9	0	17.6

Асуулт 9. Тус ТХГН-т аялал жуулчлалын үйл ажиллагааг явуулах нь нийгэмд ямар нөлөөтэй вэ?

Үзүүлэлт	Эерэг	Сөрөг	Хариултгүй
1. Шилжих хөдөлгөөн, хүн амын төвлөрөл	64.7	35.3	5.9
2. Нүүдэлчний соёл, уламжлалт ахуй	88.2	11.8	0
3. Үндэсний бахархал	88.2	11.8	0
4. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	29.4	64.7	5.9
5. Шашны урсгал	29.4	64.7	5.9
6. Нийгмийн сөрөг үзэгдэл (биеэ үнэлэх, мансууруулах бодисын хэрэглээ гэх мэт)	17.6	76.5	5.9
7. Гаднын соёлын нөлөө	41.2	58.8	0
8. Хүүхэд, залуучууд	70.6	17.6	11.8
9. Эмэгтэйчүүд	58.8	17.6	23.5
10. Үйлчилгээний салбарын хөгжил	76.5	17.6	5.9

Асуулт 10.


Нөлөөллийн зэрэг	Маш их	Их	Дунд	Бага	Маш бага	Хариултгүй
1. Шилжих хөдөлгөөн, хүн амын төвлөрөл	11.8	23.5	23.5	23.5	11.8	5.9
2. Нүүдэлчний соёл, уламжлалт ахуй	23.5	35.3	23.5	17.6	0	0
3. Үндэсний бахархал	35.3	17.6	11.8	17.6	5.9	11.8
4. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	11.8	0	41.2	11.8	35.3	0
5. Шашны урсгал	5.9	0	35.3	17.6	35.3	5.9
6. Нийгмийн сөрөг үзэгдэл (биеэ үнэлэх, мансууруулах бодисын хэрэглээ гэх мэт)	0	5.9	17.6	23.5	47.1	5.9
7. Гаднын соёлын нөлөө	0	11.8	35.3	11.8	29.4	11.8
8. Хүүхэд, залуучууд	17.6	29.4	17.6	17.6	5.9	11.8
9. Эмэгтэйчүүд	17.6	17.6	23.5	17.6	5.9	17.6
10. Үйлчилгээний салбарын хөгжил	47.1	23.5	17.6	11.8	0	0

Хавсралт 2. Байгаль хамгаалагчдаас авсан санал асуулгын дүн


Энэхүү судалгааны зорилго нь Их Газрын Чулууны байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын нөөц, даацыг тодорхойлох явдал юм.

Тус судалгааг 2021 оны 7сарын 5-15 хооронд жуулчны ачааллын үед асуулгын буюу анкетын аргаар Их Газрын Чулууны байгалийн цогцолборт газарт хээрийн судалгаагаар явах үед авсан болно.


Асуулт 1. Судалгаанд оролцогчдын хүйс




Асуулт 2. Судалгаанд оролцогчдын боловсролын зэрэг




Асуулт 3. Судалгаанд оролцогчдын байгаль хамгаалагчаар ажилласан жил




Асуулт 7. ТХГН-т аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахыг та дэмждэг үү?




Асуулт 8. Аялал жуулчлал хөгжих нь орон нутгийн хөгжилд хэрхэн нөлөөлөх вэ?



Асуулт 9. Таны хариуцаж буй газарт аялал жуулчлалаас байгаль орчинд үзүүлж буй нөлөөг дараах үзүүлэлтээр үнэлнэ үү



Асуулт 10. Аялал жуулчлалаас үүдэн биологийн төрөл зүйлд учирч буй нөлөөг та дараах үзүүлэлтээр үнэлнэ үү.



Ан амьтны тоо толгой өсөж, хорогдож буй талаар:

- Ган зуд, биологийн насжилт зэргийн улмаас ховордож байна.
- Хүн амьтнаас нөлөөлөх нөлөө бага байх тохиолдолд өсөлт хурдан явагдана.
- Ган зуд зэрэг байгалийн гамшиг
- Араатан махчин амьтны нөлөөллөөс болж хорогдох
- Сүүлийн 3 жилд аргаль янгир жил бүр 50-иас их хувиар буурсан үзүүлэлт ажиглагдаж байна.
- Ховордож байна.


Ургамлын бүрхэвчид гарч буй өөрчлөлт:

- Ховор ургамлын гарц жил ирэх тусам муудаж байна.
- Уул уурхай, хүнд даацын тээвэрлэлтийн нөлөөлөл үүсэж байна.
- Байгалийн гамшиг, хур бороо бага орсонтой холбогдуулан газрын гадарга, хөрс гэмтэж, цөлжилт их явагдаж байна. Үүний улмаас ургамал устаж шарилж, өмхий өмс зэрэг хог ургамал их ургаж байна.
- Зам дагуух ургамлууд тоосонд дарагдаж ургах нөхцөл доройтож байна
- Ус дутагдах
- Ургамлын төрөл зүйл ховордож байна

Байгаль хамгаалах талаар хэрэгжүүлж буй хөтөлбөрийн нэр, онцлог:

- Хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулж байгаа
- Хүнд даацын тээвэрлэлтийг явуулахгүй байх талаар
- Эрүүл хяналт, шалгалтыг хамтарч хийх
- Цөлжилтөөс сэргийлж хөрсний доройтлыг бууруулах зорилгоор Салхитын мөнгөний ордтой хамтран мод тарьж ногоон зурвас байгуулна

Асуулт 11. Аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл, түүнээс үүдэн гарч буй үр дагаврыг тодорхойлно уу?




ТХГН-д аялал жуулчлалын зориулалтаар ашиглагдаж буй голлох тээврийн хэрэгслүүд, тэдгээрийн чанарын шаардлага хангаж буй эсэх:

- Газрын доройтол, ан амьтдын тархац нутаг хумигдахаас сэргийлэх хэрэгтэй
- Автомашинууд, тэдгээр нь чанарын шаардлага хангаж чадаж байна.
- Тохиромжтой

Тээврийн хэрэгслээс үүдэн ТХГН-т учирч буй бэрхшээлүүд:

- Хөрсний эвдрэл үүсэж байна
- Замын тоосжилт их үүсэж байна
- Ан амьтан дуу чимээнээс нь үргэж дайжих
- Дуу чимээ, хөрс талхагдал, ан амьтан дайжих гэх мэт бүгд үүсэж байна
- Олон салаа зам гарч, газрын хөрс эвдэгдэж, ургамлын гарц доройтох зэрэг олон бэрхшээл байна
- Олон салаа зам үүсэх, ан амьтан дайжих

Асуулт 12. ТХГН-т ирж буй жуулчдын хувьд ямар мэдээллээр дутагдаж байна гэж та үзэж байна вэ?



Хавсралт 3. Дотоодын аялагч, жуулчдаас авсан судалгааны үр дүн

Энэхүү судалгааны зорилго нь Их Газрын Чулууны байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын нөөц, даацыг тодорхойлох явдал юм.

Тус судалгааг 2021 оны 7сарын 10-15 хооронд жуулчны ачааллын үед асуулгын буюу анкетын аргаар Их Газрын Чулууны байгалийн цогцолборт газарт аялж буй 200 дотоодын аялагч жуулчдаас авсан болно.

1. Та хаанаас ирсэн бэ?

Хариулт	Улаанбаатар хот	Бусад аймгууд
Хүний тоо	117	83/Дундговь, Говьсүмбэр, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Завхан аймгууд/
Хувь	58,5	41,5

2. Та гэр бүлтэйгээ болон найз нөхөдтэйгээ жилд хичнээн удаа аялдаг вэ?

Хариулт	Огт аялдаггүй	1 удаа	2-3 удаа	4-5 удаа	6 ба түүнээс дээш
Хүний тоо	15	94	75	6	10
Хувь	7,5	47	37,5	3	5

3. Та Монгол орныхоо ямар ямар үзэсгэлэнт газруудаар аялж байсан бэ?

Хариулт	Хөвсгөл нуурын БЦГ	Говь Гурван Сайхан /Ёлын ам/	Орхоны хөндийн БЦГ /Хар хорин, Эрдэнэ хийд/	Хорго-Тэрхийн БЦГ /Хоргын тогоо, Тэрхийн цагаан нуур/	Их нартын БЦГ	Бусад
Хүний тоо	95	70	85	105	19	41
Хувь	47,5	35	42,5	52,5	9,5	20,5

4. Та Монгол орноороо аялахдаа дунджаар хэд хоног аялдаг вэ?

Хариулт	1-3 хоног	4-7 хоног	10-14 хоног	15 ба түүнээс дээш
Хүний тоо	59	99	38	4
Хувь	29,5	49,5	19	2

5. Та Монгол орноор аялахдаа хаана хоноглодог вэ?

Хариулт	Майханд	Хамаатан, найз	Жуулчны бааз	Бусад
Хүний тоо	157	5	14	24
Хувь	78,5	2,5	7	12

6. Та ИГЧБЦГ-г хэд дэх удаа ирж байна вэ?

Хариулт	Анх удаа	2-3 удаа	4-6 удаа	7 ба түүнээс дээш
Хүний тоо	131	51	4	14
Хувь	65,5	25,5	2	7

7. Энэ удаагийн таны аяллын зорилго юу вэ?

Хариулт	Амарч, зугаалах	/ Найз нөхөд, хамаатан садандаа айлчлах	Судалгаа, шинжилгээ хийх	Ажил хэргийн зорилгоор	Бусад
Хүний тоо	162	28	3	5	2
Хувь	81	14	1,5	2,5	1

8. Та хэд хоног аялахаар төлөвлөж байна вэ?

Хариулт	1-3 хоног	4-7 хоног	10-14 хоног	15 ба түүнээс дээш
Хүний тоо	127	70	2	1
Хувь	63,5	35	1	0,5

9. ИГЧБЦГ-ын талаарх мэдээллийг хаанаас авсан бэ?

Хариулт	Сонин, сэтгүүл, хэвлэл	/ Интернеттээс (фэйсбүүк, инстаграм)	Телевиз, радиогоос	Гэр бүл, найз нөхөд, хамаатан садан, хамт олноосоо	Орон нутгийн иргэдээс	ИГЧБЦГ-ын захиргаанаас	Бусад
Хүний тоо	16	37	8	123	34	3	10
Хувь	8	18,5	4	61,5	17	1,5	5

10. Та энэ удаагийн аялалыг хийхдээ дунджаар хэдэн төгрөг зарцуулсан бэ?

Хариулт	0-500000 төг	501000–1000000 төг	1000000-1500000 төг	1501000-2000000 төг	2 сая төгрөгөөс дээш
Хүний тоо	107	66	14	9	4
Хувь	53,5	33	7	4,5	2

11. ИГЧБЦГ-т аялал жуулчлалаас байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг та дараах үзүүлэлтүүдээр үнэлнэ үү. (Үзүүлэлт тус бүрт харгалзах нөлөөллийг + тэмдгээр тэмдэглэнэ)

№	Нөлөөллийн үзүүлэлтүүд		Маш их	Их	Дунд	Бага	Маш бага
1	Хог хаягдал	Хүний тоо	48	39	42	30	41
		Хувь	24	19,5	21	15	20,5
2	Усны бохирдол	Хүний тоо	14	17	38	50	81
		Хувь	7	8,5	19	25	40,5
3	Амьтан үргэх, ургамал сүйдэх	Хүний тоо	20	18	35	61	66
		Хувь	10	9	17,5	30,5	33
4	Хөрсний эвдрэл, элэгдэл	Хүний тоо	23	21	53	50	53
		Хувь	11,5	10,5	26,5	25	26,5
5	Агаарын бохирдол	Хүний тоо	9	10	22	46	113
		Хувь	4,5	5	11	23	56,5

12. Энэ байгалийн цогцолборт газраар аялахад танд юу хамгийн их таалагдсан бэ?

Хүний тоо	Байгаль орчин	Үйлчилгээ (бие засах газар, тэмдэг тэмдэглэгээ)	Нутгийн иргэд (ахуй амьдрал, зан харилцаа)	Байгаль хамгаалагч (ажил үүргээ гүйцэтгэж буй байдал, зан харилцаа)
Хувь	168	13	5	14
Хүний тоо	84	6,5	2,5	7

13. ИГЧБЦГ-аар аялахдаа та ямар үзмэрүүдтэй танилцсан бэ?

№	Үзмэрүүд	Үзэж танилцсан байдал		
		Хүний тоо	Хувь	Эзлэх байр

1.	Лянх хад	63	31,5	ҮШ
2.	Нүхтийн агуй	40	20	XI
3.	Задгай театр	140	70	I
4.	Гэрэлт хөшөө	100	50	II
5.	Тоонотын агуй	87	43,5	Y
6.	Хур харцагын таг	57	28,5	IX
7.	Эхийн умай агуй	45	22,5	X
8.	Өвгөн хад	88	44	IY
9.	Түрэгийн тахилын онгон	10	5	XYII
10.	Уст хад	89	44,5	III
11.	Ихэрийн агуй	71	35,5	YII
12.	Бурхантын агуй	78	39	YI
13.	Хүннүгийн булш-18	18	9	XIY
14.	Эртний булш хиргисүүр-21	21	10,5	XII
15.	Дөрвөлжин булш-18	18	9	XIY
16.	Зэл чулуу-16	16	8	XY
17.	Хадны зураг-20	20	10	XIII
18.	Шоргоолжин булш-13	13	6,5	XYI

14. Та нутгийн иргэдээс санал болгож буй дараах бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахад бэлэн үү?

Хариулт	Сүү, цагаан идээ	Гар урлалын зүйлс	Морь, тэмээ унах	Нутгийн иргэдийн гэрт хоноглох	Хоолны үйлчилгээ	Жуулчны баазын үйлчилгээ
Хүний тоо	122	45	45	13	62	53
Хувь	61	22,5	22,5	6,5	31	26

15. Таны энэ байгалийн цогцолборт газраар аялах явцад төрсөн сэтгэл ханамжийн байдал?

Хариулт	Маш сайхан	Сайхан	Дунд	Таагүй	Маш таагүй
Хүний тоо	94	89	17	0	0
Хувь	47	44,5	8,5	0	0

16. Энэхүү ер бусын тогтоцтой, Монголын үзэсгэлэнт газар таалагдсан бол та тус газрыг цэвэрлэх, хамгаалахад зориулж хураамж болгон хэдэн төгрөг төлөхөд бэлэн байна вэ?

Хариулт	300 төг	500 төг	800 төг	1000 төг	1000-аас дээш төг
Хүний тоо	30	30	2	85	53
Хувь	15	15	1	42,5	26,5

17. Тус байгалийн цогцолборт газарт аялал жуулчлалыг хөгжүүлэхэд ямар ажлуудыг цаашид хийх шаардлагатай гэж та үзэж байна вэ?

- ✓ Үзмэр болгоны ойролцоо хогийн цэг, хогийн сав байрлуулах
- ✓ Замын тэмдэг, тэмдэглэгээ хаяг явах чиглэл заах самбар байрлуулах
- ✓ Гарын авлага, танилцуулга
- ✓ Хүүхэд тоглуулах газар, спортын талбай
- ✓ Ундын ус, худаг
- ✓ Хоолны газар, хүнсний дэлгүүр
- ✓ Тог цахилгаан, интернет
- ✓ Энэ газрыг хашиж хамгаалах

- ✓ Жуулчны бааз, үйлчилгээний цогцолбор барих
- ✓ Хоолны газар
- ✓ Хөтөч тайлбарлагч
- ✓ Бие засах газар
- ✓ Эмийн ургамал болон гар урлалын зүйлс худалдаалах
- ✓ Дэд бүтцийг сайжруулах
- ✓ Ан амьтдыг өсгөн үржүүлэх, хамгаалах
- ✓ Амрах сандал, сүүдрэвч
- ✓ Аяллын маршрут бүхий газрын зураг гаргах
- ✓ Нутгийн брэндийг бий болгох, орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах
- ✓ Зам засах
- ✓ Хиймэл нуур байгуулах, тохижуулах мод тарих
- ✓ Буудаллах газрыг үзмэрээс зайтай байгуулах
- ✓ Мэдээлэл сурталчилгааг сайн хийх

18. Энэ сайхан газраар аялж үзэхийг та бусдад санал болгох уу?

Хариулт	Тийм	Үгүй	Мэдэхгүй
Хүний тоо	196	0	4
Хувь	98	0	2